


ТАЙЛАН 2021/2022



Хараат бус

Чанар

Үр нөлөө

IRIM судалгааны хүрээлэн



1503 тоот, Pro ONE барилга, Ногоон нуурын гудамж
11-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



46A/265 Улаанбаатар, Монгол



www.irim.mn



IRIMongolia



[irim_mongolia](https://twitter.com/irim_mongolia)



[irim_mongolia](https://www.instagram.com/irim_mongolia)



+976-7011-7101



contact@irim.mn

ISBN 978-9919-26-798-8

АГУУЛГА

1	Бидний үзүүлдэг үйлчилгээ.....	3
2	Өмнөх үг.....	4
3	Бидний тухай.....	5
4	IRIM тоогоор.....	6
5	2020 оны онцлох үйл явдлын товчоо.....	7
6	2020 онцлох мэдээ.....	8
7	IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд.....	12
	1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2021.....	13
	Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн талаарх байр суурь.....	18
	2. Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа: Эмч, эмнэлгийн байгууллагад ажиллагсдын сайн сайхан байдал.....	20
	3. COVID-19 цар тахлаас үүдэн хүнс, тэжээлийн дутагдалд орсон эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх төсөл-2.....	24
	4. Ид шидийн орон 2 төвийн үйл ажиллагааны хүрээнд хийсэн суурь судалгаа.....	27
8	Хэрэгжүүлсэн төслүүд.....	31
	5. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн Амьжиргааг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн “Нийгэм-эдийн засгийн суурь судалгаа”.....	32
	6. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн Байгаль орчны харилцааны бүрэлдэхүүн хэсгийн “Мэдлэг, хандлага, туршлагын судалгаа”.....	36
	7. Монгол Улсад Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл.....	40
	8. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл: “Хувийн Хэвшил болон Их, Дээд сургуулиудын Хамтын Ажиллагааг Бэхжүүлэх” туршилтын төсөл.....	44
	9. Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ.....	47
	10. Хөдөө аж ахуйн даатгалаар дамжуулан уур амьсгалд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх нь (KlimALEZ).....	50
	11. Төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, түүний 2016-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ.....	53
	12. “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийн үр дүнгийн эцсийн үнэлгээ.....	57
	13. Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Монгол дахь уул уурхай, усны менежментийн төслийн талаар олон нийтийн ойлголт, хандлагын эцсийн шатны судалгаа.....	61
	14. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилтийг сайжруулах судалгаа.....	64
	15. “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд төв төсөл”-ийн эцсийн шатны судалгаа.....	67
	16. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа.....	72
	17. “Шийдэлд чиглэсэн судалгааны лаборатори” төсөл.....	77
	18. Зорилтот бүлгийн иргэдийн цахим мэдлэг, ур чадварыг үнэлэх чанарын судалгаа.....	81
	19. Үндэсний хэмжээний хэлэлцүүлэг.....	84

20. Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа.....	86
21. Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа.....	91
22. Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй цахим хүчирхийллийн талаарх судалгаа	96
23. “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ) 2017-2022”-ын үнэлгээ	99
24. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн “Leaders Advancing Democracy (LEAD) Mongolia” хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ.....	102
25. Ухаалаг гар утасны аудио мэдээлэл цуглуулах төсөл	106
26. Монголчуудын амьдралын хэв маяг болон соёлын судалгаа: I-III	109
27. НЗДТГ-н албан хаагчид болон нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн ажилчдад зориулсан “Судалгааны арга зүйн сургалт зохион байгуулах, судалгааны гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ	112
28. Монгол Улсын Хөгжлийн сорилтуудыг хэлэлцэх үндэсний форум.....	115
29. “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт төсөл”-ийн чанарын судалгаа.....	118
30. Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн суурь судалгаа.....	122

9

Хэрэгжиж буй төслүүд	
31. “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгаа	127
32. Олон нийтийн санал бодлын судалгаа.....	130
33. “COVID-19 цар тахлын үеийн Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих нь” техникийн туслалцааны төсөл	132
34. “Хамтдаа уншицгаая” төслийн суурь судалгаа.....	136
35. Үр дүнд суурилсан удирдлага болон үнэлгээний соёлд хувь нэмэр оруулах нь.....	138
36. Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн КОВИД-19 цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээнд үнэлгээ хийх төсөл.....	141

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа зөвлөх үйлчилгээ хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

ТУРШЛАГА:

СУДАЛГАА - Бид мэргэжлийн, шинжлэх ухаанч арга зүйгээр олон салбар хамарсан судалгааны ажлын туршлагатай. Тоон ба чанарын аргыг ашиглан шинэлэг, салбар хоорондын судалгааны төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Судалгааны мэдээллийн найдвартай байдалд чанарын хяналт тавьж, үр дүнг сүүлийн үеийн судалгааны мэдээлэл боловсруулах программ дээр гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийн үр дүнг боловсруулж байна.

131
ТӨСӨЛ

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ - Хяналт, үнэлгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж буй ажлын гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Бид Засгийн газар болон Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдэд хараат бус, хөндлөнгийн шинжилгээ хийж, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу баримт нотолгоонд суурилсан дүгнэлт гаргахыг эрмэлздэг.

96
ТӨСӨЛ

Манай байгууллага нь Монголын Үнэлгээний Сүлжээг санаачлагчдын нэг бөгөөд гишүүдийн хамтаар Үндэсний Үнэлгээний стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ - Бид сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахдаа олон төрлийн аргачлал, арга зүйг ашиглахаас гадна өөрсдийн туршлагаараа байнга баяжуулж, шинэчилдэг. Сургалтууд нь төсвийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, байгууллагын чадавхийг бэхжүүлэх зэрэг олон сэдвийг хамардаг. Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа оролцооны, интерактив аргачлал ашигладаг ба зохион байгуулалт, оролцогчдын хэрэгцээний үнэлгээ, сургалтын материал, модулийн боловсруулалт, баримтжуулалт (зураг, тэмдэглэл гэх мэт) болон сургалт бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж цаашид сайжруулах боломж, үр дүнг үнэлдэг.

23
ТӨСӨЛ

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ - Манай байгууллагын хэрэгжүүлдэг төслүүд судалгаагаар хязгаарлагддаггүй. Бид бодлогын түвшний шийдвэр гаргагчдад нөлөөлөх төрөл бүрийн арга зүйн зөвлөх үйлчилгээ болон нөлөөллийн төслүүд төлөвлөн, хэрэгжүүлдэг. Үүнд:

29
ТӨСӨЛ

- Хөгжлийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, арга зүй, санал зөвлөмж дэвшүүлэх;
- Байгууллагын дотоод гадаад орчны шинжилгээ хийх, чадавхжуулах стратеги боловсруулах зэрэг үйлчилгээнүүд үзүүлдэг.



Онц бөгөөд бүрэн эрхт элчин
сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал
Л.Цэлмэгсайхан

Дэлхий даяар цар тахлаас сэргийлж, түүнтэй тэмцэж, дасан зохицож, даван туулж буй түүхэн цаг үед нийгмийн бүхий л салбарт хүчтэй өөрчлөлт, шинэчлэл явагдсан их өрнөлтэй ахин нэг жилийг бид ардаа өнгөрөөлөө. Энэ хугацаанд IRIM судалгааны хүрээлэн үйл ажиллагаагаа тасалдалгүй явуулж өнгөрсөн онд нийт 44 судалгааг амжилттай гүйцэтгэж, төр, төрийн бус, олон улсын хөгжлийн байгууллагуудыг нотолгоонд суурилан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллажээ.

Энэ дунд бид сүүлийн 5 жил тасралтгүй өөрсдийн санаачилгаар гүйцэтгэж буй “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-гаар цар тахлын үед хамгийн хүнд бэрх нөхцөлийг даван туулсан эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын сайн сайхан байдлыг онцлон судаллаа. Уг судалгаа нь цар тахлын үед Монгол Улсын эрүүл мэндийн салбарын ажилтнуудын нөхцөл байдлыг нийгмийн байр сууринаас судалснаараа онцлог бөгөөд нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд тусалж, судалгааны үнэ цэнэ, оруулах хувь нэмрийг бага атугай өсгөн нэмэгдүүлнэ гэдэгт итгэж байна.

Түүнчлэн сүүлийн 2002 оноос хойш тасралтгүй 10 жил өөрсдийн санаачилгаар гүйцэтгэж буй “Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс” ээлжит судалгааны тайлангаа танилцууллаа. Бидний судалгааны мөрөөр төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудасны ил тод байдлаа сайжруулах үйл ажиллагааг төлөвлөж, судалгааны үр дүн талуудыг бодитой үйлдэлд уриалж байгаад мэргэжлийн байгууллагын хувьд машинд талархалтай хандан, цаашид эдгээр судалгаануудаа үргэлжлүүлж, хөгжлийн шийдвэр гаргалтыг илүү оновчтой, хүртээмжтэй, тулхтай болгоход хувь нэмрээ тасралтгүй оруулах ёстойг ухамсарлаж байна.

Мөн бид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд цар тахлын дам нөлөөгөөр гаарч буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор хүүхэд хамгаалал, хөгжлийн Ид шидийн орон-2 төв орчмын бүсийн хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг гүйцэтгэж, уг төвийн үйл ажиллагааг улам чадавхжуулахад хэрэгцээтэй мэдээллүүдийг бүрдүүлж өгснөөс гадна, олон улсын “Give2Asia” хандивын сүлжээний дэмжлэгтэйгээр COVID-19 цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн, зорилтот бүлгийн, орлого багатай өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх хүмүүнлэгийн төслөө хоёр дахь жилдээ хэрэгжүүллээ.

2022 онд IRIM судалгааны хүрээлэн дараагийн 5 жилийн стратегиа шинэчилж, технологийн дэвшлийг судалгааны өгөгдөл, дата боловсруулалтад нэвтрүүлэх, судалгааны үр дүн, өгөгдлийг дахин эргэлтэд оруулах, шинжилгээний ур чадвараа улам нэмэгдүүлэх чиглэлд нөөцөө төлөвлөн ажиллахаар зорьж байна.

Цаашид судалгааны ач холбогдлыг ойлгодог, үнэлдэг, ашигладаг талуудыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ үргэлжлүүлэн хүргэх үүднээс байгууллагын “Жилийн тайлан”-гаа бэлтгэн Монголын хөгжлийн асуудлыг сонирхдог хэн бүхэнд хүргэж байна. Уг тайлангаас уншигч та бүхэн бидний 2021 онд хэрэгжүүлсэн нийт судалгааны төслүүд, тэдгээрийн тойм үр дүнтэй танилцах болно.

Бидний үнэт зүйлс, мэргэжлийн ур чадварт итгэл хүлээлгэсэн харилцагч байгууллагууд, хамтран ажилласан судлаач, зөвлөхүүд, бидний судалгаанд оролцож үнэтэй санал бодлоо нэмэрлэсэн Монголын өнцөг булан бүрд амьдран суугаа иргэд, олон нийтдээ баярлалаа.

БИДНИЙ ТУХАЙ



IRIM судалгааны хүрээлэн нь 2008 онд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааныхаа гарааг эхэлж байсан бол өнөөгийн байдлаар нийт 27 үндсэн ажилтантай, 300 гаруй үндэсний болон олон улсын гэрээт зөвлөх, судлаачдын багтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахыг зорьж ажилладаг.

Энэ хугацаанд бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан чанартай мэдээлэл бий болгох, хараат бус, хөндлөнгийн байр суурийг хадгалах, нийгэмд үзүүлэх үр нөлөөгөө дээшлүүлэх зарчмыг үргэлж баримталсаар ирсэн.

Манай байгууллагын гүйцэтгэдэг зөвлөх үйлчилгээ, судалгааны ажил нь өргөн хүрээний нийгмийн асуудлуудыг хамардаг, түүн дотроо засаглал, боловсрол, хөдөлмөрийн зах зээл болон уул уурхай, байгаль орчны салбарт илүүтэй төвлөрдөг.

Улмаар бидний үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж 2013 онд MIRIM (Marketing and Innovation Research Institute of Mongolia) Консалтант компанийг үүсгэн байгуулж маркетинг, инновацын судалгааны чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулж байна.

IRIM ТООГООР

НИЙТ
266
ТӨСӨЛ



2008 ОНЫ
4 сар

2022 ОНЫ
4 сар

107
Засаглал

39
Боловсрол

36
Уул уурхай,
байгаль орчин

15
Хөдөлмөрийн
зах зээл

69
Бусад



192,468
Респондент




100
Захиалагч




156
Хамтрагч

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Архангай	41	Завхан	44	Хэнтий	42
Баян-Өлгий	37	Орхон	37	Улаанбаатар	185
Баянхонгор	48	Өмнөговь	57	БНХАУ-ын Эрээн хот 1	
Булган	28	Өвөрхангай	48	Казахстан	2
Говь-Алтай	44	Увс	46	Киргизстан	2
Говьсүмбэр	29	Сүхбаатар	37	Бангладеш	1
Дархан-Уул	51	Сэлэнгэ	48	Тажикстан	2
Дорнод	46	Төв	41	Афганистан	1
Дорноговь	43	Ховд	64	Нийт	1104
Дундговь	37	Хөвсгөл	50		



- Олон улсын байгууллага
- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- Бусад

Бидний ёс зүйн болон мэргэжлийн зарчим



Олон Улсын Социологичдын Холбоонд (ISA) 2011 оноос хойш Монгол Улсаас албан ёсны гишүүн бөгөөд тус байгууллагаас батлан гаргасан "Ёс зүйн дүрэм"-ийг чанд сахин ажилладаг.



2016 оны 8 сард "Ази-Номхон далайн Үнэлгээний Холбоо"-нд албан ёсоор гишүүн орсон Монголын анхны байгууллага юм. Мөн 2017 оноос тус холбооны ТУЗ-ын гишүүн байгууллагаар сонгогдон ажиллаж байна.



IRIM нь Монголын үнэлгээний сүлжээ байгуулах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус, ОУ-ын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдийг эгнээнд нэгтгэсэн. Одоогоор сүлжээний гишүүдтэйгэй хамтран Үндэсний үнэлгээний стандартыг Монголд нэвтрүүлэхээр ажиллаж байна.



IRIM нь 2016 оноос "Сайн сайхан байдлын судалгаа"-г санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард "Азийн Субъектив Сайн Сайхан Байдлын Олон Улсын Консорциум"-д Монгол Улсыг төлөөлөн гишүүнээр нэгдэн орсон.



ЖЕНДЕРИЙН
ҮНДЭСНИЙ ХОРОО

Монгол Улсын Жендрийн Үндэсний Хорооны орон тооны гишүүнээр 2017 оноос ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн бүхий л салбарт, жендрийн тэгш эрхийг хангуулах, төрийн бодлогод жендрийн тэгш эрхийг зарчмыг хангуулах тал дээр иргэний нийгэм, хувийн хэвшлийг төлөөлөн ажиллаж байна.



Ази номхон далайн улс орнуудын "Нийгмийн харилцан төлөх сүлжээ" байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн 2018 оноос Innovation for Change Төв Азийн бүс нутгийн сүлжээнд нэгдэн орсон бөгөөд мөн тус онд ТУЗ-ийн гишүүн байгууллагаар сонгогдсон. Одоогоор иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалах, түүнд тулгарч буй бэрхшээлийг даван туулах арга замыг хийж хангуулах дор сүлжээний гишүүдтэй хамтран ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн Азийн ардчиллын судалгааны сүлжээнд гишүүнээр элссэн. Уг сүлжээ нь 2013 онд байгуулагдсан. Ази тивд ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжих чиглэлд судалгаа, шинжилгээ хийдэг байгууллага юм. Өдгөө 14 орны голлох 21 think-tank-ууд гишүүнчлэлтэй, Азийн Барометрийн судалгаагаар олон улсад танигдан байдаг.



2019 онд IRIM Судалгааны хүрээлэн Give2Asia олон улсын хандивын сүлжээнд гишүүнээр элссэн. Тус сүлжээ нь Азийн хөгжиж буй улс орнуудад туламдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой орон нутгийн иргэдийн төсөл, хөтөлбөрийг дэмжих хөрвөгч босгох чиглэлээр үйл ажиллагаагаа Азийн 23 оронд явуулах АИУ-д төвтэй ашгийн бус байгууллага юм. Уг сүлжээнд нэгдсэнээр бид Монгол улс дахь хөгжиж, бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, орлоогоо нэмэгдүүлэх чиглэлийн төслүүдийг санаачлан, хэрэгжүүлж байна.

Хамтрагч байгууллагууд



2021/2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧОО

ХЭҮК-ын захиалгаар "Туслах малчны хүний эрхийн судалгаа"-г гүйцэтгэж үр дүнг холбогдох төрийн албан хаагчдад цахимаар танилцууллаа.



1 сар



2 сар

"Монголын Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд COVID-19-ийн үзүүлсэн нөлөө" сэдэвт судалгааны үр дүнг Жендэрийн Үндэсний Хорооноос Эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтан зохион байгуулсан хуралд танилцууллаа.

"Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2021-2025)"-д их дээд сургуулийн багш, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөлөөс санал авах уулзалтад оролцож, саналаа илэрхийллээ.



3 сар



4 сар

IRIM Судалгааны хүрээлэн үүсгэн байгуулагдсаны 13 дахь жилийн ойн баяраа цахимаар зохион байгууллаа.

2021 оны эхний төслийн хаалтыг зохион байгуулж хэрэгжүүлж дууссан 10 төслийг албан ёсоор хааж, туршлага сургажмаа дүгнэлээ.



Би Эф Эй Эс ХХК болон Бизнес эрхлэгч Эмэгтэйчүүдийн Ментор Клубтай хамтран АХБ-ны санхүүжилттэй "COVID-19-ийн үеийн Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих нь" зөвлөх үйлчилгээний төслийг 10 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр боллоо.



5 сар

6 сар

Give2Asia олон улсын хандивын сүлжээний дэмжлэгтэйгэр COVID-19 цар талхын нөлөөнд өртсөн зорилтот бүлгийн өрхүүдэд "Хүнс тэжээлийн туслалцаа үзүүлэх" төслийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлээ.

Лантуун Дохио ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Шинэ Салхи" хөтөлбөрийн судлаач оюутнуудын дунд Хүний эрх болон Судалгааны арга зүйн чиглэлээр 6 модуль сургалтыг амжилттай зохион байгууллаа.

2018 оны ардчиллын хурлын эмхэтгэл болох "Ардчиллын тэмцэл сорилтын жилүүдэд: Монгол ба Дэлхийн улс орнууд туршлагажиж эхэлсэн нь" номын нээлтийг цахимаар зохион байгууллаа.



7 сар

8 сар



НҮБ-ын Хөгжлийн туслалцааны хүрээ (2017-2022)-ны үр дүнг хэмжих үнэлгээний төслийг гүйцэтгэж эхэллээ.

IRIM хамт олон байгууллагынхаа ажилтнуудыг чадавхжуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, стратегийг хөгжүүлэх чиглэлээр явагддаг "Зуны сургалт"-аа 12 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

ХНХЯ, НҮБ-ын захиалгаар гүйцэтгэсэн "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)-ын үнэлгээний үр дүнг танилцууллаа.



9 сар

10 сар



Ажилтнуудын туршлага, чадваруудыг тасралтгүй сайжруулах санаачлагын хүрээнд Английн The Global Growth Institute-ээс зохион байгуулдаг "World Class Manager" сургалтыг Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан бүх ажилтнуудын дунд 1 сарын хугацаанд зохион байгууллаа

British School of Ulaanbaatar-аас зохион байгуулсан Боловсролын үзэсгэлэнд ахлах ангийн сурагчдад Социологийн шинжлэх ухаан, судалгааны салбарын үйл ажиллагааг таниулах зорилгоор нийгмийн хариуцлагын хүрээнд оролцлоо.

ЖҮХ, АХБ-тай хамтран зохион байгуулсан "Жендэр ба Хөгжил-2021" үндэсний чуулганд ахлах судлаач Н.Янжинпагма "Малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй зарим арга, аргачлал: Ховд аймгийн жишээн дээр" сэдэвт тэтгэлэгт судалгааны үр дүнгээ танилцууллаа.



11 сар

12 сар



"Жилийн хүлээн авалт-2021" зургаа дахь жилдээ IRIM судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбатын ивээл дор амжилттай зохион байгууллаа.

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагаас хүн амын шилжилт хөдөлгөөний засаглалыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан "Дотоодын Шилжилт Хөдөлгөөн: Шилжилтээс Хөгжлийн Боломж" сэдэвт бодлогын хэлэлцүүлэгт "Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа"-ны үр дүнг танилцууллаа.

2021 ОНЫ ОНЦЛОХ МЭДЭЭ

IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХАД 10 ДАХЬ ЖИЛДЭЭ ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ БАЙНА

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (МИТББМАЭТХ) батлагдсаны 10 жилийн ойн дээр IRIM судалгааны хүрээлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд гүйцэтгэдэг хараат бус бүтээгдэхүүн болох “Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс” мониторингийн тайлангаа 10 дахь жилдээ гарган, олон нийтэд нээлттэй байршууллаа. Тайланд төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын 10 жилийн өөрчлөлтийн үр дүнг тусгасан бөгөөд 2010 онд төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал ердөө 17.7% байсан бол 2021 онд 54.9% болж нэмэгджээ. Гэвч сүүлийн илүүдэд энэ үзүүлэлт төдийлөн их өсөөгүй, тогтонги сул түвшинд байна. Энэ үнэлгээ нь улсын хэмжээнд төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлдэг цор ганц индекс юм.



Дээрх хуулийг цаг үеийн хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй байгаа гэж үзэн уг хуулийг “Нийтийн мэдээллийн тухай хууль” болгож өөрчлөх хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны УИХ-ын намрын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан билээ. Энэхүү хуулийн төслийн хэлэлцүүлгийн шатанд IRIM судалгааны хүрээлэн хуулийн төслийн ирээдүйд гарч болзошгүй үр дагаврын талаар олон нийтэд нээлттэй, анхны өргөн баригдсан хувилбарт өөрсдийн туршлагад үндэслэн байр сууриа илэрхийлсэн. Үүгээр тус хуулийн төсөл иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахтай холбоотой саад учруулсан хэвээр байгаа тухай болон хууль тодорхой, иргэдэд ойлгомжтой байх гэсэн зарчмыг хангахгүй байгаа гэсэн хоёр бүлгийн 6 саналыг боловсруулан гаргаж, байгууллагын цахим хуудастаа нээлттэйгээр байршуулан, тус хуулийн ажлын хэсгийн гишүүд, УИХ-ын нэр бүхий гишүүдэд бичгээр хүргүүлээд байна. Хуулийн төсөлд илэрхийлсэн байр суурийг бүрэн эхээр нь irim.mn/news/1476 холбоосоор хандан танилцана уу.

IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН НЬ АЗИ-НОМХОН ДАЛАЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОЛБООНД ГИШҮҮНЧЛЭЛЭЭ ИДЭВХТЭЙ ХАДГАЛЖ БАЙНА

Ази-Номхон Далайн Үнэлгээний Холбоо (APEA) нь бүс нутаг дахь үр дүнд суурилсан үнэлгээ, ил тод, нээлттэй байдлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд анхааран ажилладаг байгууллага юм. Манай байгууллага нь тус холбоонд 2016 оноос хойш гишүүнээр элссэн бөгөөд өмнөх Гүйцэтгэх захирлууд болох А.Долгион 2018-2019 онд, Ц.Батсугар 2020-2021 онд ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байв.

IRIM судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач Т.Элбэрэл 2022 оноос энэ холбооны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж эхлээд байна. Т.Элбэрэл нь зорилтот бүлгийн иргэдийн асуудал, боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, засаглалтай холбоотой судалгаа болон хяналт шинжилгээ, үнэлгээний 50 гаруй төслийг зохицуулан, удирдсан туршлагатай судлаач

юм. Тэр бээр мөн Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг төдийгүй Монголын Үнэлгээний Сүлжээний гишүүнээр ажиллаж байна. 2018 онд АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй Фулбрайтын тэтгэлгээр АНУ-н Жоржиагийн Үндэсний Их Сургуульд “Төрийн бодлого”-ын чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн.

IRIM судалгааны хүрээлэн нь эдгээр төлөөлүүдээрээ дамжуулан Ази Номхон Далайн Үнэлгээний Сүлжээнд өөрсдийн дуу хоолойг улам хүчтэй хүргэснээр олон арга туршлагыг өөрсдийн орондоо хэрэгжүүлэх боломж нэмэгдэж байгаа юм.

Тус сүлжээ хамгийн сүүлд 2022 оны 2 сарын 24-нд ‘Ази Номхон Далайн Үнэлгээний Холбооны III бага хурал’-аа цахимаар зохион байгуулж, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Ц.Батсугар панелистаар оролцлоо.

2021 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ЖИЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

IRIM судалгааны хүрээлэн нь 2015 оноос IRIM-ийн Ерөнхийлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбатын ивээл дор “Жилийн хүлээн авалт”-г элчин сайдын яам, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон өөрсдийн харилцагчдын дунд уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Хүлээн авалтаар өөрсдийн ажилладаг тодорхой нэг сэдвийг сонгон авч тухайн асуудалд талуудын оролцоо, ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьдог онцлогтой.




COVID-19 цар тахлаас шалтгаалан 2 жил өнжсөн уг арга хэмжээг 2021.11.30-нд зохион байгуулж, 31 зочид төлөөлөгчид оролцон санал сэтгэгдлээ солилцлоо. Бид Монголын нийгэмд эерэг нөлөө бүхий хараат бус, чанартай судалгаануудыг онцлон хүнд хэцүү цаг үед үйл ажиллагаагаа тасалдалгүй байгууллагын алсын хараа, үнэт зүйлс, зарчмуудыг баримтлан ажилласан туршлагаасаа хуваалцан өнгөрүүлээ.

“АРДЧИЛЛЫН ТЭМЦЭЛ СОРИЛТЫН ЖИЛҮҮДЭД: МОНГОЛ БА ДЭЛХИЙН УЛС ОРНУУД ТУРШЛАГАЖИЖ ЭХЭЛСЭН НЬ” ЭМХЭТГЭЛ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА



бид Төв Азийн 7 орны 15 багийн хүсэлтийг хүлээн авч, 5 орны иргэний нийгмийн байгууллага, нийгмийн идэвхтнүүдээс бүрдсэн 6 баг шалгарч өөрийн улс орондоо ил тод байдал, авлигын эсрэг шинэлэг шийдлүүдийг гаргасан төслүүдийг амжилттай хэрэгжүүллээ. IRIM эдгээр багуудыг төслөө хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, менторуудтай холбох, сургалт семинар зохион байгуулах үйл ажиллагааг хариуцан ажиллаа.

BITRIX-24 ПРОГРАММД СУУРИЛСАН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ДУУДЛАГЫН ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА



COVID-19 цар тахлын үеэр тавьсан хөл хорио нь судалгаа, шинжилгээний, тэр дундаа мэдээлэл цуглуулалтын ажлыг зайнаас хийх шаардлага үүсэж, хэрэгцээ, үнэ цэнийг нь улам нэмэгдүүлсэн. IRIM судалгааны хүрээлэн энэ цаг үеийг дуудлагын төвөө бэхжүүлэн, иргэдээс мэдээлэл цуглуулалт хийх төслүүдийн дийлэнхийг утсаар ярилцлага авах аргачлалаар зохион байгуулж, дуудлагын төвийн чадавхыг сайжруулан ажиллалаа. Аливаа нийгмийн судалгаанд мэдээлэл цуглуулж буй ажилтан

судалгаанд оролцогчид асуултыг зөв, нэг ойлголтоор хүргэн, мэдээллийг бүрэн авах явдал хамгийн чухал процесс байдаг билээ.

Дуудлагын төвийн бүрэн, тасалдалгүй, зохион байгуулалттай үйл ажиллагаа нь тухайн судалгааны бүтээмжийн суурь болж, мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хадгалахад ихээхэн чухал байдаг. Тиймээс бид олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, 10 сая гаруй байгууллагын сонголт болсон Bitrix-24 платформ дээр дуудлагын төвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Энэхүү платформ нь нэгдсэн бүртгэл, төслийн менежмент, харилцаа холбоо, дуудлага авах, дуудлага хийх олон талт цогц үйл ажиллагаатай бөгөөд бүтээмжийг нэмэгдүүлж, зардлыг бууруулах давуу талуудтай юм.

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД АВСТРАЛИЙН САЙН ДУРЫН АЖИЛТНЫ ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧИЙГ ХҮЛЭЭН АВЧ, АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

IRIM судалгааны хүрээлэн Австралийн сайн дурын ажилтны хөтөлбөрөөс зургаа дахь олон улсын сайн дурын ажилтантайгаа амжилттай хамтран ажиллалаа. Энэ удаад байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэг чиглэл болох хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-гээр мэргэшсэн, Австралийн үнэлгээний нийгэмлэгийн гишүүн үнэлэгч Ким Эббиг (Kim Abbey) манай байгууллага дээр 3 сарын хугацаатайгаар зайнаас ажиллалаа. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан анх удаа зайнаас ажилласан хэдий ч маш амжилттай төлөвлөгөөнийхөө дагуу хамтран ажилласан нь өмнөх жилүүдээс онцлогтой байлаа.



Сайн дурын ажилтан нь хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүй, гендерийн чиглэлээр 3 удаагийн сургалтыг байгууллагын ажилтнуудад зохион байгуулж, байгууллага дээр хэрэгжиж буй ХШҮ-ний төслүүдийн тайланд хяналт хийх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад арга зүйн заавар зөвлөгөө өгөх зэргээр байгууллагын чадавхад томоохон хувь нэмрүүд оруулсан юм. Эдгээр үйл ажиллагаа нь ХШҮ-ний үнэ цэнэ, эрэлт хэрэгцээ нэмэгдэж буй өнөө үед хараат бус үнэлгээг бүх төрлийн төсөлд төлөвлөн, хийх чадавхыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлсэнд баяртай байна.

ИД ШИДИЙН ОРОН-2 ТӨСӨЛД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАН “ИД ШИДТЭЙ ХАМТ ОЛОН” БОЛЛОО



IRIM судалгааны хүрээлэн Лантуун дохио ТББ-тай Ид шидийн орон-2 төслийн суурь судалгааны ажлаар хамтран ажиллах санамж бичгийг 2020 оны 10 сарын 03-ны өдөр байгуулсан. Уг хамтын ажиллагааны хүрээнд “Шинэ салхи” оюутны сайн дурын хөтөлбөрийг нийт 60 гаруй оюутнуудын дунд зохион байгуулснаас гадна, “Ид шидийн орон-2” төслийн “Гадаад орчны шинжилгээ”, “Зорилтот орон нутаг дахь Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын суурь судалгаа”-г гүйцэтгэн,

холбогдох тайлангуудыг хүлээлгэн өгөөд байна.

Ийнхүү нэг жилийн хугацаанд үргэлжилсэн хамтын ажиллагааныхаа хүрээнд хоёр байгууллага хийж гүйцэтгэсэн ажлуудаа дүгнэн, цаашдын үйл ажиллагаагаа хэлэлцүүлэх уулзалтыг 2022 оны 03 сарын 17-ны өдөр зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичгээ дүгнээд байна. Уг уулзалтын үеэр Лантуун дохио ТББ-аас хүүхэд хөгжил, хамгааллын салбарт оруулсан хувь нэмрийг үнэлж “ИД ШИДТЭЙ ХАМТ ОЛОН” батламжийг манай байгууллагад олголоо.

IRIM судалгааны хүрээлэнгийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн судалгааны үр дүн нь “Ид шидийн орон жишиг загвар”-ийг боловсруулах, төвийн цаашдын стратегийг боловсруулахад суурь баримт нотолгоо болж байгаад баяртай байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Дэлхийн жишигт нийцсэн хараат бус, судалгаа, зөвлөх үйлчилгээ хүргэдэг, Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв байна.

ЧАНАРЫН БОДЛОГО: Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

**IRIM-ИЙН
САНААЧЛАН
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСЛҮҮД**

IRIM

INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA


Quality

Impact

Independence

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2021

IRIM
INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM судалгааны хүрээлэн

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Цахим ил тод байдлын индексийн зорилго нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх хангагдах боломж бүрдсэн эсэхийг үнэлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах явдал юм. Цахим ил тод байдлын индексийн зорилтууд нь:


- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.



2021 11-р сар

2022 3-р сар

МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төрийн захиргааны түвшний нийт 88 байгууллагын үр дүнд үндэслэн цахим ил тод байдлын индексийг тооцон гаргасан. Үүнд:

Монгол Улсын Яам - 14;

Монгол Уулсын Хэрэгжүүлэгч Агентлаг - 26;

Монгол Улсын Тохируулагч Агентлаг - 10;

Монгол Улсын Орон Нутгийн Захиргаа - 21;

Нийслэл, Дүүргийн захиргаа - 8

Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллага - 9

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Ил тод байдал нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд сайн засаглалыг илэрхийлэх шинж байдлын нэг гэж олон улсын байгууллагууд тодорхойлдог. Үүнийг цахим шилжилтийн үйл явцтай хослуулан хөгжүүлж буй өнөө үед “цахим ил тод байдал” гэх ойлголт бий болсон. Төр олон нийтэд үйл ажиллагаагаа нээлттэй хүргэснээр иргэд цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг авч, төрийн үйл ажиллагааг үр ашигтайгаар хянаж, төр засагт хариуцлага тооцоход суралцана. Тиймээс төрийн мэдээллийг ил тодоор олон нийтэд хүргэх нь нэн тэргүүний шаардлагатай, чухал асуудал юм.

МУЗГ 2021-2024 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөрт “Цахим үндэстэн” болох зорилт тавьж, үүнд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Үүний үр дүнд цахим засаглалтай холбоотой эрх зүйн орчны шинэчлэлт, түүнийг хэрэгжүүлэх бүтэц бий боллоо. Тиймээс цаашид төрийн цахим ил тод байдлыг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарна гэж итгэж байна.

IRIM судалгааны хүрээлэн нь цахим ил тод байдлын хөндлөнгийн үнэлгээг 10 дахь жилдээ гүйцэтгэн та бүхэнд хүргэж байгаа бөгөөд ач холбогдлын хувьд төрийн байгууллагын цахим засаглалыг бүхэлд нь үнэлдэг цор ганц индекс юм. Энэхүү үнэлгээг төрийн байгууллагуудын цахим ил тод байдал хэрхэн сайжирч, эсвэл хэрхэн муудаж буйг тоон утга харгалзуулан жил жилээр үнэлэх, мөн өөр хооронд нь харьцуулж болохуйцаар эрэмбэ тогтоон цахим хуудасны мэдээллийг тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хийж хэрэгжүүлсээр ирлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийлэгдэх бөгөөд 0-1 онооны хооронд утга харгалзуулан, 5 түвшинд ангилдаг. Индексийг хэмжихдээ 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үздэг ба эдгээр нь эрх зүйн орчин, байгууллагын чадамж, цахим нээлттэй байдал гэсэн үндсэн хэсгээс бүрдэж, 9 дэд бүлэг, 26 индикаторын дагуу үнэлдэг.




Эрх зүйн орчин – тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлдэг. Төрийн байгууллагын мэдээлэл ил тод, нээлттэй болгох нөхцөлийг бодлогын түвшинд хэрхэн хангаж буй талаар судалдаг. Түүнчлэн иргэний нийгмийн оролцоо ямар түвшинд байгааг авч үзнэ. Үүнийг хууль, бодлогын баримт бичгүүд болон холбогдох олон улсын үзүүлэлтүүдэд тулгуурлан үнэлнэ. Энэ хэсгийн үнэлгээ нь байгууллагын түвшинд ижил жингээр тооцогддог.

Байгууллагын чадамж - тухайн төрийн байгууллагад мэдээллийг ил тод болгох механизм, чадавх хэр бүрдсэн эсэхийг үнэлдэг. Хууль, бодлогоор тогтоосон ил тод байдлыг хангахын тулд төрийн байгууллагуудын 1) мэдээлэл ил тод болгох процедур бүрдсэн эсэх, 2) хүний нөөц хүрэлцээтэй эсэх, 3) нээлттэй мэдээллийн санг үүсгэх, авч явах чадавх бий эсэх, iv) технологийн чадавх зэргийг тухайн байгууллагын цахим ил тод байдлыг хариуцсан албан хаагчаас авсан мэдээлэлд тулгуурлан үнэлдэг.

Цахим нээлттэй байдал - Энэ бүрэлдэхүүн хэсэгт цахим хэрэгслээр нээлттэй хүргэж буй мэдээллийн цар хүрээг үнэлдэг. Нийт 45 үзүүлэлттэй ба үүнийг задалбал технологи 6, нээлттэй мэдээллийн агуулга 36, иргэдийн оролцоо ба харилцааны талаарх 4 асуулттай байна. Эдгээр асуултуудын 80% нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, стандарттай нийцэж байгаа эсэх буюу мэдээллийн агуулгад тулгуурлах ба үлдсэн 20% нь цахим хуудсыг ашиглахад хялбар байдал, харилцах боломжууд зэрэг технологийн хэрэглээг үнэлдэг.

Цахим ил тод байдлын индекс нь дээрх 3 бүрэлдэхүүн хэсгийн нийлбэрээр тодорхойлогдоно. Индексийг тооцохдоо дээрх 3 бүрэлдэхүүн хэсэг тус бүр ижил жинтэй буюу "1/3" байхаар тооцсон.


Цахим ил тод байдлын индексийг хэмжих түвшин



ГОЛ ҮР ДҮН

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 2021 онд 0.602 буюу 'СУЛ' түвшинд үнэлэгдлээ. Нийт байгууллагын талаас дээш хувь нь болох 53 байгууллага "сул" түвшинд үнэлэгдсэн нь гол нөлөө үзүүлэв. Үнэлгээнд хамрагдсан 88 байгууллагаас 29% буюу 25 байгууллага л ил тод байдал нь 'хангалттай' түвшинд байсан бөгөөд энэ жилийн хувьд "сайн" түвшинд үнэлэгдсэн байгууллага байгаагүй. Үлдсэн байгууллагуудын 8 нь "хангалтгүй" түвшинд үнэлэгдсэн бөгөөд муу түвшинд үнэлэгдсэн байгууллага байгаагүй. Хэдийгээр муу түвшинд үнэлэгдсэн байгууллага байхгүй хэдий ч нийт байгууллагын талаас илүү хувьд нь сул түвшинд үнэлэгдсэн, сайн түвшинд үнэлэгдсэн байгууллага байхгүй нь цаашид цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшин



Эрх зүйн орчны үзүүлэлт

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ				
№	Үзүүлэлтүүд	2021	2019	Зөрүү
Мэдээлэл авах эрх				
	Мэдээлэл авах эрх	0.267	0.224	-0.007
1	Мэдээлэл хүрээ	1.00	1.00	0
2	Мэдээлэл хүсэх процедур	0.917	0.833	0.084
3	Мэдээллийн санхүү ба хамгаалалт	0.750	0.750	0
4	Мэдээллийн санхүү ба хамгаалалт	0.625	0.625	0
Засгалал				
	Хуулийн хэрэгжилт	0.163	0.172	-0.009
5	Дуу хоолой ба хариуцлага	0.430	0.463	-0.033
6	Зохихуулалтын чанар	0.610	0.640	-0.03
7	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	0.450	0.493	-0.043
8	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	0.470	0.473	-0.003
Иргэний нийгэм				
	Иргэдийн оролцоо	0.523	0.591	-0.068
9	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	0.670	0.673	-0.003
10	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	0.730	0.721	-0.009
11	Иргэний нийгмийн төлөв байдал	0.400	0.500	-0.1
Эрх зүйн орчны үр дүн		0.631	0.657	-0.026

Үүнийг индикатор тус бүрээр 2019 онтой харьцуулахад ямар өөрчлөлттэй байгааг дараах зургуудаас харна уу.

Байгууллагын чадамжийн үзүүлэлт

БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
№	Үзүүлэлтүүд	2021	2019	Зөрүү
Байгууллагын бэлэн байдал				
	Ил тод байдлыг хангах процедур ба процесс	0.713	0.715	-0.002
1	Нөөцийн хүрэлцээ	0.838	0.813	0.025
2	Нөөцийн хүрэлцээ	0.588	0.618	-0.03
Үүрэг хариуцлага				
	Мэндлайлал	0.485	0.519	-0.034
3	Тасралтгүй хөгжил ба сургалт	0.533	0.642	-0.109
4	Тасралтгүй хөгжил ба сургалт	0.437	0.396	0.041
Мэдээлэл холбооны технологи (МХТ) ийн бэлэн байдал				
	МХТ-ийн ашиглалт	0.683	0.751	-0.068
5	МХТ-ийн ашиглалт	0.691	0.700	-0.009
6	МХТ-ийн хүрэлцээ	0.677	0.742	-0.065
7	Мэдээллийн санг үүсгэх ашиглах чадвар	0.680	0.811	-0.131
Байгууллагын чадамжийн үр дүн		0.627	0.661	-0.034

Цахим ил тод байдлын үзүүлэлт

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ				
№	Үзүүлэлтүүд	2019	2021	Үр дүн
Технологи				
	Технологийн нийцтэй байдал	0.598	0.553	0.445
1	Технологийн нийцтэй байдал	0.749	0.741	0.008
2	Технологийн үр нөлөөтэй байдал	0.447	0.336	0.111
Нээлттэй мэдээллийн агуулга				
	Үйл ажиллагаа	0.403	0.550	-0.147
3	Үйл ажиллагаа	0.715	0.598	0.117
4	Хүний нөөцийн бодлого	0.439	0.454	-0.018
5	Төсөв, санхүү	0.507	0.697	-0.19
6	Худалдан авах ажиллагаа	0.320	0.409	-0.89
7	Нээлттэй өгөгдөл	0.639	0.594	0.045
Иргэдийн оролцоо ба харилцаа				
	Харилцаа ба эргэх холбоо	0.523	0.621	-0.098
8	Харилцаа ба эргэх холбоо	0.523	0.621	-0.098
Цахим ил тод байдлын үр дүн		0.518	0.549	-0.031

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээгээр 3 дэд бүлгийн 11 индикаторыг хамруулан үнэлдэг. Уг үнэлгээний үр дүнд эрх зүйн орчин 0.631 оноо буюу 'сул' түвшинд үнэлэгдсэн бөгөөд энэ нь 2019 онд хийгдсэн үнэлгээнээс 0.026 оноогоор буурсан үзүүлэлт юм.

Байгууллагын чадамжийн үзүүлэлтийг 3 бүлэг, 7 индикаторын хүрээнд үнэлэхэд 2021 онд 0.627 оноогоор 'сул' түвшинд үнэлэгдэж байна. Үүнийг 2019 оны байгууллагын чадамжийн үзүүлэлттэй харьцуулахад бага зэрэг буурсан байна. Үр дүнгээс харахад мэдээллийг ил тод болгох талаар хууль, дүрэм, журам батлагдаад 10 жил болсон тул мэдээллийн ил тод байдлыг хангах процедур, хүний нөөцийн болон технологийн хүрэлцээтэй байдал нэмэгдсэн ч мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд зориулсан төсөв хангалтгүй байна.

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын өөрчлөлт, оноор хувиар



Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсэг нь 3 дэд бүлэг 8 индикатораас бүрдэх бөгөөд 0.549 оноо авч "сул" түвшинд үнэлэгджээ. Энэхүү үзүүлэлт нь 2019 оны индексээс (0.519) 0.031 оноогоор өссөн үзүүлэлт юм. Нийт 8 индикатораас зөвхөн 2 индикатор хангалттай түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн индикаторууд сул ба хангалтгүй түвшинд үнэлэгджээ.

Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 10 дахь жилдээ энэхүү судалгааг гүйцэтгэж байна. Тиймээс өнгөрсөн хугацааны төрийн байгууллагын цахим ил тод байдалд гарсан өөрчлөлтийг нэгтгэн харуулж байна.

Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 88 төрийн байгууллагын ил тод байдлын 2021 цахим ил тод байдлын ерөнхий индекс улсын хэмжээнд 0.602 гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд байгааг харуулж байна. Уг үр дүнг 2019 онтой харьцуулахад (0.612) өөрчлөлтгүй хэвээр байна.

Анх 2010 онд судалгаанд хамрагдсан 81 төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал ердөө 17.7 хувьтай байв. Тухайн үед төрийн байгууллагын "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг батлаад дөнгөж нэг жилийн хугацаа өнгөрч байсан. Үүний дараа 2011 онд нэмэгдэж 28.7 хувьд хүрсэн ч хангалтгүй хэвээр байв. Үнэлгээ хийж эхэлснээс хойш 5 жилийн дараа буюу 2015 онд төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс өсөж "хангалтгүй" түвшнээс "сул" түвшинд үнэлэгдэж эхэлсэн. Энэхүү өсөлтийн шалтгаан нь 2014 оны 7 сард Шилэн дансны тухай хууль хэрэгжиж төрийн байгууллагууд төсөв санхүүгийн ил тод байдлаа цахим хуудсаараа дамжуулан мэдээлэлдэг болсонтой холбоотой. Нээлттэй мэдээллийн агуулга дотроос төсөв, санхүүгийн ил тод байдал нь сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй өсөж байгаа нь сайн үзүүлэлт юм.

Гэвч сүүлийн 7 жилийн хугацаанд төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал төдийлөн өссөнгүй. Үүнд төрийн мэдээллийн ил тод байдлыг хянах, хариуцлага тооцох механизм сул байгаатай холбоотой.

Дүгнэлт

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 0.602 буюу 'сул' түвшинд үнэлэгдсэн ба сүүлийн 5 жилийн хугацаанд уг үзүүлэлтэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

Индексийг тооцоход авч үзсэн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн үр дүнг нэгтгэн авч үзвэл:

Эрх зүйн орчны индекс 0.631 оноо авч 'сул' түвшинд үнэлэгдлээ. 2019 онд Монгол Улсын цахим ил тод байдлын эрх зүйн орчин 0.657 оноо авч хангалттай түвшинд үнэлэгдэж байсан бол даруй 2 жилийн дараа гэхэд уг үзүүлэлт буурсан дүнтэй байна. Энэ хугацаанд мэдээлэл авах эрхийн хүрээнд нээлттэйгээр авах боломжтой мэдээллийн хүрээ хумигдаж, засаглалын бүх үзүүлэлтүүд болон иргэний нийгмийн бүлэг хэсгийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөнөөс бусад үзүүлэлтүүд бууралттай гарлаа. Буурсан дүнтэй гарсан үзүүлэлтүүдээс иргэний нийгмийн төлөвшил хамгийн ихээр буурсан нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлд цаашид анхаарах шаардлагатай.

Байгууллагын чадамжийн индекс 0.627 буюу 'сул' түвшинд үнэлэгдлээ. Ялангуяа мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн үүрэг бүхий албан тушаалтан томилох болон мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилтныг хөгжүүлэх, хянах механизм сул хэвээр байна. Мөн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг иргэдийн санал, гомдолд үндэслэн сайжруулах байдал сул. Энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд зориулсан төсөв хангалтгүй байгаа нь мэдээллийн ил тод байдал нэмэгдэхгүй байх нэг үндсэн шалтгаан болж байна.

Цахим нээлттэй мэдээллийн индекс 0.549 буюу 'сул' түвшинд үнэлэгдлээ. Төрийн байгууллагууд цахим хуудсанд мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн тусдаа цэстэй, мэдээллийн төрөл, ангилал бүрээр мэдээллээ оруулж байгаа ч оруулсан мэдээллийн агуулга харилцан адилгүй байна. Тэр дундаа "шилэн данс", "төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-д байгууллагуудын 80% нь цахим хуудсаа холбосон, холбоосоор дамжин шууд нэвтрэн орох боломжтой байна. Эдгээр системүүдээр дамжуулан Сангийн яам хяналт тавьдагтай холбоотойгоор төсөв, санхүүгийн ил тод байдал хамгийн их өсөлттэй байж, хангалттай түвшинд үнэлэгдсэн. Тиймээс хяналтын тодорхой механизм нь мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Үр дүнгийн дэлгэрэнгүй тайлантай та бүхэн www.irim.mn/web-monitoring холбоосоор хандан танилцах боломжтой.

IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН: НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ БАЙР СУУРЬ

IRIM судалгааны хүрээлэн нь өнгөрсөн 13 жилийн хугацаанд хараат бус, Монголын туршлагад тулгуурласан судалгаа, зөвлөх үйлчилгээг тасралтгүй үзүүлэн, салбараа манлайлан ажиллаж байна. Бид төрийн бодлого, үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийдэг туршлагатай ба өнгөрсөн 9 жилийн турш нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээг хийж ирсэн. Энэхүү үнэлгээ нь 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (МИТББМАЭТХ)-д түшиглэсэн арга зүйгээр хийгддэг.

Тус хуулийг “Нийтийн мэдээллийн тухай хууль” (НМТХ) болгож өөрчлөхөөр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны УИХ-ын намрын нэгдсэн чуулганаар хэлэлцэж байгаа энэ үед хуулийн төслийн ирээдүйд гарч болзошгүй үр дагаварын талаар хуулийн төслийн олон нийтэд нээлттэй, анхны өргөн баригдсан хувилбарт өөрсдийн туршлагад үндэслэн байр сууриа илэрхийлж байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь одоогийн мөрдөгдөж байгаа хуулиас агуулгын хувьд өргөн хүрээтэй, цахим технологийн хөгжилтэй нийцүүлсэн хууль болж байгаа ч энэ хэрээрээ ойлгомжгүй, тодорхой бус байгаа нь хэрэгжилтийг хангахад хүндрэл учрах эрсдэлтэй байна. “Нийтийн мэдээллийн тухай хууль”-ийн зорилго нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох гэж томъёолсон. Энэ зорилгыг хангахад дараах асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Одоогийн мөрдөгдөж буй МИТББМАЭТХ -д иргэд мэдээллийг хаанаас авах, ямар мэдээллүүд авахыг тодорхой тусгасан байдаг ч иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийг нээлттэй байлгах, мэдээллийг авах эргэх холбоог сайжруулах шаардлага байсаар байгаа. Гэтэл эдгээр сайжруулах шаардлагатай зүйлс хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдаагүй хэвээр байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах зорилготой хамгийн чухалд хуульд саад учруулсан хэвээр байна. Тухайлбал:

- Иргэдийн мэдээлэл олж авах үйл явцыг хялбаршуулах зорилгоор төрийн байгууллагын цахим платформ иргэдтэй харилцах сонголтот арга хэрэгслүүдтэй байхыг шаардлага болгож оруулах. Үүнд: Цахимаар өргөдөл, гомдол гаргах, чатбот, цахим хуудасны мэдээлэлд сэтгэгдэл бичих хэсэгтэй байх гэх мэт.
- Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.3 болон 9.6-д мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр мэдээлэлтэй танилцах боломжтой гэсэн нь энэ хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Зөвхөн энэ зүйл заалтуудад үндэслэн мэдээлэл ил тод болохгүй байх, мэдээлэл авах эрхийг хязгаарлах үндэслэл болж байгаа нь өмнөх хуулиас дордуулсан зүйл заалтын нэг том жишээ юм.
- Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих субъект болон үнэлэх, дүгнэх үйл явц өмнөх хуультай харьцуулахад тодорхойгүй хэвээр үлдсэн нь мөн хуулийн хэрэгжилтийн хангах асуудлыг тодорхойгүй болгож байна. Тухайлбал, одоогийн хэрэгжиж буй МИТББМАЭТХ-н 24-р зүйлд заасан хэрэгжүүлэх механизмтай харьцуулахад энэ харилцаа тодорхойгүй байна. Иргэд, хуулийн этгээд мэдээлэл авах, шаардах эргэх холбоо бүхий үйл явцыг хангалттай тусгаагүйгээс хуулийг практикт хэрэгжүүлэхэд хяналтын тогтолцоо суларч, шахалт буурснаар мэдээлэл хариуцагч мэдээлэл оруулаагүйтэй холбоотой үүссэн хариуцлагыг тухай бүрд хүлээх боломжгүй

болох эрсдэл үүсэхээр байна.

- Нээлттэй болгож буй мэдээллийн төрөл нэмэгдэж байгаа ч мэд яээлэл хариуцагчийн ажлын орон тоо, чиг үүрэг тодорхойгүй хэвээр байна. Ихэнх төрийн байгууллагад байгууллагын ил тод байдлыг хариуцсан ажилтны тодорхой орон тоо байхгүй, өөр өөр албан тушаалтай хавсран гүйцэтгэх байдал нийтлэг байна. Хуулийн төсөлд тусгасан мэдээллийн төрөл нэмэгдсэнээр мэдээлэл хариуцагчийн ажил үүрэг нэмэгдэх магадлалтай. Гэвч мэдээлэл хариуцагчийн статусын тодорхойгүй байдал нь энэ хуулийн хэрэгжилтийг бүрэн хэмжээнд хангахгүй байх эрсдэлтэй.

Хоёр. Одоогийн мөрдөгдөж буй МИТББМАЭТХ нь мэдээллийг албан ёсны цахим хуудас болон мэдээллийн самбараар авахыг тодорхой заасан байдаг. Харин хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь өнөөгийн цахим шилжилтийн өөрчлөлттэй нийцүүлэн мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд цахим мэдээллийн системээр нээлттэй хүргэнэ гэж өргөн хүрээтэйгээр тодорхойлсон. Энэхүү хэт өргөн хүрээтэйгээр тодорхойлсон байдал хууль тодорхой, иргэдэд ойлгомжтой байх гэсэн зарчмыг хангахгүй байна гэж үзэж байна. Тухайлбал:

- Хуулийн гол нэр томъёонуудын тодорхойгүй нэршил, тэдгээрийн ялгаа заагийг гаргах. Жишээлбэл, мэдээллийн систем болон мэдээллийн дэд бүтэц гэх нэршлүүд хэд хэдэн төрлөөр хуульд хэрэглэгдэж байгаа нь хууль хэрэглэгчдэд ойлгомжгүй, төөрөгдүүлсэн байдлыг үүсгэж байна. Тодруулбал, мэдээллийн үндсэн систем гэдэг нь тусдаа үүсэж буй платформ уу эсвэл тухайн байгууллагын цахим хуудас уу гэдэг нь ойлгомжгүй, мэдээллийн дэд бүтцийг тайлбарлахдаа мэдээллийн систем болон мэдээллийн сүлжээ зэрэг ойлголтуудаа хольсон зэрэг хаанаас ямар мэдээлэл авах, бүтэц, логик

дэс дарааллыг ойлгомжгүй байдлаар тайлбарласан нь уг хуулийг гол хэрэглэгч болох иргэдэд мэдээлэл авах эрхээ хангахад бэрхшээл учруулж байна.


- Хуулийн төслийн 38-р зүйл дэх “нийтийн мэдээллийн систем ийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд” гэдэгт мэдээлэл хариуцагч эсхүл мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж эсхүл тухайлсан аль байгууллагыг нэрлэж байгааг нарийвчлан тодорхойлж оруулаагүй байна. Энэ нь хуучин хуулиас шинэ хууль руу шилжих шилжилтийн үеийн зохицуулалтад ямар хуулийн этгээд, субъектийг хамааруулж үзэх нь тодорхойгүй болгож байна.

Дүгнэлт. Одоогийн хэлэлцүүлэгдэж буй Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах эрхээ хангаж байгаа тулгуур хууль. Хууль иргэдэд ойлгомжтой байх зарчмын хүрээнд дээр дурдсан саналуудыг тусгаагүйгээс иргэн, аж ахуй нэгжүүд ямар мэдээллийг хаанаас олж авах нь тодорхойгүй байх; хуульд заасан нэр томъёонуудыг ашиглан ялгаатай тайлбарлал хийж, үндсэн зорилгоос бусад зорилгоор ашиглах; хүлээн зөвшөөрч буй хэлбэрийн тодорхойгүй байдлаас үүдэн албан тушаалтнууд өөрсдийн үзэмжээр харилцах хэлбэрээ сонгох; хариуцах эзэнгүй хугацаа алдах; хуучин үйл ажиллагаа арга хэлбэрээс шинэ нөхцөлд ямар шат дарааллын дагуу шилжих нь тодорхойгүй болох зэрэг эрсдэлүүд гарч болзошгүй байна.

Иймд, хэрэв хуулийн шинэчилсэн найруулгын төсөл энэ хэвээр батлагдвал түүнийг даган гарах журам, зааварчилгаа, тэдгээрийн хэрэгжилтийг тодорхой, ойлгомжтой боловсруулж, мөрдүүлэхэд онцгой хүчин чармайлт гаргах шаардлагатайг үүгээр илэрхийлж байна.

2021 оны 11 сарын 25

МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА: ЭМЧ, ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГСДЫН САЙН САЙХАН БАЙДАЛ



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM судалгааны хүрээлэн

Олон Улсын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Эмч эмнэлгийн байгууллагын ажилчдын нийгмийн нийцэл, сайн сайхан байдлын түвшнийг тодорхойлж, үндэсний хэмжээнд гүйцэтгэсэн суурь судалгаа (цаашид “улсын дундаж” гэсэн нэршлээр ашиглагдана)-ны үр дүнтэй харьцуулагдах зорилготой юм.




2021

12-р сар

2022

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотод байршилтай эмнэлгийн байгууллагын 380 ажиллагсад

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэнгийн бие даасан бүтээгдэхүүн болох "Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа" 5 дахь жилдээ хийгдэж байна. Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Уг судалгааны хүрээнд жил бүр нийгмийн ялгаатай бүлгүүдийг судалгааны зорилтот түүврээр сонгон авч тухайн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг шинжлэх ухааны арга, аргачлалаар цуглуулсан баримт нотолгоонд суурилж тайлбарлахыг зорьдог. Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2016-2019 оны хооронд жил бүр өөр өөр цаг хугацаа, цаг үеийн ялгаатай мөчлөгүүдийн харгалзан цуглуулсан бөгөөд сэдэвчилсэн судалгааны гол харьцуулах үзүүлэлт болгон ашигладаг. Өнгөрсөн 2020 онд "Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал" сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэж үр дүнг олон нийтэд танилцуулсан бол 2021 оны мэдээлэл цуглуулалтын зорилтот бүлгээр эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудыг сонгосон. Зөвхөн

Монголд төдийгүй дэлхийн дахинд COVID-19 цар тахлын өвчлөл, нас баралт нэмэгдсээр байгаа энэ хүнд цаг үед эмнэлгийн байгууллагын ачаалал, ажлын цаг эрс нэмэгдэж байгаа билээ. Өөрөөр хэлбэл эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд нь сүүлийн 1-2 жилийн хугацаанд нийгмийн асуудал, сайн сайхан байдал нь хамгийн их хөндөгдөж байгаа бүлэг юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын эмч, эмнэлгийн байгууллагын 380 ажилтнуудыг судалгаанд оролцуулсан бөгөөд тоон судалгааны аргыг голчлон ашиглав.

Судалгаанд нийт 4 бүлэг, 54 асуулт ашигласан бөгөөд 2 бүлэг 20 гаруй асуулт нь судалгааны үндсэн үр дүнг илэрхийлж, бусад асуултууд нь харьцуулагдах, үр дүнг дэмжих байдлаар тайланд туссан.

Нийгмийн сайн сайхан байдлыг илэрхийлэх үндсэн асуултуудад 0-10 хүртэлх 11 сонголт бүхий Кантрил (Cantril, 1965)-ын шкалыг ашиглаж, үндсэн үр дүнг эдгээр 11 шкалын дундаж утгаар илэрхийлнэ.


Судалгааны мэдээлэл цуглуулалтыг КОВИД-19 цар тахлын дэглэмийг чандлан мөрдөж, 2021 оны 12 сард дээр дурдсан эрүүл мэндийн 8 шатлалын байгууллагуудыг хамруулан гүйцэтгэсэн. Үүнд:

- Өрхийн эмнэлэг-30
- Эрүүл мэндийн төв-25
- Нэгдсэн эмнэлэг-131
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв-3
- Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг-95
- Төрөлжсөн мэргэжлийн төв-30
- Оношилгоо эмчилгээний төв-7
- Бусад (хувийн эмнэлэг)-59

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд бусад хүмүүст итгэх ерөнхий итгэлийн түвшин 4.9 байв. Энэ нь улсын дундаж үр дүнгээс 1.76 функтээр бага дүр зургийг харуулсан. Өөрөөр хэлбэл бусдад итгэх тал дээр эмнэлгийн байгууллагад ажиллагсад нийт Монголчуудтай харьцуулахад илүү болгоомжтой хандаж байна.

Нийгмийн нийцэл




Бүх зүйлсийг хамруулан авч үзвэл та өөрийгөө хэр зэрэг аз жаргалтай гэж хэлэх вэ?

(0= Огт аз жаргалгүй; 10= Бүрэн дүүрэн аз жаргалтай)

Улсын дундаж дүнг харвал Монголчууд өөрсдийн амьдралдаа нэлээд сэтгэл хангалуун (7.96) байдаг нь харагддаг. Харин эмнэлгийн байгууллагад ажиллагсдын хувьд өөрсдийн амьдралдаа сэтгэл ханамжтай, аз жаргалтай байгаа байдал улсын дунджаас ялимгүй бага (7.19) байв.

Хэдийгээр үр дүнг дунджилж авч үзэхэд төдийлөн зөрүү гарахгүй байгаа боловч эмнэлгийн байгууллагад ажиллагсдын “бүрэн дүүрэн аз жаргалтай” ангилал руу дөхсөн шкал буюу 8, 9, 10 гэсэн хариултуудыг сонгосон байдал улсын дундажтай харьцуулахад эрс бага байна.


Амьдралын сэтгэл ханамж



Амьдралын олон талт байдлын үнэлгээ

Амьдралын олон талт байдлын үнэлгээ гэдэг нь хүний амьдрал эсвэл түүний тодорхой нэг онцлог талын когнитив үнэлгээ буюу хүмүүсийг өөрийн амьдралын талаар эргэцүүлэн бодож ерөнхийдөө амьдрал нь хэрхэн явж байгаа талаар үнэлүүлэх асуултауд юм. Амьдралын олон талт байдлын сэтгэл ханамжийг үнэлэх 8 асуулт асуусан ба үр дүнг дор харуулав.

Амьдралын олон талт байдлын үнэлгээ



Эмнэлгийн байгууллагад ажиллагсад гадаад орчин болон хувийн орчиндоо хэрхэн үнэлэлт өгч байгаа нь ялгаатай байв. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь гадаад орчин болох Монголын Улс төрийн нөхцөл байдал (2.81), эдийн засгийн нөхцөл байдал (3.38)-д сэтгэл ханамж муу байв. Эсрэгээр өөрийн гэр бүл, ажил мэргэжилдээ хамгийн өндөр сэтгэл ханамжтай байдаг болохоо илэрхийлжээ.

Дүгнэлт

Эмч нар бусад хүмүүст хэт их итгэх эсвэл хэт итгэхгүй байхаас илүүтэй дундаж хариултын утгуудыг түгээмэл сонгож байв. Эмнэлгийн байгууллагад ажиллагсдын хувьд ойрын хүрээлэл буюу гэр бүл хамаатан садан, хамтран ажиллагсад, хөршүүддээ итгэх итгэл бусад нийгмийн бүлгүүдтэй харьцуулахад өндөр байна.

Эмнэлгийн байгууллагын ажилтнууд одоогийн болон өмнөх 5 жилийн амьдралаа 10 гишгүүртэй шатаар зүйрлэхдээ 5-6 дугаар гишгүүрийн хооронд байгаагаар, харин 5 жилийн дараах амьдралаа 7 дугаар гишгүүт дээр байгаагаар төсөөлсөн. Одоогийн нөхцөл байдлаа өнгөрсөн болон ирээдүйн нөхцөл байдлын аль алинаас доогуур үнэлсэн нь улсын дундаж үр дүнтэй харьцуулахад онцлог байв.

Эмнэлгийн байгууллагад ажиллагсад гадаад орчин болон хувийн орчиндоо хэрхэн үнэлэлт өгч байгаа нь ялгаатай байв. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь гадаад орчин болох Монголын улс төрийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдалд сэтгэл ханамж муу байв. Эсрэгээр өөрийн гэр бүл, ажил мэргэжилдээ өндөр сэтгэл ханамжтай байдаг болохоо илэрхийлсэн.

Эмч нарын бүлгийн сэтгэл зүйн ерөнхий шинж хандлага харьцангуй өндөр, сэтгэл ханамжтай байв. Тэр дундаа өөрсдийн “бие даасан байдал” (өөрийнхөө төлөө шийдвэр гаргах, амьдралын утга учир зорилгоо тогтоох эрх чөлөө)-даа хамгийн сэтгэл ханамжтай байна. Харин сүүлийн үеийн нөхцөл байдалтай холбоотой бодомжуудад өгсөн сөрөг хариулт илүү өндөр байлаа.

Судалгааны үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй тайланг irim.mn/Well-Being-Study холбоосоор хандан танилцана уу.

COVID -19 ЦАР ТАХЛААС ҮҮДЭН ХҮНС, ТЭЖЭЭЛИЙН ДУТАГДАЛД ОРСОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ӨРХҮҮДЭД ХҮНСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ-2



ТЭГГЭЛЭГ ОЛГОСОН:

Give2Asia

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

COVID-19 цар тахлын нөлөөнд өртсөн зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх, эрүүл зөв хооллолтын сургалт зохион байгуулах зорилготой.




2021

6-р сар

2021

8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Төв аймаг Зуунмод сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн нь Ази, Номхон далайн 20 гаруй оронд хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон Улсын ашгийн бус байгууллага болох Give2Asia хандивын сүлжээний санхүүжилтээр “COVID-19-ийн нөлөөнд өртсөн зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг 2 дахь удаагаа хэрэгжүүллээ. COVID-19 цар тахал дэлхий даяар тархсантай холбоотойгоор Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн урт болон богино хугацааны хөл хорио, хязгаарлалтууд нь нийгэм, эдийн засгийн олон сөрөг үр дагавруудыг бий болгож, энэ нь иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлсөн. Үүний үр нөлөө нийгмийн зорилтот бүлгийн өрхүүдэд, тэр дундаа орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон өрхүүдэд илүү хүчтэй тусаж байгаа тул цар тахлын хүнд хэцүү үеийг даван туулахад нийгэмдээ хувь нэмрээ оруулах зорилгоор IRIM судалгааны хүрээлэн зорилтот бүлгийн өрхүүдэд хүнс тэжээлийн тусламж үзүүлэх төслийг санаачлан, Give2Asia хандивын сүлжээний тэтгэлгийн тусламжтайгаар уг төслийг 2 дах жилдээ

амжилттай хэрэгжүүллээ.

Төслийн нэгдүгээр шатанд зорилтот бүлгийн 200 өрхөд хүнс тэжээлийн багц түгээх ажлыг амжилттай зохион байгуулсан. Уг төслийн хоёр дахь шатны онцлог нь иргэд, олон нийтийн эрүүл зөв зохистой хооллох мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээрх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн явдал юм. Учир нь цар тахлын хөл хорионы үед орлого нь тасалдаж, хоол хүнсгүй болсон өрхүүдийн эдийн засагт хэмнэлттэй, эрүүл хоол хүнс хэрэглэх талаар мэдлэг, дадлыг дээшлүүлэх нь тэдэнд урт хугацаандаа өгөөжтэй, үр дүнгээ өгсөн ажил болно гэж үзсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Хүнсний тусламж үзүүлэх өрхүүдийг сонгохдоо аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран тодорхойлсон ба ингэхдээ өрхөд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн бий эсэхийг нэн тэргүүнд харгалзан үзсэн.

Хүнс тэжээлийн багцаа сонгохдоо бид хоол зүйн зөвлөх багш нараасаа зөвлөгөө авч өдөр тутамдаа авч хэрэглэж болох илчлэг чанар өндөр хямд зардалтай зүйлсийг сонгож хүнсний багцаа бэлтгэсэн.

ГОЛ ҮР ДҮН

Төслийн нэгдүгээр шатны хүрээнд 2020 оны 8-9 дүгээр сарын хооронд Нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймаг дахь зорилтот бүлгийн 200 зорилтот өрхөд хүнс тэжээлийн багц түгээх ажлыг амжилттай зохион байгуулсан.

Уг төслийн хоёр дахь шатанд 2021 оны 6-8 дугаар сард Нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Төв аймгийн Зуунмод сумын 160 иргэд, олон нийтийн эрүүл зөв зохистой хооллох мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Төслийн хүрээнд (1) хамгийн хэрэгцээтэй гэж тодорхойлогдсон бүтээгдэхүүнийг агуулсан хүнсний тусламжийн багц бэлтгэн, 160 зорилтот өрхүүдэд дэмжлэг үзүүлж, (2) зорилтот бүлгийн хүмүүс өдөр тутмын нийтлэг хүнсний бүтээгдэхүүнийг ашиглан эрүүл зөв, зохистой хоол бэлтгэх талаар практик мэдлэг олгох 2-3 цагийн сургалтыг Хоол зүй, шим судлалын Монголын Нийгэмлэгийн гишүүн, Монгол Улсын зөвлөх инженер гурван зөвлөх багштай хамтран зохион байгуулж, зөв хооллолтын талаар мэдээлэл болон хэрхэн хямд, төсөр аргаар эрүүл шим тэжээлтэй хоол хүнс хийх талаар жорыг агуулсан гарын авлагыг тарааж, (3) олон нийтийг уг хүнд хэцүү нөхцөлд бие

биедээ тусалж дэмжихийг уриалсан видео бичлэг хийж өөрсдийн нийгмийн сүлжээ, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд танилцуулаад байна.

Хүнсний тусламжийн төслийг танилцуулсан, үр шим хүртэгчдийн санал бодол, сэтгэгдлийг харуулсан видео бичлэгтэй дараах холбоосоор танилцах боломжтой.

https://irimmn-my.sharepoint.com/:v/g/person-al/azbileg_irim_mn/Eau5hKX8AAxLqBWZL7xyT-WYB-xz7iADW0q2NkhROdiYPig?e=W5DWxc

IRIM Судалгааны хүрээлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүлсэн уг төслийг санхүүжүүлсэн Give2Asia хандивын сүлжээ, түүний хандивлагчид, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд гар бие оролцсон, хувь нэмрээ оруулсан бүх талуудад талархлаа илэрхийлж байна. Бидний хувьд өөрсдийн судалгаа, үнэлгээний ажилдаа зорилтот бүлгийн иргэдийн дуу хоолой, хэрэгцээ шаардлагыг тусгахыг ямагт эрхэмлэн ажилладаг бөгөөд цаашид ч хүмүүнлэг, хариуцлагатай нийгмийг бүтээхэд өөрсдийн хувь нэмрээ оруулахыг хичээн ажиллах болно. Бид хүн бүрд тусалж чадахгүй ч, хүн бүр хэн нэгэнд тусалж чадна!



ИД ШИДИЙН ОРОН 2 ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙСЭН СУУРЬ СУДАЛГАА



ЛАНТУУН ДОХИО ТББ
МОНГОЛ ЗАЛУУС ХҮЧИРХИЙЛЭЛИЙН ЭСРЭГ



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Лантуун Дохио ТББ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг судалгаа нь “Ид шидийн орон”-2 хөгжлийн төвийн урт хугацааны стратегийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг цуглуулж, байгууллагын удирдлагыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах гол зорилготой. Энэ зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэв. Үүнд:

Зорилт 1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх зорилтот хороодын эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг ойлголт, хандлага, зан үйлийг тодорхойлох

Зорилт 2. Төвийн танигдсан байдал, талуудын өгсөн үнэлгээ, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

Зорилт 3. Байгууллагын гадаад орчны шинжилгээг хийх



2020

12-р сар

2022

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 9, 10, 23-р хороо


ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн нь Лантуун дохио ТББ-ын Ид шидийн орон-2 (ИШО-2) хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлон, цаашид баримтлах бодлого, стратеги боловсруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлсэн. Энэ хүрээнд бид 2021 онд "Ид шидийн орон"-2 хөгжлийн төвийн урт хугацааны стратегийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг цуглуулж, байгууллагын удирдлагыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах гол зорилгыг дэвшүүлж, Гадаад орчны шинжилгээ болон Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын судалгааг амжилттай хэрэгжүүлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны зорилтын дагуу хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон нийт, тэр дундаа эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхэд залуусын мэдлэг ойлголтыг тодорхойлохдоо зорилтот хороодын өрхийн эцэг, эх, асран хамгаалагч, 12-17 насны хүүхэд залуусын төлөөллийг хамруулан тоон судалгааг зохион байгуулсан. Эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдийн мэдлэг ойлголтын ялгаатай байдлыг харьцуулах зорилгоор тоон судалгааг нэг өрхийн эцэг эх болон хүүхдээс авахаар зохион байгуулж гүйцэтгэсэн.

Зураг 1 Судалгааны дизайн



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүүхэд хамгааллын талаар ойлголт мэдлэг: Судалгаанд оролцогчид "хүүхэд хамгаалал" гэсэн ойлголтыг хаана, ямар орчинд хамааруулж ойлгож буй талаар болон тус ойлголттой холбоотой гол оролцогч талуудыг хэрхэн тодорхойлсноор нь мэдлэгийн нөхцөл байдлыг хэмжсэн. Хүүхэд хамгааллын талаар бүрэн дүүрэн ойлголттой, хүүхдийн аюулгүй байдлыг хангахын тулд бүх талууд, иргэд оролцоотой байх ёстой талаар нийт судалгаанд оролцсон хоёр хүн тутмын нэг нь зохих **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг танин мэдэж буй байдал**: хүүхдийн эсрэг түгээмэл үйлдэгддэг "үл хайхрах", "сэтгэл санааны", "бие махбодын", "бэлгийн" гэсэн 4 төрлийн хүчирхийллийн хэлбэрийг судалгаанд оролцогчид мэдэж буй эсэхийг тодорхой бодомжуудаар таньж, тодорхойлж чадаж буй эсэхээр хэмжсэн. Хүчирхийллийн хэлбэрүүдийг илтгэх 11 бодомж болон үл хамаарах буюу хүчирхийллийн шинжтэй бус үйлдлүүдийг илэрхийлсэн 7 бодомжоос бүрдсэн асуулгыг оролцогчдоод танилцуулан, зөв тодорхойлж буй эсэхийг шалгасан. Хүчирхийллийн хэлбэрүүдийг зөв таних байдал

эцэг эх, хүүхдүүдийн хариултад статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байдал ажиглагдаагүй ч хүүхдүүд ихэнх бодомжуудад эцэг эхчүүдээсээ илүү өндөр хувьтай зөв хариулуудыг өгсөн байна. Тэр дундаа "сэтгэл санааны" болон "бэлгийн" хүчирхийлэлд хамаарах бодомжуудыг хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ харьцуулахад илүү зөв тодорхойлжээ.

Хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага: Хүүхдээ хэрхэн, ямар аргаар хүмүүжүүлэх нь эцэг эхийн мэдэх асуудал бөгөөд зарим тохиолдолд бие махбодын шийтгэл (гар хүрэх) оноох хүмүүжлийн арга барилыг байж болох асуудал гэж үзэх хандлага эцэг эх, хүүхдүүдийн аль алинд нь өндөр хувьтай байна. Хүүхэд хүмүүжлийн хандлагыг тандсан энэхүү асуултуудад эцэг эх, хүүхэд гэдгээс эсвэл нас, хүйс, боловсрол гэх мэт бусад хүн ам зүйн үзүүлэлтүүдээс хамаарсан ялгаа алга байв.

Ид шидийн орон төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл: Лантуун дохио ТББ-аас илүү ИШО-2 төвийн үйл ажиллагааны талаар зорилтот хорооны иргэд илүү мэдээлэлтэй байв. Гэвч ИШО-2 төвийн талаар мэдээлэлтэй гэж хариулсан

оролцогчдын дийлэнх нь буюу 3 хүн тутмын хоёр нь 'ерөнхий ойлголттой' гэж хариулснаас үзвэл цаашид төвийн танигдсан байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй юм.

Дүгнэлт, цаашдын чиглэл


Хүүхдийн аюулгүй байдал: Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдал хангагдсан гэж талууд үзэж байгаа хэдий ч оролцогчдын ойлголтын зөрүүгээс шалтгаалан тодорхой аюул, эрсдэлүүдийг хүүхдийн аюулгүй байдалтай холбон авч үзээгүй, өнгөрөөсөн байх талтай. Хүүхдүүдийн хувьд голлон эцэг эхтэйгээ харилцах харилцаа, ойлголттой холбоотой асуудлуудыг гэр бүлийн орчин дахь өөрсдийн аюулгүй байдалтай холбон дурдсан нь "үл хайхрах" төрлийн хүчирхийллийн хэлбэр гэр бүлийн орчинд түгээмэл байгааг илтгэсэн.

Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал: Хүүхэд хамгааллын талаар судалгаанд оролцогчдын тал хувь нь зохих түвшинд ойлголттой, үлдсэн нь зөвхөн хүүхдийн эцэг эх, гэр бүлийн гишүүдийн чиг үүрэг гэсэн хязгаарлагдмал ойлголттой байна.

Мөн хүчирхийллийн хэлбэрүүдийг зөв таних бодомжуудад хүүхдүүд нь эцэг эхчүүдээсээ илүү зөв хариултаудыг өгсөн. Гэвч "Үл хайхрах" төрлийн хүчирхийллийн талаар эцэг, эх, хүүхдүүдийн мэдлэг бага байна. Иймд цаашид хүүхэд хамгааллын талаар болон хүчирхийллийн хэлбэр, түүний үр нөлөөг таниулсан ажлуудыг эцэг эх, хүүхдүүдэд таниулах, мэдлэг олгох бодит шаардлагатай байгаа нь харагдлаа.

Хүүхдийг хүмүүжүүлэх нь зөвхөн эцэг эхийн асуудал бөгөөд ямар арга ашиглах нь бусдад хамаагүй гэсэн нэг талын өрөөсгөл ойлголт эцэг эх, хүүхдүүд дунд өндөр байна. Ялангуяа хүүхдүүдийн хувьд эцэг, эхээс цохиж зодуулах төрлийн шийтгэл авах нь байж болох зүйл гэж үзэж байгаа нь энэ төрлийн гэр бүлийн хүчирхийллийн нуугдмал, удаан орших байдлыг улам нэмэгдүүлэх талтай. Цаашид гэр бүлийн орчинд хүүхэд хүмүүжүүлэх эерэг хандлагатай холбогдсон мэдлэг мэдээллийг сайтар түгээх шаардлагатай байна.

Ид шидийн орон – 2 төвийн үйл ажиллагааны тухай мэдлэг, талуудын өгсөн үнэлгээ, цаашдын хэрэгцээ: ИШО-2 төв нь цаашид хүүхэд хамгааллын чиглэлээр хүчирхийлэл, хүүхдийн эрхийн сургалт, танин мэдүүлэх ажил өрнүүлэх болон сэтгэл зүйчтэй болох, хүүхэд хөгжлийн чиглэлээр сургалтын анги дүүргэлтийг нэмэгдүүлэх, дугуйлангийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүнд хэрэгцээтэй байна.



**ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСЛҮҮД**

“ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES) ТӨСЛИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН “НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ СУДАЛГАА”

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Монгол Улсын Баруун бүсийн сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутгийн хүн амын амьжиргааны өнөөгийн түвшин, тэдгээрийн олон янз байдал, орон нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр, тулгамдаж буй асуудлыг сум болон өрхийн түвшинд тус тус тодорхойлоход оршино.




2020

11-р сар

2021

12-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Баяннуур, Булган, Дэлүүн сумд
Завхан аймгийн Дөрвөлжин сум
Увс аймгийн Өмнөговь, Наранбулаг сумд
Ховд аймгийн 16 сумд (Жаргалант сумаас бусад сумд)*

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүрүүд нь ан амьтан, ургамлын олон зүйлүүдийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс юм. Биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд төрөөс нийт нутаг дэвсгэрийнхээ 30 орчим хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөц баялгийн хэт ашиглалт нь хамгаалалттай газар нутгийн сүлжээний биологийн олон янз байдал болон экосистемд эрсдэл учруулсаар байна.

Хөдөөгийн хүн амын нэлээд хэсэг нь Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн орчны бүс нутагт амьдардаг. Эдгээр бүс нутаг нь эрсдэлд орсноор тэдний амьжиргаанд ч мөн сөргөөр нөлөөлж байна. Уг гарааны нөхцөл байдлаас үүдэн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН) нь ХНБГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яамны захиалгаар Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай хамтран “Тусгай хамгаалалттай газар нутгуудад

дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь (SPACES) төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна. SPACES төсөл нь 4 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох Амьжиргааг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Нийгэм-Эдийн засгийн шинжилгээ ба суурь судалгаа”-ны ажлыг 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэлээ

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгаанд олон улсад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хэмжихэд ашигладаг “Аж байдлын индекс” аргачлалыг гол баримтлан ашиглаж өрхийн аж байдлын индексийг тооцсон. Индексийг тооцоход өрхийн удаан эдэлгээт эд зүйлс, тээврийн хэрэгсэл, мал, газар эзэмшил, сууцны төрөл, шинж байдал, нийтийн хэрэглээ үйлчилгээнд хамрагдалтын мэдээллийг ашигласан. Аж байдлын түвшнийг тооцохдоо хүчин зүйлийн шинжилгээ хийн, гаргаж ирсэн оноог 10 децильд хувааж, аж байдлын түвшний 5 бүлгийг тодорхойлсон.


Аж байдлын бүлэг

Аж байдлын түвшин	Нийт өрхийн эзлэх хувь
Доогуур	Хамгийн бага 20%
Дунджаас доогуур	30-40%
Дундаж	50-60%
Дунджаас дээгүүр	70-80%
Дээгүүр	Хамгийн өндөр 20% (90-100%)

Орон нутгийн амьжиргааны нөхцөл байдал, тэдгээрийн олон янз байдал, орон нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр, тулгамдаж буй асуудал бэрхшээлийг сум болон өрхийн түвшинд тодорхойлох зорилгоор “Амьжиргааны нөхцөл байдлын шинжилгээ” хийсэн. Энэхүү шинжилгээний хүрээнд таван капиталаар амьжиргааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үр дүнд нь тулгуурлан даван туулах стратегийг тодорхойлсон.

Доорх дүрсэд суурь судалгааны шинжилгээний хүрээг харууллаа.

Суурь судалгааны шинжилгээний хүрээ



Суурь судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан мэдээлэл цуглуулав. Тоон судалгаанд 1043 өрхийг хамруулсан. Харин чанарын судалгааны хүрээнд голлох мэргэжилтэнтэй гүнзгийрүүлсэн ярилцлага 72, эмзэг бүлгийн иргэдийн төлөөлөлтэй ФБЯ 8-ийг хийж мэдээлэл

цуглуулалтыг зохион байгуулсан. Тус суурь судалгаа нь КОВИД-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжсэн бөгөөд нөхцөл байдалтай уялдуулан мэдээлэл цуглуулалтыг талбарт болон утсаар хослуулан зохион байгуулсан.

ҮР ДҮН

Нийгэм-эдийн засгийн суурь судалгааны хүрээнд сонгогдсон бүс нутгаас 1043 өрхийн судалгаанд хамруулсан бөгөөд нийт өрхийн 53.6% нь сумын төвийн өрх, 23.2% нь хөдөөгийн өрх, 13.6% нь ТХГН-т оршин суудаг малчин өрх, 9.6% нь орчны бүсийн малчин өрх хамрагдсан байна. Судалгааны баг өрхийн аж байдлын түвшнийг тодорхойлох зорилгоор өрхийн удаан эвэлгээт эд зүйлс, тээврийн хэрэгсэл, мал газар эзэмшил, сууцны төрөл, шинж байдал, нийтийн хэрэглээ үйлчилгээнд хамрагдалтын мэдээллийг цуглуулсан. Аж байдлын түвшнийг өрхийн хэв маяг, өрхийн тэргүүний нас, хүйс, боловсролын түвшинтэй харьцуулсан харьцуулалтын үр дүнгээс дурдвал:

Аж байдлын түвшний үзүүлэлтүүд:

Өрхийн хэв маяг: Өрх толгойлсон болон ганц бие байх нь өрхийн аж байдлыг түвшин бууруулж байгаа ба өрх толгойлсон мөн ганц бие өрхийн аж байдлын түвшин бусад бүлгээс доогуур байна. Ганц бие өрхийн 47.1% , ганц бие эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн 46.2%, ганц бие эрэгтэй тэргүүнтэй өрхийн 30.0% аж байдлын түвшин доогуур байв.

Өрхийн тэргүүн эмэгтэй, өрх толгойлсон ганц бие байх нь өрхийн аж байдлын түвшин доогуур байгаа байдалтай шууд хамааралтай байдаг нь судалгааны үр дүнгээр батлагдаж байна.

Өрхийн тэргүүний хүйс: Өрхийн тэргүүний хүйс болон аж байдлын бүлэг хооронд ялгаа байгаа эсэхийг нийцтэй байдлын хи квадрат тестээр шалгахад p утга = 0.0004, хи квадрат тест p утга = 0.0002 гарснаар тус бүр статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн 47.0% нь аж байдлын түвшин хамгийн доогуур байгаа бол эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн 17.1% нь аж байдлын түвшин доогуур байна. Эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн 62.8% нь аж байдлын түвшин дундаж ба түүнээс дээш амьдарч байна.

Өрхийн тэргүүний нас: Өрхийн тэргүүний нас болон аж байдлын түвшний хооронд ялгаа байгаа эсэхийг вариацийн шинжилгээ хийнэ шалгахад (p утга=0.329) F критик муж=1.156 гарснаар ямар нэгэн статистик ач холбогдолгүй гарсан. 55-59 насны өрхийн тэргүүнтэй өрхийн 25.4% нь аж байдлын түвшин доогуур байгаа нь бусад бүлгээс хамгийн өндөр байгаа бол 35-39 насны өрхийн тэргүүнтэй өрхийн 25.9% нь аж байдлын түвшин дээгүүр байгаа нь насны бүлэг дотроо хамгийн өндөр байна.

Өрхийн тэргүүний боловсрол: Өрхийн тэргүүний боловсролоос хамааран аж байдлын түвшин харилцан адилгүй байна. Өрхийн тэргүүний боловсрол болон аж байдлын бүлэг хооронд ялгаа байгаа эсэхийг нийцтэй байдлын хи квадрат тест ашиглана шалгахад (p утга=0.0001) гарснаар статистикийн хувьд ач холбогдолтой байна. Судалгааны үр дүнгээс харвал боловсролгүй эсвэл бага боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхийн 38.0% нь аж байдлын түвшин доогуур, 22.1% нь дунджаас доогуур байгаа бол дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхийн 42.7% нь аж байдлын түвшин дээгүүр амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх (аж байдлын бүлгээр): Судалгааны үр дүнгээс харахад аж байдлын түвшин дундаж болон дунджаас доогуур өрхөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн 28.6% нь аж байдлын түвшин доогуур өрх, 20.9% нь аж байдлын түвшин дунджаас доогуур байгаа бол ердөө 12.1% нь аж байдлын түвшин дээгүүр амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх /аж байдлын бүлгээр/



Дүгнэлт, цаашдын чиглэл

Энэхүү төслийн үр дүнгийн тайлан боловсруулагдаж дууссан ч захиалагч талаас санал өгч эцэслэх үйл ажиллагаа хийгдэж байна. IRIM судалгааны хүрээлэнгийн боловсруулсан нийгэм-эдийн засгийн суурь судалгааны үр дүн SPACES төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэж найдаж байна.

“ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES) ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИЛЦААНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН “МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГЫН СУДАЛГАА”

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

SPACES төсөл нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийг урт хугацаанд хөгжүүлэх хүрээний нөхцөлийг сайжруулах зорилготой юм. Энэхүү зорилгын хүрээнд Байгаль орчны харилцааны бүрэлдэхүүн хэсгийн дагуу Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-ийн ажилтнууд, дотоодын жуулчдын (ялангуяа ТХГН-аар аялж буй) мэдлэгийг дээшлүүлэх, ТХГН-ийн онцлог шинж чанаруудын болон ёс зүйн дүрмийн талаарх зөв мэдээллийг сайжруулах зорилготой юм. Мэдлэг, хандлага, туршлагын судалгааны үндсэн зорилго нь:

- Зорилтот ТХГН-т мэдлэг, хандлага, туршлагын урьдчилсан ба дараах судалгааг хийх, төлөвлөх
- Мэдлэг, хандлага, туршлагын судалгааг байршлын онцлог, статистикийн ач холбогдолтой зорилтот ТХГН-т ганцаарчилсан ярилцлага хийх аргаар зохион байгуулах,
- Мэдлэг, хандлага, туршлагын урьдчилсан судалгааг хийж, ТХГН-ийн онцлог шинж чанар, ТХГН-тай холбоотой мэдээллийн суурь мэдээллийг боловсруулах юм.




2021

5-р сар

2021

11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар (ГТБЦГ)
Хан-Хэнтийн Улсын Тусгай Хамгаалалттай газар (ХХУТХГ)
Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газар (ОХБЦГ)*


ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН) болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ) нь 2019 оноос 2022 он хүртэлх хугацаанд “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн ерөнхий зорилго нь Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-ийн тогтвортой хөгжлийн хүрэн дэх нөхцөл байдлыг сайжруулах бөгөөд үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа юм. Энэхүү судалгаа нь SPACES төслийн дөрөв дэх үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээг дэмжиж, ТХГН-ийн ажилтнууд болон дотоодын жуулчдын мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэнэ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаанд дотоодын 1316 дотоодын аялагчид, ТХГН-ийн 147 ажилтныг хамруулж, тэдгээрийн мэдлэг, хандлага, туршлагын өнөөгийн түвшнийг үнэлэв. Мэдээлэл цуглуулалтыг ГОУХАН-тэй анх тохиролцсоны дагуу 2 төрлөөр зохион байгуулсан. Ингэхдээ зорилтот 3 ТХГН-т манай судлаачид хүрч ажиллан нийт 1,316 дотоодын аялагчдаас судалгаа авсан ба үүний дараа 147 ТХГН-ын ажилтнуудаас утсан судалгаа авсан.

Дотоодын аялагчид болон ТХГН ажилтнуудын мэдлэгийн түвшнийг үнэлэхдээ асуулга судалгаа зохион байгуулсан. Тодруулбал, судалгааны асуумж нь дор дүрсэд үзүүлсэнчлэн нийт 3 бүлэгтэй ба ерөнхий мэдлэгийн түвшнийг эдгээр бүлгүүдэд хамаарах агуулгаар мэдлэгийн түвшнийг нэгтгэн хэмжив. Судалгааны баг асуумжийн бүлэг тус бүрд арван оноо өгсөн ба энэ нь мэдлэгийг бүлэг тус бүрээр харьцуулахад илүү хялбар болгож буй юм. Иймд нийлбэр оноо нь хамгийн дээд талдаа 30 байж болох бөгөөд энэ нь ерөнхий мэдлэгийн түвшнийг илтгэх болно.



ГОЛ ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ

Мэдлэг тодорхойлох аргачлалын дагуу нийт 30 онооноос дотоодын аялагчид 11.72 оноо, ТХГН-ийн ажилтнууд 19.2 оноо авлаа. Энэ нь дотоодын аялагчидтай харьцуулбал ТХГН-ийн ажилтнууд харьцангуй өндөр мэдлэгтэй байгааг илтгэж байна. Гэвч энэ үзүүлэлт нь эдгээр судалгаанд хамрагдсан бүлгүүдийн ерөнхий мэдлэг, хандлага болон дадлын түвшин хангалттай өндөр биш байгааг харуулж байна.

Доор дүрсэд харуулсанчлан дотоодын аялагчдын хаана зорчиж буйгаас үл хамааран мэдлэгийн түвшин нь харьцуулагдахуйц ижил байсан. Жишээлбэл, ОХБЦГ болон ХХУТХГ-т аялж буй оролцогчдын нэгдсэн оноо нь 11.8 байсан ба харин ГТБЦГ-т аялж буй оролцогчид 11.7 оноотой байна. Дээр харуулсан дүрсээс гурван дэд хэсэг бүрийн (ТХГН бүрээр) оноог харах боломжтой. Дундаж онооноос дүгнэн үзвэл оролцогчид ТХГН-ийн шинж тэмдгүүдийн талаар илүү мэдлэгтэй байсан бол Ёс зүйн дүрэм дээр харьцангуй бага мэдлэгтэй байна.

Дэд бүлэг тус бүрийн талаар цааш дэлгэрүүлэн авч үзвэл:


Дэд бүлэг 1. ТХГН-уудын хамгаалалт

ТХГН-уудын хамгаалалт дэд бүлэг нь нийт 4 асуултаас бүрдэх ба судалгаанд оролцогчдоос экосистем болон түүний хүнд өгөх ач холбогдлын талаар мөн ТХГН байгуулагдах болсон шалтгаануудыг нээлттэй хариулт бүхий асуултаудаар дамжуулан асуусан юм. Тус дэд бүлэгт авч болох боломжит 10 онооноос дотоодын аялагчид 3.96 оноо авсан бол ТХГН ажилтнууд 5.65 оноо авсан байна.

Дотоодын аялагчдын дундаж оноо нь тэдний хүн ам зүйн шинж чанар болон аль ТХГН зочилсноос хамааран өөрчлөгдөж байв. Тухайлбал, ГТБЦГ болон ОХБЦГ аялж буй оролцогчдын ТХГН-уудын хамгаалалтын талаарх мэдлэгийн түвшин 4.36 болон 3.45 байсан бол ХХУТХГ-т аялагчдын мэдлэг харьцангуй бага буюу 3.27 байв.

Дэд бүлэг 2. ТХГН-ийн бүрэлдэхүүн хэсгүүд

ТХГН-ийн бүрэлдэхүүн хэсгүүд дэд бүлэг нь нийт 4 асуултаас бүрдэх ба тухайн ТХГН-т байрлах түүх болон соёлын дурсгалт газрууд, нуур, голууд, амьтад болон ургамлуудын талаар асуусан. Тус дэд бүлэгт дотоодын аялагчдын авсан дундаж оноо 5.03 байсан бол ажилтнууд 8.43 оноо авчээ. Энэ нь судалгаанд оролцогчид ТХГН-ийн хамгаалалтаас илүүтэйгээр "ТХГН-ийн бүрэлдэхүүн хэсэг"-ийн талаар өндөр мэдлэгтэй байв. "ТХГН бүрэлдэхүүн хэсэг"-ийн талаар асуухад аялагчид тухайн ТХГН-ийн дурсгалт газар, гол, нуур, ургамлаас илүүтэй амьтны нэрийг сайн мэдэж байв. Харин үүнийг газар зүйн байршлаар харахад ХХУТХГ-т аялж байсан аялагчид илүү мэдлэг өндөртэй байсан. Ерөнхийдөө амьтдыг эс тооцвол зөв нэр өгсөн дундаж тоо нь боломжит онооны 50%-д хүрсэн байна.



Дэд бүлэг 3. Ёс зүйн дүрэмтэй холбоотой мэдлэг


Ёс зүйн дүрмийн талаарх мэдлэгийн түвшин гэдэг нь тухайн ТХГН-т хэрхэн зүй зохистой аялах талаар асуултуудаас бүрдсэн ба нийт 6 асуулттай. Тус дэд бүлэгт дотоодын аялагчид 10-аас 2.78 байсан бол ажилтнууд 5.12 оноо авсан байна. Энэ хэсэгт оролцогчид хэдий зөв хариулсан боловч өгсөн зөв хариултын тоо шаардлагатай хариултын тоонд хүрэхгүй бол бүтэн оноогоо авах боломжгүй байсан. Тиймээс аялагчид ёс зүйн дүрмийн талаар ойлголтоотой хэдий ч бүрэн мэдлэгтэй биш, харин ажилтнууд энэхүү дэд бүлгийн талаар илүү мэдлэг өндөртэй байна.

Мэдээллийн эх сурвалж

Үндсэн гурван дэд бүлгээс гадна дотоодын аялагч болон ажилтнуудад мэдээлэл өгөх зорилго бүхий сэтгүүлүүд болох "Гоо Монгол", "Цэлмэг, Цэнгэг хоёр мод тарьсан нь" болон "Цоохор найз"-ыг харсан болон уншсан оролцогчдын хувийг гаргахыг зорьсон ба энэ нь цаашлаад тухайн ТХГН-ийн талаар мэдээллийг оролцогчид ямар эх сурвалж ашиглаж түлхүү авдгийг тодорхойлох зорилготой байсан юм. Эдгээр гурван сэтгүүлийг

харсан болон уншсан оролцогчдын хувь маш бага байсан ба үүнд оролцогчдын 0.9% (ажилтнуудын 18.4%) нь Гоо Монгол, 0.8% (ажилтнуудын 10.2%) нь Цэлмэг, Цэнгэг хоёр мод тарьсан нь болон 1.1% (ажилтнуудын 29.3%) нь Цоохор найз сэтгүүлүүдийг тус бүр харсан болон уншиж байжээ. Харин оролцогчдын 80% гаруй, ажилтнуудын 70% нь эдгээр сэтгүүлүүдийг харж болон уншиж байгаагүй гэдгээ мэдэгдсэн.

Үүнээс харахад эдгээр сэтгүүлүүд нь зорилтот бүлэгтээ хангалттай хүрч чадахгүй байгааг илтгэж байна. Аялагчдын ихэнх нь буюу 58.6% нь эдгээр ТХГН-уудад зочлохоосоо өмнө мэдээлэл аваагүй байдаг талаар дурдсан юм. Тэднээс ТХГН-уудын талаар хаанаас мэдээлэл авсан талаар асуухад хамгийн түгээмэл өгсөн хариултауд нь аман (албан бус) мэдээллээр (23.4%), интернэтээс (14.0%) болон олон нийтийн сүлжээнээс (11.0%) авсан гэжээ. Аман буюу албан бус байдлаар мэдээлэл авсан аялагчдын хувьд нас болон хүйсээс хамаарсан ялгаа алга байна. Харин интернэт болон олон нийтийн сүлжээ ашиглан мэдээлэл авсан хүмүүс нь илүү залуу хүмүүс байна. Тиймээс зорилтот бүлгээс шалтгаалан ТХГН-уудын талаарх мэдээллийг авах эх сурвалжуудыг олон янзаар бэлтгэх шаардлагатай юм.



МОНГОЛ УЛСАД ГАМШГИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Хөгжлийн Банк

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь Монгол Улсад “Эрт зарлан мэдээлэх тогтолцоо”-г цогц байдлаар хөгжүүлэх явдал бөгөөд дараах хоёр зорилгод хүрэх замаар төслийн үндсэн зорилгыг хангана. Үүнд:

- Олон төрлийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцооны ХШҮ ба мэдээлэл тархах системийг бий болгох,
- Тус тогтолцоонд хамрах байгууллага болон олон нийтийн чадавхыг бэхжүүлэх.




2020

9-р сар

2022

4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улс (Улаанбаатар хот, 21 аймаг)

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Олон төрлийн аюулаас эрт зарлан мэдээлэх систем (ОТАЭЗМС) нь уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмтгий гэж тодорхойлсон бөгөөд уг систем нь үүнд дээр тулгуурлан мэдээлдэг байна. Уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмтгий бус гэдэг тодорхойлолтод газар хөдлөлт хамаарагдах боловч газар хөдлөлтийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй, гагцхүү газар хөдлөлт бий болоход маш богино хугацаа шаарддаг тул ОТАЭЗМС нь урьдчилан зарлаж, аль эсвэл бууруулах чадавх дутагдалтай.

Энэхүү хөрөнгө оруулалт нь Монгол Улсын ОТАЭЗМС-ны хэмжээнд хэрэгцээтэй байгаа асуудлыг тодорхойлох юм. Нийт 6 үе шатын хүрээнд төсөл явагдсан. Үүнд:

1. Одоогийн байгаа технологи болон шинэчлэн сайжруулсан технологийн хүрээнд хүртээмжтэй, эрт зарлан мэдээлэх системийг олон нийтэд хүргэх (ялангуяа хөдөө орон нутаг, малчдад),

2. Одоогийн системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (жишээ нь олон нийтэд зориулсан зарлан мэдээлэх цамхаг),
3. Шинэ систем гаргах (жишээ нь шууд нэвтрүүлэх телевиз, яаралтай үеийн телевиз болон радио зэрэг);
4. Гамшгийн хяналтын мэдээллийн системийг сайжруулах, дотоод нөөцийн систем, ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдэд тогтмол засвар үйлчилгээ хийх болон сайжруулах;
5. Хариу арга хэмжээг авахын тулд бэлэн байдлыг хангах;
6. ОБЕГ болон ОТАЭЗМС -ын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар олон нийтийн мэдлэгийг сайжруулж үйл ажиллагаанд ОТАЭЗМС-ыг оролцуулах юм.

Уг төсөлд манай байгууллага техникийн туслалцааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ:

- Техникийн зураг төслийг боловсруулж, техник эдийн засгийн үнэлгээ хийх. Үүний үр дүнд төслийн үйл ажиллагааг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж, төслийн үйл ажиллагаа нь хамаарах салбарыг хүртээмжтэй хөгжүүлэх, шилдэг туршлагыг уялдуулан хэрэгжихийн тулд төслийн техник эдийн засгийн үндэслэл, техникийн дизайны үнэлгээг хийнэ.
- Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч агентлагуудын техникийн болон төслийн менежментийн чадавхыг сайжруулах. Үүний үр дүнд төслийн бэлэн байдал, төслийн хэрэгжилтийг сайжруулахын тулд гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч агентлагуудын чадавхыг бэхжүүлнэ.
- Нийгэм, жендер, хамгааллын талаарх үнэлгээ, төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэх. Энэхүү үр дүн нь төсөлтэй холбоотой нийгмийн болон хамгааллын (нийгмийн болон хүрээлэн буй орчны) зохих шаардлагын үнэлгээ, урьдчилсан судалгааны төлөвлөлтөд дэмжлэг үзүүлнэ.
- Хэрэгжүүлэлтийн зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны багцыг бэлтгэх. Үүний үр дүнд төсөл боловсруулахад шаардагдах санхүү эдийн засгийн, болон засаглалын урьдчилсан судалгааг хянах, бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- COVID-19 цар тахлын тандан судалгааны системийг туршилтаар нэвтрүүлэх. Үүний үр дүнд тахлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн системийн нэг хэсэг болгох тохиромжтой тандалтын системийг туршиж, Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаатай нягт уялдуулан зохицуулахад тусална.
- Төслийн дизайныг бэлтгэсэн арга барилыг баримтжуулах, ноу-хау бий болгох. Үүний үр дүнд төслийн ерөнхий дизайны тоймыг гаргаж, арга барилыг илүү өргөн хүрээнд хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хүргэнэ.

ҮР ДҮН БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн хүлээгдэж буй үр нөлөө нь үндэсний болон орон нутгийн түвшний гамшгийн бэлэн байдлыг бэхжүүлж, Монгол Улсын гамшигт тэсвэртэй байдлыг нэмэгдүүлнэ. Ингэснээр төсөл нь дараах гол бодлогын баримт бичиг болох Монгол Улсын Алсын Хараа 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлого, Азийн Хөгжлийн Банкны 2030 оны стратегитай үр нөлөө нь уялдаж байна.

Баримт бичиг боловсруулах төслийн хүрээнд зээлийн төслийн баримт бичгийг боловсруулж, дараагийн төслийн үе шатанд доорх үр дүнг хүлээж байна.

Үр дүн 1: Улсын хэмжээнд эрт зарлан мэдээлэх систем бий болгоно.

Энэ зорилгын хүрээнд үндэсний гамшиг эрсдэлийн удирдлагын систем хэсэгт болон олон нийтийн дунд эрт илрүүлэлтийн системийг суулгах, олж илрүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах, хянах, аюулыг зарлах гэх мэт ажлууд орно. Үүний үр дүнд:

1. Улс, бүс нутаг, аймгийн Онцгой байдлын газар, зарлан мэдээллийн төвд яаралтай тусламжийн диспетчерийн төвүүдийг байгуулж, аюулын хяналт, урьдчилсан мэдээг ОБЕГ-ын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх системд нэгтгэх замаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;
2. Үүрэн өргөн нэвтрүүлгийн шинэ үйлчилгээг бий болгох, телевиз, олон нийтийн радио сувгаар дамжуулан гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх холбооны системийг боловсронгуй болгох, олон нийтийн зарлан мэдээлэх цамхгийн системийг өргөтгөх, Хөдөлгөөнт Холбоо Харилцааны Төв (ХХХТ) хөгжүүлэх, үүрэн холбоо бүхий холбооны нөөц системийг бэхжүүлэх төвүүд, дотоод сэрэмжлүүлгийн холбооны сувгийг бий болгох юм.


Эдгээр үйл ажиллагаа нь Монгол Улсад 6 үе шаттай ЭЗМС -ын төгсгөлийн мөчлөгийн 3-4 үе шат дахь чухал цоорхойг нөхөх яаралтай хэрэгцээг шийдвэрлэхэд тусална.

Үр дүн 2: Засгийн газар болон олон нийтийн Эрт зарлан мэдээлэх систем ба гамшгийн хүчин чадал сайжруулна.

Энэхүү үр дүн нь байгууллагын чадавх, олон нийтэд түшиглэсэн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хөгжүүлэх зорилготой. Энэ нь шийдвэр гаргах, харилцаа холбоо, зарлан мэдээлэл түгээх стратеги, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулахад ОБЕГ болон бусад ЭЗМС-ын байгууллагын чадавхыг нэмэгдүүлнэ. Гол үйл ажиллагаанууд нь:

1. Хот, гэр хороолол, хөдөөгийн зорилтот бүлгүүдийн олон төрлийн аюулын ЭЗМС болон ЖҮДҮБ Жендерийн Үр Дүнтэй Үзэлт Баримтлал чадавхыг бэхжүүлэх хөршийн бүлгүүдийг байгуулах,
2. Олон нийтэд сурталчлах кампанит ажлыг хөгжүүлэх,
3. Олон нийтээр дамжуулан эрт сэрэмжлүүлэг түгээх үр нөлөөг бэхжүүлэх зэрэг орно. болон байгууллагын доороос дээш чиглэсэн санал,
4. Олон нийтийн бэлэн байдлыг бэхжүүлэх,
5. ОБЕГ-ын эцэс төгсгөлтэй ЭЗМС-ын техникийн чадавхыг бэхжүүлэх,
6. Олон төрлийн аюулын ЭЗМС-ын талаар бусад оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх,
7. Гамшгийн менежмент, шийдвэрийг бэхжүүлэх. дэмжлэг үзүүлэх систем,
8. Сэрэмжлүүлэг түгээх үндэсний веб порталыг шинэчлэх/шинэчлэх,
9. Гамшгийн хэрэгцээ, нөөцийн мэдээллийн системийг (ГХНМС) бий болгох үйл ажиллагаанууд дараагийн төслийн үе шатанд хийгдэхээр төлөвлөгдөж байна.

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ: “ХУВИЙН ХЭВШИЛ БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ” ТУРШИЛТЫН ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь хувийн хэвшил болон их дээд сургуулиудын уялдааг холбоог бий болгох зорилготой. Төслийн зорилтууд нь:

- Хувийн хэвшлийн байгууллагууд болон их дээд сургуулиудын хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг судлах;
- Зорилтот салбар дахь төгсөгчдийн ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг тодорхойлох;
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны боломжийг тодорхойлох;
- Байнгын хэлэлцүүлгийн форум бий болгоход тулах замаар, хүний нөөцийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний чиглэлээр салбараас тодорхойлсон хэрэгцээг шийдвэрлэхэд их дээд сургуулиудад дэмжлэг үзүүлэх;
- Мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн төлөөлөл болон их дээд сургуулийн төлөөлүүдийн хооронд тогтмол зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.



2020

10-р сар

2021

4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУЯ) “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд оюутнуудад дээд боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх зорилт дэвшүүлжээ. Энэхүү баримт бичигт “хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч ба их, дээд сургуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах” гэж заасан.

2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр РЕКС Интернейшнл Инк.-ийн ЖАЙКА Төслийн баг (‘Үйлчлүүлэгч’) ба IRIM (‘Гэрээлэгч’) нар хамтран ‘Хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх’ туршилтын төслийг эхлүүлэхээр тохиролцов. Энэхүү туршилтын төслийг ‘Монгол Улсын Үндэсний Хөгжлийн Цогц Төлөвлөгөө (ҮХЦТ)-г боловсруулах’ төслийн хүрээнд хэрэгжүүлэв.

Туршилтын төслийн гол зорилго нь сонгогдсон салбарын хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хооронд санамж бичиг зурж баталгаажуулах замаар хамтын ажиллагааг бий болгож, бэхжүүлэх зорилго бүхий механизмуудыг бий болгох байв.

Энэхүү туршилтын төсөл нь ҮХЦТ-ний боловсролын салбарын хүрээнд хийгдэх төслүүдийн гол суурь төсөл болж байгаа юм. Тиймээс, туршилтын төсөл нь ҮХЦТ-ний үндсэн стратеги, аргачлалд заасны дагуу салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх замаар төрөлжсөн аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой байв.

Туршилтын төслийн загварт заасанчлан туршилтын төслийн эхний хоёр үе шат нь гурван салбарыг хамарсан. Үүнд:

- Тээвэр, логистик,
- Аялал жуулчлал,
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)

Судалгааны үр дүнд үндэслэн эдгээр гурван салбараас МХХТ-н салбарыг сонгон, оролцогч талуудын оролцоо, нөлөөлөл, тайлагналт гэх гуравдугаар үе шатанд үргэлжлүүлэн авч үлдэхээр сонгосон. Тиймээс, туршилтын төслийн гурав дах үе шатны хүрээнд МХХТ-ийн салбарт хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагаа бий болгох зорилгыг тавьж ажиллалаа.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг төсөл нь (1) бэлтгэл үе шат, (2) судалгааны ажил болон үзэл баримтлал боловсруулах үе шат, (3) оролцогч талуудыг холбох, нөлөөлөл, тайлагнах үе шат гэсэн гурван үндсэн үе шаттай даалгаврыг гүйцэтгэнэ. Эхний хоёр шатны үр дүнд IRIM нь хувийн хэвшил болон их дээд сургуулиудын хамтын ажиллагааны нөхцөл байдалд гол анхаарлаа хандуулж цогц судалгаа хийлээ. Ийнхүү мэдээлэл цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг гэсэн чанарын судалгааны аргуудыг ашигласан. Нийт 70 ганцаарчилсан ярилцлага, 6 фокус бүлгийн ярилцлага хийсэн. Оролцогч талуудыг холбох, нөлөөлөл, тайлагнах үе шатны хүрээнд төслийн баг мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор холбогдох оролцогч талуудын төлөөлөл болон мэдээллийн технологийн эрдэм шинжилгээний салбарын төлөөллүүдтэй цуврал зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж байна.

ҮР ДҮН

Туршилтын төслийн эхлэлтийн үе шатанд аялал жуулчлал, мэдээллийн технологи, тээвэр ба ложистик гэсэн гурван салбарын гол оролцогч талуудын дунд явуулсан судалгааны үр дүнд эрдэм шинжилгээний байгууллагууд болон аж үйлдвэр хоорондын уялдаа холбоо, хамтран ажиллах нөхцөл боломжийг үнэлж, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлсон. Судалгааны үр дүнд үндэслэн мэдээллийн технологийн салбарыг туршилтын төсөлд цаашид анхааран ажиллах гол салбараар сонгосон. Иймээс аж үйлдвэрийн салбар болон эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын уялдаа холбоог Монголын мэдээллийн технологийн салбарт туршиж үзэхээр болов. Туршилтын төслийн явцад их сургуулиуд, салбарын төлөөлөл, төрийн байгууллагууд, мэдээллийн технологийн салбар, төрийн бус байгууллагуудын бүх гол оролцогч талууд төслийн бүх үйл ажиллагаанд оролцсон. Үүнд судалгааны ажлын үр дүнг түгээх, их дээд сургууль болон хувийн хэвшил хоорондын уялдаа холбоог бий болгох хэд хэдэн зөвлөлдөх уулзалтууд багтана. Хэлэлцүүлгийн үр дүнд их дээд сургуулийн эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн салбарын төлөөллүүд, оролцогч талууд их сургууль болон хувийн хэвшил хоорондын уялдаа харилцаа холбоог бий болгох санамж бичигт гарын үсэг зурсан.

Санамж бичиг зурах үйл ажиллагаанд Монголын мэдээллийн технологийн салбар дах аж үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал нөлөө бүхий дараах талуудыг хамруулсан. Оролцогч талуудын үүрэг оролцоо нь:

- Эрдэм шинжилгээний байгууллага: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль нь эрдэм шинжилгээний байгууллагаа төлөөлөн 'Үндсэн Баг'-т орох бөгөөд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль болон Хөдөө Аж Ахуйн Их Сургууль нь Зөвлөлдөх Талууд болно.
- Аж үйлдвэр: Аж үйлдвэр талаас Ай Си Ти Групп ХК нь хувийн хэвшлээ төлөөлөн Үндсэн багт орох бөгөөд Голомт банк, Интерактив ХХК нь Зөвлөлдөх Талууд болно.
- Төрийн байгууллага: Төрийн байгууллагуудыг төлөөлж Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газар, Стратегийн Бодлого, Төлөвлөлтийн Газар нь Үндсэн багт орох бөгөөд Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Бодлого төлөвлөлтийн газар, Мэдээллийн Технологи, статистикийн хэлтэс нь Зөвлөлдөх тал болно.
- Ажиглагч: Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл болон Мэдээллийн Технологийн Үндэсний Парк нь ажиглагчийн байр сууринаас оролцох болно.


Төслийн үр дүнд бий болсон хамтын ажиллагааны платформыг зөвлөлдөх талуудын оролцоотойгоор цаашид тогтвортой авч явах шаардлагатай гэж үзсэн. Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлуудыг удирдан зохион байгуулах, Нарийн Бичгийн гол үүргийг Монголын Программ Хангамж Үйлдвэрлэгчдийн Холбоо хүлээх бөгөөд эдгээр талуудын хамтын ажиллагааг гэрчилж энэхүү санамж бичгийг баталгаажуулсан болно. IRIM судалгааны хүрээлэн нь уг төсөлт ажлыг эхлэхээс дуусах хүртэл төлөвлөгдсөн бүх ажлыг гүйцэтгэн дараагийн алхам руу шилжихэд амжилттай хүлээлгэн өгсөн.



2020 10-р сар

2021 5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ




Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд болон Увс, Булган, Сэлэнгэ, Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, бичил бизнес эрхлэгчдийг хамруулсан.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Тус судалгааны арга зүй нь КОРЕ Глобал болон Азийн Сангийн хамтран боловсруулсан “5С”-ийн үзэл баримтлалын хүрээнд үндэслэн боловсруулагдсан. Энэхүү арга зүй нь иргэдэд хүрч буй капиталын хүртээмж, тэдгээрээс олж авч буй чадамжуудад нөлөөлж буй хүчин зүйлсэд КОВИД-19 цар тахал ямар үр нөлөө үзүүлж буйг судлахад чиглэсэн.

Монгол дахь Азийн сангийн хамрах хүрээ



“Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх нь” (ЭЭЧБ) төслийн удирдлага, Азийн Сангийн зөвлөхүүд, IRIM судалгааны хүрээлэнгийн баг хамтран зөвлөлдсөний дагуу уг үзэл баримтлалын төсөлд хамгийн их хамааралтай бүрэлдэхүүн хэсгүүд дээр төвлөрч, судалгаагаа явуулах шийдвэр гаргасан.

Үнэлгээ нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн ба үүнд Зураг 2-т үзүүлсний дагуу тоон ба чанарын судалгаа багтсан болно.

Бүрэлдэхүүн 1:
Тоон судалгаа

SAT1 аргыг ашиглан 400 зорилтот оролцогчдоос судалгаа авсан. Тоон судалгаанд зөвхөн эмэгтэй бизнес эрхлэгчид хамрагдсан.

Бүрэлдэхүүн 2:
Чанарын судалгаа

Зорилтот оролцогчидтой 24 кэйс судалгаа болон 48 хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийсэн. Чанарын судалгаанд эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчид тэгш хамрагдсан.

ҮР ДҮН

COVID-19 цар тахлын үед ихэнх эмэгтэй эзэдтэй бизнесүүдийн нийлүүлэлтийн сүлжээ тасарч, худалдаа, үйлдвэрлэлийн хэмжээ нь буурч, зарим тохиолдолд түр болон бүр мөсөн бизнесээ зогсоох эсвэл ажилчдаа халахад хүрсэн байна. Хэдийгээр хөл хорио нь бүхий л салбарт ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн ч, салбарын онцлогоосоо шалтгаалан үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарууд хамгийн их алдагдлыг амссан. Судалгааны үр дүнд, гэр бүлгүй ганц бие эмэгтэйчүүд илүүтэй бизнесээ бүр зогсоосон байхад гэр бүлтэй эмэгтэйчүүд гэр бүлийнхнээсээ дэмжлэг авч байжээ.

Цар тахлын үед эмэгтэйчүүдийн цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэдэг ажил үүрэг улам нэмэгдсэн байна. Хэдийгээр зарим эмэгтэйчүүд гэр бүлийнхэнтэйгээ их цаг өнгөрөөх боломжтой болсон гэж хариулсан нь эерэг үр дүн мэт боловч, нөгөөтээгүүр бизнесийн үйл ажиллагаа нь багасаж орлого буурсан, мөн эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдсэн гэж үзжээ. Оролцогчдын 8% нь сөрөг, заналхийлсэн, дарамталсан хандлагатай нүүр тулсан гэсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд энэхүү хандлагатай 2-3 дахин их тулгардаг байна. Зарим эмэгтэйчүүдийн хувьд бизнесийн орлого буурах нь гэр бүлийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлжээ.

Төрөөс COVID-19 цар тахлын үед бизнес эрхлэгчдэд үзүүлсэн дэмжлэг нь жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгчдэд хүрч, шаардлагатай дэмжлэг болж чадаагүй байна. Цар тахлын үед төрийн зүгээс үзүүлж байсан албан дэмжлэг туслалцааг (татварын хөнгөлөлт, мөнгөн тусламж г.м) эдгээр эмэгтэйчүүд хүртэж чадаагүй нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн бус хүрээлэл болох найз нөхөд, хөрш, хамт ажилладаг хүмүүсийн дэмжлэг их чухал гэж үзэж байгаа ч, харамсалтай нь тэд ямар нэгэн холбоо эсвэл хүрээлэлд гишүүнчлэлгүй байна.

Хөл хорионы үеийн бизнесийн үйл ажиллагааны доголдлыг дагаад санхүүгийн байдал нь улам хүндэрсэн байна. Бизнес эрхлэгчдийн орлого буурч, зардал нь өсөж, өр зээл, түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон гэж мэдээлсэн. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд цар тахлын өмнө ч санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай байсан. Тэд бизнесээ тэлж албан ёсны болгоход барьцаа хөрөнгө байхгүй, зээлийн хүү нь хэт өндөр байсан зэрэг хүндрэл бэрхшээлүүдийг дурдав. Харин эрчүүдийн хувьд барьцаа хөрөнгө нь нэг их асуудал болдоггүй гэсэн байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан мэдээллийн хүртээмж дутмаг байна. Санал асуулгад хамрагдсан эмэгтэйчүүдийн 90 хувь нь салбарынхаа мэдээллийг хэрхэн авахаа мэддэггүй гэжээ. Гэр бүлийн байдал, бизнесийн байршил, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг хүчин зүйлээс үл хамааран ерөнхийдөө эмэгтэйчүүдийн дунд мэргэжлийн болон салбарын тухай мэдлэг, ойлголт дутмаг байна. Тиймээс дийлэнх эмэгтэйчүүд бизнесийн холбогдолтой мэдлэг чадвараа дээшлүүлэх сонирхолтой байна. Тухайлбал, санал асуулгад оролцогчдын 60-аас дээш хувь нь албан бүртгэл, НӨАТ, татвар гэх мэт төрийн удирдлагатай холбоотой мэдлэгээ дээшлүүлэх, мөн оюуны өмч, бизнесийн стратеги, борлуулалтын стратеги, санхүүгийн менежмент, түгээлт, болон зах зээлийн судалгаа хэрхэн хийх талаар сурах сонирхолтой гэжээ.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДААТГАЛААР ДАМЖУУЛАН УУР АМЬСГАЛД ТЭСВЭРТЭЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ (KLIMALEZ)



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Шилжилтийн Эдийн Засаг дахь Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Лейбниц Институт

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг төсөл нь даатгалын шинэ зах зээлийг ашиглан цаг уурын эрсдэл, ялангуяа ганг даван туулах Төв Азийн хөдөө аж ахуйн салбарын чадавхыг нэмэгдүүлэх зорилготой юм. Төслийн хүрээнд Казакстан, Тажикстан, Монгол зэрэг Төв Азийн хэд хэдэн оронд улаан буудайн тариалан эрхлэгчдийн 2020 оны тариалан эрхлэлт болон, даатгалын талаар хандлагыг судалсан бөгөөд Монгол Улс дахь мэдээлэл цуглуулалтын ажлыг IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэв.




2021

6-р сар

2021

9-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Архангай, Булган, Дархан-Уул аймаг, Дорнод, Завхан, Орхон, Сэлэнгэ,
Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл болон Хэнтий аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын хувьд Үндэсний Давхар Даатгал компани нь 2019 оноос эхлэн улаан буудайн даатгал болон өөр төрлийн индексжүүлсэн даатгал хийж ирсэн арга туршлага дээрээ үндэслэн “Улаан буудайн индексжүүлсэн даатгал”-ыг Герман Улсын Шилжилтийн Эдийн Засгийн Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Лейбниц Институт (IAMO) болон Герман Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөлтэй хамтран нэвтрүүлж, 387 ААН, иргэдийг уг даатгалд хамруулсан. Энэхүү даатгал нь улаан буудай тариалагч иргэд, аж ахуй нэгжийг байгаль цаг уурын урьдчилан сэргийлэх аргагүй таагүй нөхцөлөөс болж ургац алдах, улмаар санхүүгийн хохирол амсах эрсдэлээс хамгаалах даатгал юм. Судалгааны үр дүнд тулгуурлан IAMO байгууллага нь сансрын хиймэл дагуулын цуглуулсан ургамлын ургалтын мэдээн дээрээс үндэслэн хохирлын үнэлгээг хийж, нөхөн төлбөр олгодог гар утасны аппликейшн боловсруулна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Дэлхийн Банкны дата багийн хөгжүүлсэн Survey Solution платформыг ашиглан зохион байгуулсан. Захиалагч байгууллагын зүгээс уг платформ дээр ажиллах тусгай зааварчилгааг судалгааны багт өгсөн. Доорх зурагт судалгааны багийн бүтэц болон мэдээлэл цуглуулалтын гол үйл явцыг харуулав.




#	Аймаг	Даатгалд хамрагдсан	Даатгалд хамрагдаагүй	Нийт
1	Архангай	4	9	13
2	Булган	33	56	89
3	Дархан-Уул	11	18	29
4	Дорнод	6	2	8
5	Завхан	2	1	3
6	Орхон	2	5	7
7	Өвөрхангай	5	6	11
8	Сэлэнгэ	62	100	162
9	Төв	19	31	50
10	Увс	62	60	122
11	Хөвсгөл	11	19	30
12	Хэнтий	14	3	17
Нийт		233	308	541

Судалгааны баг Survey Solution платформыг ашиглан 12 аймгийн тариалан эрхлэгч 541 хувь хүн болон аж ахуйн нэгжийн 2020 оны газар тариалан болон ургацад суурилсан даатгалын талаарх мэдлэг хандлагыг нь судлах мэдээлэл цуглуулсан. КОВИД-19 цар тахлын улмаас мэдээлэл цуглуулалтыг талбарт зохион байгуулах боломжгүй болж, дуудлагын төвөөр дамжуулан судалгааг гүйцэтгэсэн.

ҮР ДҮН ДҮГНЭЛТ

Судалгааны баг уг төслийн мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэж, захиалагчид датаг хүлээлгэн өгсөн бөгөөд захиалагчаас төслийн үр дүнгийн талаар зарим мэдээллийг хүлээн авсан. KlimALEZ төсөл нь судалгааны үр дүнд үндэслэн цаг уурын үйлчилгээ үзүүлдэг нээлттэй платформыг бий болгосон. Андройд дээр суурилсан гар утасны аппликейшн одоогоор боловсруулагдаж байна. Мөн KlimALEZ баг 2021 оны 11-р сард бизнес, улс төр, судалгааны оролцогч талуудад төслийн үр дүнг танилцуулах цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төслийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор нэвтрэн авах боломжтой: <https://www.klimalez.org/home/>

ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ТҮҮНИЙ 2016-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Захиалагч: Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Санхүүжүүлэгч: Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага

НҮБ-ын Хүн Амын Сан

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (ТХАХТББ) болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийн биелэлтийг системтэйгээр үнэлэхэд оршино. Үнэлгээний хүрээнд дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн:


- ТХАХТББ, түүний хүрээнд 2018-2020 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн нийцтэй байдал, уялдаатай байдал, үр дүн, үр ашиг, үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлэх.
- Үнэлгээнээс гарсан үр дүн, сургамжуудыг нэгтгэн дүгнэж, цаашид бодлогын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмж гаргах.
- ТХАХТББ-ын шинээр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хууль (ХБТУТХ), Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг, КОВИД-19 цар тахалтай холбогдуулан засгийн газраас авч хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдох уялдаа холбоог хянах (шаардлагатай тохиолдолд бодлогын өөрчлөлтийн талаар санал оруулах)



2020 12-р сар

2021 8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Налайх дүүрэг болон
Хөвсгөл, Говьсүмбэр аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

УИХ-аас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (ХБТТУТ)- хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 5-р сарын 7-ны өдөр баталсан бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, оролцогчдын эрх үүргийг боловсронгуй болгож, бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт, шинжилгээ хийх механизмыг тусгасан.

Ингэхдээ нэгдмэл ерөнхий зарчмын хүрээнд урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангахыг зорьж байгаа бөгөөд уг хуулийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2020 оны 45 дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Үүний дагуу Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (ТХАХТББ)-ын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх, хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, санал зөвлөмжид үндэслэн ТХАХТББ-ыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний

удирдлагын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлага үүссэний хүрээнд уг төсөл хэрэгжих болсон.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээг хамааралтай байдал, үр ашигтай байдал, үр дүнтэй байдал, үр нөлөөтэй байдал, тогтвортой байдал, уялдаа холбоотой байдал, КОВИД-19 цар тахлын нөлөө гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэсэн.

Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан мэдээлэл цуглуулсан.

Чанарын судалгааны мэдээллийг голчлон баримт бичгийн судалгаан дээр үндэслэсэн бөгөөд төр, иргэний нийгмийн салбарын мэргэжилтнүүд, экспертүүдтэй хийсэн ярилцлагаар баяжуулав. Нийт 64 ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Чанарын судалгааны түүвэр



Бодлогын үр шим хүртээгчдээс авсан тоон судалгааны түүвэр

Судалгаанд хамруулсан бүлэг	Аймаг/ Дүүрэг				Нийт
	Налайх	Сонгинохайрхан	Говьсүмбэр	Хөвсгөл	
Залуу гэр бүл	30	30	15	15	90
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн/асран хамгаалагч	30	30	30	30	120
Ахмад настан	30	30	30	30	120
Малчин	-	-	15	15	30
Нийт судалгаанд хамрагдагчдын тоо					360

Зорилтот талбаруудад оршин суудаг иргэдээс бага насны буюу 5-аас доош насны хүүхэдтэй гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний асран хамгаалагч, тэтгэврийн насны ахмад настан, малчин гэсэн бүлгийн 360 төлөөллөөс цар тахлын нөхцөл байдалд уялдуулан утсаар мэдээлэл цуглуулсан. Доорх хүснэгтэд тоон судалгааны түүврийн бүрдлийг нэгтгэн харуулав.

ҮР ДҮН

Төрөөс Хүн амын Хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)-ын тэргүүлэх чиглэл, хэрэгцээ шаардлага нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын Хараа -2050", Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтууд болон үндсэн зарчим, чиглэлүүдтэй нийцэж байна. Мөн ТХАХТББ-н дунд хугацааны чиглэл, зорилтууд нь 2019 онд зохион байгуулагдсан "Хүн ам ба хөгжил-25" Найробигийн дээд хэмжээний хуралд Монгол Улсын Засгийн Газраас ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр танилцуулсан үндсэн 5 амлалттай нийцтэй байна. Үүнээс харвал ТХАХТББ-ын зорилго, зорилтууд ач холбогдолтой, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод хамааралтай хэвээр байна.

ТХАХТББ-ын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт: "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт тодорхойлсон 6 чиглэл, 55 зорилтын хэрэгжилтийг 15 шалгуур тодорхойлж, үр дүнг үнэлнэ гэж тусгасан. Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтээс үзвэл "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын чиглэл, зорилтын хэрэгжилт дунд хугацаанд үр дүнтэй бус гэж дүгнэлээ.

ТХАХТББ-ын хүрээнд тодорхойлсон 55 зорилт, 109 үйл ажиллагааны хэрэгжилт: Бодлогын дунд хугацааны хэрэгжилт буюу 2020 онд хүрсэн түвшнийг 55 зорилтын биелэлтээр авч үзэх боломжтой хэдий ч 25 зорилт нь шалгуур үзүүлэлтгүй, 24 зорилт нь хэмжигдэхүйц бус байна. Энэ нь тухайн бодлогын явц, хэрэгжилтийн төлөв байдлыг үр дүнд суурилсан байдлаар үнэлж, дүгнэх боломжгүйд хүргэж байна.

ТХАХТББ-ыг хэрэгжүүлэх төсөв, хүний нөөц: 2016-2018 онуудад нийт 109 үйл ажиллагаанаас 12 үйл ажиллагааны төсөв, худалдан авалт зэргийн мэдээлэл нь тусгагдсан бол 2019 оны тайланд 19 үйл ажиллагааны төсвийн мэдээлэл тусгагдсан байна. Бодлогыг хэрэгжүүлэх тусгайлсан төсөв санхүүгийн тайланд тодорч харагдахгүй байна. Мөн энэ чиглэлээр хүний нөөцийн чадавхыг

бэхжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, мэргэшсэн ажилтныг бэлтгэж, мэдлэг, мэргэшлийг нь дээшлүүлэх зүйл заалтууд хэрэгжээгүй байна.

ТХАХТББ-ыг хэрэгжүүлэх талууд, тэдний хамтын ажиллагаа: Нийт 109 үйл ажиллагаанаас 4-5 үйл ажиллагаа л салбар хоорондын хамтын ажиллагааг онцолсон. Хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ) л уг бодлогыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх юм шиг ойлгогдож байгаа ч нийт 109 үйл ажиллагаанаас зөвхөн 39-д нь оролцож хэрэгжилтийг шууд хариуцна гэжээ. ХНХЯ-д салбар дундын уялдаа зохицуулах чиг үүрэг бүхий Хүн амын асуудлаар үндэсний хороо байгуулагдсан нь сайн талтай боловч салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр үйл ажиллагааг нь тогтмолжуулах шаардлага байна.

ТХАХТББ-ын тогтвортой байдал: Хүн амын хөгжлийн бодлого нь дунд хугацааны баримт бичигтэй нийцэж мөн хэрэгжүүлэгч байгууллагууд нь тогтсон боловсон хүчин, төсөв хөрөнгө, удирдамжтай ажиллаж байгаа тул тогтвортой байдал хангагдсан гэж дүгнэж байна.

ТХАХТББ-ын хэрэгжилтэд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөө: КОВИД-19 гарснаар төсөв санхүүжилтийг зогсоогоогүй хэдий ч сургалтын төсөв хумигдсан байна. Төлөвлөсөн сургалтууд цуцлагдаж, цахим хэлбэрт шилжсэнээр иргэдийн идэвх буурчээ. Улаанбаатар хотын хувьд эрүүл мэндийн байгууллагад ажиллагчид КОВИД-19-ын үеийн шинжилгээ, оношилгооны үйл ажиллагаанд дайчлагдсанаар эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа хүргэх, үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн ажлууд орхигдсон.

ТХАХТББ-ын ил тод байдал: ТХАХТББ-ын үнэлгээний ажлын хүрээнд үнэлгээний багийн зүгээс энэхүү бодлогын оролцогч талууд болох яамд, хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагуудын веб хуудас руу орж бодлоготой холбоотой баримт бичиг, төсөв төлөвлөгөө, тодорхой албан тушаалтнуудын мэдээллийг олж авах шаардлага үүссэн. Яамдын веб хуудсанд энэ талаар мэдээлэл огт байгаагүй. Харин хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг олж авахад харьцангуй боломжтой байсан учраас энэ тал дээр ямар нэг асуудал тулгараагүй.

Мөн байгууллагуудын веб сайт дээр шилэн дансны мэдээлэл байгаа боловч ТХАХТББ-той холбоотой батлагдсан төсөв, зарцуулалтын талаар мэдээлэл байхгүй байна.

Үнэлгээний үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах талуудад дэлгэрэнгүй санал зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. УИХ, Засгийн Газрын түвшинд
2. Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон салбарын яамны түвшинд

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон үнэлэх хүрээнд, мөн бодлогын 6 чиглэл тус бүрээр ерөнхий зөвлөмжийг гаргасан ба ТХАХТББ болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яаманд өгсөн.

“ОЙТ ХЭЭРИЙН ЭКОСИСТЕМ БОЛОН ХОВОРДОЖ БУЙ АМЬТДЫГ НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ



Эх сурвалж: ZSL

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэгээс Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-т оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар ОНТХГ -ын жишиг менежментийг бий болгох зорилгоор 2018 оны 7 сараас 2021 оны 3 сар хүртэл хугацаанд хэрэгжүүлсэн төслийн эцсийн үр дүнг үнэлэхэд судалгааны зорилго оршино.

Судалгааны баг зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудын дагуу мэдээллээ цуглууллаа. Үүнд:


- Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг үнэлэх
- Хойд Могойн гол орчмын биологийн олон янз байдалд гарсан үр нөлөөг шинжлэх,
- Байгаль хамгаалал, тогтвортой хөгжил, байгалийн нөөцийг зохистой, тэгш, хүртээмжтэй ашиглах талаар орон нутгийн иргэд ямар үзэл бодол, хандлагатай болсныг тодорхойлохыг зорьсон.



2021 1-р сар

2021 3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Архангай аймгийн Булган сум

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)-ээс 2018 оны 7 сараас 2021 оны 3-р сарын хугацаанд “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийг хэрэгжүүлсэн. Архангай аймгийн Булган сум нь ойт хээрийн экосистемийн төлөөлөл бөгөөд газарзүйн байршлын хувьд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд хамаардаг. Энэ бүс нутаг аймгийн төвтэй ойр байршдаг тул хулгайн мод, хулгайн ангийн хэрэг түгээмэл гардаг ба мөн бэлчээрийн доройтолд өртсөн бүс нутаг болсон нь тус газрыг сонгон төслөө хэрэгжүүлэхэд үндэслэл болсон. Төсөл хэрэгжиж эхлэх үеийн суурь судалгааг IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэж байсан бөгөөд 3 жилийн хугацаанд хэрэгжсэн энэхүү төслийн эцсийн үр дүнг үнэлж, суурь судалгаатай харьцуулах нь судалгааны гол зорилго байв.

СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Судалгааны үр дүнг баталгаажуулж, давхар шалгах болон олон талуудын байр сууриудыг илэрхийлэх, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зорилгоор судалгаанд тоон болон чанарын аргуудыг хослуулан ашигласан.

Тоон өгөгдөл: Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-ын 150 өрхийг түүвэрлэн анхдагч тоон өгөгдөл цуглууллаа. Тоон судалгааны аргын хувьд төслийн суурь судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой байх үүднээс орон нутгийн иргэдийн амьжиргааг үнэлэхдээ Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ)-ийг өргөн хүрээнд ашигласан. ОХЯИ нь: (1) олон хэмжээст ядууралд өртсөн хүн амын харьцаа, мөн (2) тэдний гачигдал хомсдолын жинлэгдсэн дундаж харьцаа гэсэн хоёр мэдээллийг хослуулан ядуурлын гүнзгийрлийг хэмждэг.

Чанарын өгөгдөл: Төслийн талаар гол мэдээлэл өгөх иргэд, нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч зэрэг оролцогч талуудаас хагас бүтэцлэгдсэн ярилцлага авч, анхлагч мэдээллийг цуглууллаа.

Судалгааны ажлын 3 зорилтын хүрээнд дараах аргачлалын дагуу судалгааны ажлыг зохион байгуулсан.

(1) Судалгааны эхний зорилт бол Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг үнэлж, төсөл эхэлж байсан 2018 онд хийгдсэн суурь судалгаа-ны үр дүн болон улсын, бүсийн, орон нутгийн бусад иргэдийн амьжиргаатай харьцуулах явдал юм. Энэ зорилт жендерийн эрх, тэгш байдлыг хангаж, баталгаат ажлын байрыг бий болгох замаар ядуурлыг бууруулж, өлсгөлөнг зогсоох, эдийн засгийн өсөлтийг бий болгох Тогтвортой хөгжлийн зорилгуудтай илүү уялдаатай байв. Суурь болон эцсийн үр дүнг хооронд нь харьцуулахын тулд суурь судалгаанд ашигласан ОХЯИ байгуулах арга зүйгээр төслөөс үр шим хүртэгчдийн нийгэм, эдийн засгийн байдлыг тоон үзүүлэлтээр харьцуулав.

Суурь судалгаанаас ялгаатай нь эцсийн үр дүнг үнэлэхдээ ОХЯИ-д нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох регрессийн шинжилгээ хийв. Ингэснээр өрхийн тэргүүний хүн ам зүйн үзүүлэлтээс хамаарч тухайн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал ялгаатай эсэхийг тодорхойлох боломж бүрдсэн юм. Түүнчлэн, энэ хэсэгт баримт, бичгийн судалгаа хийж, төслөөс үр шим хүртэгчийн нөхцөл байдлыг тухайн орон нутгийн бусад иргэдтэй харьцуулан дүгнэлээ.

(2) Судалгааны хоёр дахь гол зорилт нь төслийн үйл ажиллагаа бүрийн хэрэгжилт, үр нөлөөг логик хүрээний дагуу үнэлж, дүгнэх явдал байв. Энэ зорилтыг хангахын тулд судалгааны баг төслийн баримт бичгүүд, холбогдох материалуудыг судалж, нийт 5 зорилт, 21 шалгуур бүхий логик хүрээний дагуу төслийн үйл ажиллагаа бүрийн үр дүнг тоон болон чанарын судалгааны арга зүй ашиглан үнэлсэн юм. Уг үнэлгээгээ суурь онтой харьцуулан дүгнэсэн болно.

(3) Гурав дахь гол зорилт бол иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг үнэлэх явдал байв. Уг зорилтдоо хүрэхийн тулд судалгааны баг 150 өрхөөс авсан асуулгын өгөгдлийг ашиглан энгийн статистик шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, вариацийн шинжилгээ хийлээ.

ҮР ДҮН

Төсөл хэрэгжсэнээр өрхийн нийгэм, эдийн засгийн байдалд ямар өөрчлөлт гарсныг судалгааны баг (1) ОХЯИ тооцож, суурь оны индекстэй харьцуулан (2) өрхөөс авсан асуулга, бусад оролцогч талуудаас авсан ярилцлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар төслийн нийгэм, эдийн засгийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийг үнэлсэн.

ОХЯИ тооцоололт, суурь оны индекстэй харьцуулсан шинжилгээ:

Эцсийн шатны судалгаанд ОХЯИ-ийг 150 өрхийн түүвэр өгөгдлийг ашиглан боловсрол, эрүүл мэнд, амьжиргааны түвшин гэсэн 3 бүлэг, 10 дэд үзүүлэлтийг 0, 1 гэсэн утга оноон тооцооллоо. Уг аргачлалын дагуу 10 дэд үзүүлэлт тус бүрд 0, 1 гэсэн утга оноохдоо:

- Суралцсан жилийн хувьд тухайн өрхөд бага боловсрол буюу 5 жилийн боловсрол эзэмшээгүй хүн байдаг бол 1,
- Сургуульд хамрагдалтын хувьд хэрвээ тухайн өрхөд 6-14 насны сургууль завсардсан хүүхэд байдаг бол 1,
- Таваас доош насны хүүхэд эндсэн тохиолдол байгаа бол 1 гэсэн оноог тус тус өгсөн.

Эдгээр 10 дэд үзүүлэлт тус бүрийн аль нэг дээр 1 гэсэн оноо авч байгаа бол тухайн өрх олон хэмжээсний хувьд ядууралд өртсөн гэсэн үг. Дараах хүснэгтэд ядуурлын онооны үр дүнг харуулсан бөгөөд түүвэрт хамрагдсан 150 өрхөөс 10 дэд үзүүлэлт тус бүрээр 1 гэсэн оноо авсан өрхийг тоог харуулсан. Тухайлбал, эцсийн шатны судалгаагаар 44 өрхөд бага ангийн боловсрол эзэмшээгүй хүн байгаа нь хүснэгтээс харагдаж байна

Ядууралд өртсөн өрхийн нөхцөл байдал

	Үзүүлэлтүүд	Ядууралд өртсөн өрхийн тоо		Нийт өрхөд эзлэх хувь	
		Суурь шат	Эцсийн шат	Суурь шат	Эцсийн шат
А	Боловсрол				
1	Суралцсан жил	42	44	28%	29.3%
2	Сургуульд хамрагдалт	5	2	3%	1.3%
Б	Эрүүл мэнд				
3	Нялхсын эндэгдэл	0	7	0%	4.7%
4	Хоол хүнсний шим тэжээл	5	2	3%	1.3%
В	Амьжиргааны түвшин				
5	Цахилгаан	2	1	1%	0.7%
6	Ундны ус	145	98	97%	65.3%
7	Ариун цэврийн нөхцөл	143	60	95%	40%
8	Гэр, байр, орон сууцны шал	32	85	21%	56.7%
9	Хоол унд хийх түлш	149	147	99%	98%
10	Өмч хөрөнгийн эзэмшил	54	0	36%	0%

1. Гол үр дүнг нэгтгэвэл ОХЯИ суурь шатанд 0.115 байсан бол эцсийн шатанд 0.084 болж, 0.031 функтээр буурчээ. Тодруулбал, олон хэмжээсээр тооцсон ядуу хүмүүсийн нийт хүний тоонд эзлэх хувь суурь шатнаас эцсийн шатанд 0.297-оос 0.229 болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, суурь шатанд судалгаанд оролцсон нийт хүний 29.7% нь ядуу байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 22.9% болж буурчээ. Олон хэмжээст ядуурлын эрчимжилт суурь шатнаас эцсийн шатанд 0.389-өөс 0.365 болж, 0.024 функтээр мөн буурсан буюу суурь шатанд ядууралд өртсөн өрхүүдийн 38.9% нь нийт үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол эцсийн шатанд уг үзүүлэлт 36.5% болж буурсан гэсэн үг.

Ийнхүү дэд хоёр индекс хоёул тодорхой хэмжээгээр буурсан нь ОХЯИ эцсийн дүн буурахад нөлөөлөв.

2. ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлын өөрчлөлтийг авч үзвэл ОХЯИ суурь онд 0.115 байсан бол эцсийн үнэлгээгээр 0.084 болж, буурсан байна. Тодруулбал, ядуурлын

индекс буурна гэдэг нь суурь онтой харьцуулахад тухайн орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал сайжирсныг илтгэнэ. Нөхөрлөлийн гишүүн өрхийн амьжиргаа дээшилсэн болон хивэндээ байсан хувь нь нөхөрлөлийн гишүүн бус өрхтэй харьцуулахад өндөр байгаа тул уг төсөл өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна гэж дүгнэх боломжтой юм.

Дүгнэвэл суурь шатнаас эцсийн шатны хооронд төслийн хэрэгжих хугацаанд олон хэмжээст ядуурлын индекс буурсан нь түүвэрт хамрагдсан өрхүүдийн хувьд амьдрал чанар ерөнхий утгаараа сайжирчээ. Гэхдээ ОХЯИ тооцоход ашиглаж буй 10 дэд үзүүлэлтийн 7 үзүүлэлт сайжирсан буюу олон хэмжээсний хувьд ядууралд өртсөн өрхийн тоо буурсан, харин 3 үзүүлэлтийн хувьд муудсан дүнтэй байгааг тэмдэглэх нь зүйтэй. ОХЯИ-ийн хоёр бүрэлдэхүүн индекс хоёулаа буурсан нь түүвэрт хамрагдсан өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал сайжирсныг ахин батлан харууллаа.

Судалгааны шат	Олон хэмжээст ядуурлын индекс	Олон хэмжээсний хувьд ядуу хүмүүсийн нийт хүний тоонд эзлэх %	Олон хэмжээст ядуурлын эрчимжилт	Ядууралд өртсөн хүний тоо
Суурь судалгаа	0.115	0.297	0.389	175
Эцсийн судалгаа	0.084	0.229	0.365	151

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦЫН МОНГОЛ ДАХЬ УУЛ УУРХАЙ, УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫН ЭЦСИЙН ШАТНЫ СУДАЛГАА



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Олон Улсын Санхүүгийн Корпораци

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Эцсийн шатны судалгааны зорилго нь уул уурхайн компаниудын усыг хамгаалах, ил тод байдлыг хангах үүрэг амлалтаа биелүүлэх байдал болон уул уурхайгаас усны менежментэд үзүүлэх нөлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагад гарсан ахиц дэвшлийг тодорхойлох юм. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

- Орон нутгийн усан хангамжид уул уурхайн салбарын үзүүлж буй нөлөөллийн талаарх иргэдийн ойлголтыг судлах
- 2013 онд хийгдсэн суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад тэдний ойлголт, санаа бодол өөрчлөгдсөн, сайжирсан эсэхийг үнэлэх
- Үүнд ОУСК-ийн хэрэгжүүлсэн төсөл (сургалт, хэлэлцүүлэг гэх мэт), уул уурхайн компаниудын үйл ажиллагаа (олон нийтэд хүрч ажиллах гэх мэт), Засгийн газрын санаачилгууд нөлөөлсөн эсэхийг тодруулах юм.




2021

3-р сар

2021

7-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Өмнөговь аймгийн 15 сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК) нь 2014 оноос эхлэн уул уурхайн компаниудын орон нутаг дахь усны менежмент дэх оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн усны менежментийн талаар ойлголт, хандлагыг сайжруулах зорилготой төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Уг төслийн хүрээнд 2014-2018 оны хооронд Өмнөговь аймгийн 15 сумын иргэдэд усны менежментийн талаар суурь ойлголт олгох, талуудын оролцоог бий болгох зорилготой цуврал сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. IRIM судалгааны хүрээлэн нь уг төслийн суурь судалгаа болон мониторинг судалгааг 2013, 2018 онуудад хэрэгжүүлсэн ба төслийн эцсийн шатны судалгааг 2021 онд зохион байгууллаа.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Эцсийн шатны судалгаанд уг төслийн үр нөлөөг тодорхойлохын тулд Өмнөговь аймгийн 15 сумын төлөөлөл 1071 иргэдээс тоон аргаар судалгаа авсан ба орон нутгийн Байгаль орчны мэргэжилтнүүд болон уул уурхайн компаниудын 27 мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Судалгааны түүвэр

Тоон арга

Өмнөговь аймгийн 15 сумын 1071 иргэн (43% эрэгтэй 57% эмэгтэй) (үүнээс 33.7% нь малчин)

Чанарын судалгаа

27 ганцаарчилсан ярилцлага (орон нутгийн засаг дарга, байгаль орчны мэргэжилтэн - 8 уул уурхайн компаниудын байгаль орчны мэргэжилтэн - 19)

ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын усны хэрэглээ 2013-2021 онд эрс нэмэгдсэн. Харин хүртээмж, чанарын талаарх ойлголт нь нэмэгдээгүй байна.

2013 оны суурь судалгааны үр дүнгээс харахад, ердөө 17 оролцогч нь ундны усны хүртээмжид нөлөөлж буй хүчин зүйлд зөвшөөрөлтэй уул уурхайн нөлөөллийг “бага” гэж үзсэн бол 2021 онд энэ тоо хоёр дахин нэмэгдэж, 34 оролцогч уг хариултыг өгчээ. Уул уурхайн нөлөөллийг бага гэж үзсэн хүмүүсийн тоо нэмэгдсэн нь сайн боловч зөвшөөрөлтэй уул уурхайн нөлөөлөл “маш их” гэж хариулсан хүмүүсийн тоо долоогоор (261 болж 268) нэмэгдсэн байна.

Харьцуулалтыг сайжруулах үүднээс судалгаанд оролцогчдын мэдлэг, хандлагын жинлэсэн

дунджийг тодорхойлсон. Бүх тохиолдолд жинлэсэн дундаж нь 3.0-аас 3.6 хооронд байна (“их”-ийг “маш их”-тэй нэгтгэсэнтэй тэнцэнэ). 2013 оноос хойш нэгээс бусад тохиолдолд “дундаж” мэдлэг, хандлагын түвшин бага зэрэг буурсан (0.4 хүртэл) байна.

Өмнөговь аймгийн усны хүртээмж болон чанарт уул уурхай (болон бусад хүчин зүйлс)-н үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаанд оролцогчдын мэдлэг, хандлага 2013-2021 оны хугацаанд бага зэрэг нэмэгдсэн байна. Гэвч энэ хугацаанд малын тоо толгой (олон судалгаанд оролцогчдын орлогын гол эх үүсвэр) болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ихээхэн нэмэгдсэн нь усны хүртээмж, чанарт мөн нөлөөлж байна.

Судалгаанд оролцогчдын усны хэрэглээ (литр/өдөр)

Зорилго	Суурь судалгаа 2013 он	Эцсийн судалгаа 2021 он	Ойлголт, хандлага
Ундны ус	10	20	Хүртээмж болон чанар өөрчлөгдөөгүй (ундны усны хувьд)
Ахуйн хэрэглээний ус	20/30	30/40	
Ажлын хэрэглээний ус	500-1,000	1,000-3,000	

Хариуцах хүчин зүйлсийн нөлөөллийн талаарх судалгаанд оролцогчдын мэдлэг, хандлага

Ундны усны хүртээмж		Мэдлэг, хандлага				Жинлэсэн дундаж
		Бага	Дунд	Их	Маш их	
Зөвшөөрөлтэй уул уурхай	2013	17	53	240	261	3.3
	2021	34	104	209	268	3.2
	Ялгаа	17	51	-31	7	
Зөвшөөрөлгүй уул уурхай	2013	7	27	143	97	3.2
	2021	23	38	88	106	3.1
	Ялгаа	16	11	-55	9	

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Австрали Монголын Эрдэс Баялгийн Салбарын Хамтын Ажиллагааны Хөтөлбөр

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгааг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангах чиглэлээр оролцогч талуудын санаа бодлыг нэгтгэх зорилгоор гүйцэтгэсэн.




2021

4-р сар

2021

5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Баянхонгор, Өмнөговь, Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Төв, Дундговь, Увс, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа 34 байршил

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

АМЕП 2 хөтөлбөрийг Австралийн Гадаад Хэрэг, Худалдааны Яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл зөвлөх компани хэрэгжүүлсэн. Энэхүү судалгааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-нд олон нийтийн оролцоог хангах журмыг боловсронгуй болгох шаардлагын үндсэн дээр уг журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангах чиглэлээр оролцогч талуудын санаа бодлыг нэгтгэх зорилгоор гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааг чанарын судалгааны арга болох гүнзгийрүүлсэн ярилцлагаар гүйцэтгэсэн. Судалгааны асуултууд нь БОНБУ-нд оролцоог хангаж буй байдал, БОНБУ-ний оролцоог хангах хэсгийг хэрхэн зохион байгуулдаг талаарх туршлага, ойлголт, мэдээлэл, оролцоог хангахтай холбоотой гол бэрхшээлүүд, оролцогч талуудын эрх үүрэг, харилцаанд тулгарч буй бэрхшээл, давуу талууд, үнэлгээг хийхэд ашигладаг тодорхой аргууд, аргачлал, сайн туршлагууд, журамд оруулах өөрчлөлтийн хувилбарын саналууд болон цаашид сайжруулах тодорхой санаа, шийдэл гэсэн сэдвүүдийн хүрээнд боловсруулагдсан.

Судалгаанд нийт 13 аймаг, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 34 байршил хамрагдсан байна. Судалгаанд дараах төлөөллүүдийг хамруулав.


Оролцогч талууд, түүврийн хэмжээ, түүврийн шалгуур

№	Оролцогч талууд	Оролцогчдын тоо	Сонголт хийсэн шалгуур
1	Үнэлгээний компаниуд	30	Сүүлийн 3-5 жил хэд хэдэн чиглэлд үнэлгээ хийсэн компаниуд болон бие даасан үнэлгээний мэргэжилтнүүд
2	Уул уурхайн компаниуд	30	Сүүлийн 3-5 жилд үнэлгээ хийлгэсэн болон томоохон компаниуд
3	Бусад салбарын компаниуд	10	Сүүлийн 3-5 жилд үнэлгээ хийлгэсэн болон томоохон компаниуд
4	Сум дүүргийн удирдлага	10	Сүүлийн 2-3 жилд 2-оос дээш үнэлгээ хийгдсэн сум, дүүрэг
5	Баг, хорооны Засаг дарга, ИНХ-ын дарга	20	Сүүлийн 2-3 жилд 2-оос дээш үнэлгээ хийгдсэн баг, хороо
6	Иргэний нийгэм, ТББ-ын төлөөлөл	5	Сүүлийн 5-10 жилд байгаль орчин, уул уурхай, иргэдийн оролцооны чиглэлээр тогтвортой ажиллаж ирсэн
7	Салбарын/мэргэжлийн байгууллагууд	5	Уул уурхай болон БОНБУ хийгддэг голлох салбарын дээвэр холбоод, мэргэжлийн байгууллага
8	Орон нутгийн иргэдийн төлөөлөл	5	Уул уурхай, дэд бүтэц, хүнд үйлдвэрийн хэд хэдэн төслийн үнэлгээ орон нутгийн иргэн
Нийт		115	-

ҮР ДҮН

IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд үр дүн, тайлан бэлтгэх шатанд оролцоогүй болно.

“БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД ТӨВ ТӨСӨЛ”-ИЙН ЭЦСИЙН ШАТНЫ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

Солютек систем корпораци

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Эцсийн шатны судалгааны гол зорилго нь төслийн үр шим хүртэгчдийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд болон бизнесийн нөхцөл байдал, түүнд гарсан өөрчлөлтүүд, төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ач холбогдол, сэтгэл ханамж, хэрэгцээтэй байдал, хэрэгжилт, төслөөс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чадавхад үзүүлсэн үр нөлөө, төслийн цаашдын тогтвортой байдалд үзүүлэх хүчин зүйлсийг үнэлэх явдал юм. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:


- Төслийн үр шим х хүртэгчдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон 'Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв' тө сөлд хамрагдсан байдлыг тодорхойлох;
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, гарсан өөрчлөлтүүд, түүний үр нөлөөг тодорхойлох;
- Төслийн хэрэгжүүлсэн 18 төрлийн үйл ажиллагааны ач холбогдол, сэтгэл ханамж, хэрэгцээтэй байдал, хэрэгжилтийг үнэлэх;
- Төслийн зүгээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хувь хүний бизнес эрхлэх ур чадвар болон бизнесийн үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг үнэлэх;
- Төслийн цаашдын тогтвортой байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж боловсруулах.



2021 4-р сар

2021 5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын 6 дүүрэг (Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Баянгол)

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Бизнесийн томоохон байгууллагуудад эрэгтэйчүүд давамгайлдаг бол жижиг дунд үйлдвэрлэлийн (ЖДҮ) 64%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хэдийгээр ЖДҮ-ийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо арай өндөр байгаа ч тэдэнд бизнесийн болон удирдлагын арга туршлага, мэдээлэл, танилын сүлжээ дутмаг, цагийн хомсдол их, эмэгтэйчүүдийг хувийн хэвшилд манлайлахад соёлын хэм хэмжээ садаа болж байгаагаас гадна барьцаа хөрөнгө байхгүйн улмаас санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх, мөн цалин хөлсгүй өрхийн бизнест ажиллагчдын 75.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа талаар олон улсын байгууллагын судалгаануудад дурджээ.

УСХ-ны 2020 оны мэдээллээр Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ)-д эрэгтэйчүүд 65.1%, эмэгтэйчүүд 50%-тай байна. Мөн бүх насны бүлэгт АХОТ эрэгтэйчүүдийнх илүү, ялангуяа 30-34 насны бүлэгт хамгийн их буюу 26.7 пунктын зөрүүтэй байгаа нь эмэгтэйчүүд энэ насанд хүүхэд төрүүлэх, асрах зорилгоор ажиллах хүчний эгнээнээс гардаг бөгөөд хүүхдүүд нь өсөж томрохын хэрээр ажиллах хүчний эгнээнд

эргэн ордог байна. Эдгээр нийгэм-эдийн засаг, биологийн хүчин зүйлс эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд ороход саад учруулсаар байна. Дээр дурдаагүй олон шалтгаан бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгарч байгаагаас гадна цаг үеийн нөхцөл байдал буюу COVID-19 цар тахал бизнесүүдэд сөргөөр нөлөөлсөөр байна.

Эдгээр сорилтуудыг даван туулахад эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, тэднийг бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд нь туслах, хотын эдийн засагт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготойгоор НЗДТГ, Азийн Сан хамтран БНСУ-ын КОЙКА ОУБ-ын санхүүжилтээр Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв (БЭЭТ) төслийг 2016 оны 07-р сард эхлүүлсэн. Энэ төсөл нь амжилттай хэрэгжсэнээр II-р шатыг 2018-2020 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн ба энэ судалгаа нь төслийн II-р шатны үр дүнг хэмжсэн юм.

Судалгааны дизайн

Оролцогчид	2018 БЭЭТ-I төслийн эцсийн судалгаа	2021 БЭЭТ-II төслийн эцсийн судалгаа	Өөрчлөлт
	A_1	A_2	$A_2 - A_1 = X_1$

A1-2018 БЭЭТ-I төслийн эцсийн судалгаа, A2-2021 БЭЭТ-II төслийн эцсийн судалгаа, X1—өөрчлөлт

СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүргээс “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд төв” төслийн үр шим хүртэгчид болон төслийн үйл ажиллагаанд хамрагдсан 261 эмэгтэйчүүд хамрагдсан.

Эцсийн судалгааны ажлын ерөнхий дизайн нь төслийн хоёр шатны эцсийн судалгааны үр дүнг харьцуулах бөгөөд мэдээлэл нь хугацааны хувьд хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц байх зарчимд голлон анхаарсан. Судалгааны мэдээлэл цуглуулалт нь зорилтот талбарт чиглэгдэж буй тул байршил болон оролцогчдын хооронд харьцуулалт хийх нь чухал биш юм.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Эцсийн шатны судалгааны үр дүнгээс үзвэл БЭЭТ-ийн үзүүлдэг бүхий л үйлчилгээг оролцогчид ерөнхийдөө чухал ач холбогдолтой буюу 4.4 хэмээн үзэж байна. Оролцогчид бүх үйл ажиллагааны ач холбогдлыг 4.0-өөс дээш үнэлсэн нь төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд хэрэгцээтэй, нийцтэй байгааг харуулж байна.

БЭЭТ төслийн талаарх ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 4.1 буюу “сэтгэл ханамж өндөр” хэмээн үнэлсэн. Төслийн үр шим хүртэгчид төслийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ач холбогдлыг өндрөөр үнэлж байгаа ч, тэдгээрийн үр дүн дэх сэтгэл ханамж арай бага байна.

Нарийвчлан харвал, жендерийн сургалт болон мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн сургалтууд сэдвийн хувьд ач холбогдол өндөртэй боловч, сэтгэл ханамж хүлээлтээс бага зэрэг доогуур, онлайн сургалт, зөвлөгөөнүүд, худалдааны үйл ажиллагаанд өгч буй ач холбогдолтой харьцуулахад сэтгэл ханамж илүү өндөр байна. Онлайн худалдааны платформ болон компьютерын лаборатори зэрэг МХХТ-д чиглэсэн үйл ажиллагааны ач холбогдол болон сэтгэл ханамжийн түвшин ижил байгаа нь хүлээлттэй нь нийцсэнийг харуулж байна.


Төслийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн дундаж (1-5 оноо)



БЭЭТ төслийн 1-р шатны эцсийн судалгаанд хувь хүний чадавхтай холбоотой бизнесийн талаарх мэдлэг, ур чадвар дутмаг, үйл ажиллагаатай холбоотой ур чадварууд, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ зэрэг асуудлууд хамгийн чухалд тооцогдож байв. Төслийн 2-р

шатны үр дүнг өмнөх шатны судалгааны дүнтэй харьцуулбал мөн ижил багаар ажиллах ур чадвар, борлуулалтаа нэмэгдүүлэх мэдлэг, санхүүгийн талын мэдлэгүүд хамгийн их нэмэгдсэн гэж үнэлжээ.

Хувь хүний бизнесийн мэдлэг, ур чадварт гарсан өөрчлөлтийн үр дүнг, %



Бизнесийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн үр дүн, %



Өмнөх шатны үр дүнтэй харьцуулахад хамтран ажиллах болон олон нийтийн сүлжээ ашиглаж борлуулалт хийх зэрэг ур чадварууд дээр илүү их ахиц гарсан. Энэ зэрэг өөрчлөлтүүд нь инкубаторын харилцагчид дээр илүү их мэдрэгдэж 70% орчим байхад, бусад эмэгтэйчүүдийн 40% орчимд энэ зэрэг өөрчлөлтүүд мэдрэгдэж, тал хувьд нь ямар нэг өөрчлөлтгүй хивэндээ гэж үнэлжээ.

Дүгнэлт

- Эмэгтэйчүүд ихэвчлэн бичил, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид бөгөөд гол төлөв хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарт, тэр дундаа оёдол, худалдаа үйлчилгээний салбарт түлхүү ажиллаж байна. Төслийн 1-р шатны үр дүнтэй харьцуулахад бизнесийн орлого ихэнх салбаруудад буурсан (19 чиглэлийн 14 нь) байгаа нь COVID-19 цар тахалтай шууд холбоотой.
- Ихэнх бизнесийн орлого буурч, үйл ажиллагаа нь бүрэн явагдахгүй байгаа ч БЭЭТ төслийн үр шимээр МХХТ-ийн мэдлэг ур чадвар, онлайн орчинд бизнес эрхлэх олон чадваруудыг эзэмшсэнээрээ нийт оролцогчдын 30.7% нь бизнесээ онлайн хэлбэрт шилжүүлэн амжилттай ажиллаж байна.

- Бизнес, санхүү, МХХТ-ийн зөвлөгөөнүүд үр шим хүртэгчдийн хэрэгцээ болон сэтгэл ханамжид илүү нийцсэн байна.
- Төслийн үр шим хүртэгчдийн хувьд эрчимжүүлсэн инкубатор хөтөлбөрт хамрагдах сонирхол өндөр байна.
- Худалдааны үйл ажиллагаанд оролцогчдын 89.6% нь уг үйл ажиллагааны ач холбогдлыг өндрөөр үнэлж, 87% нь сэтгэл ханамжтай байна.
- Төслийн хоёрдугаар шатанд мэдээллийн технологид суурилсан арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн нь үр дүнд хүрсэн байна.
- Компьютерын лабораторийг дүүргийн ЖДҮДТ үүдийг түшиглэн байгуулсан нь оновчтой шийдэл болсон байна.
- Төслийн үр дүнгийн ерөнхий үнэлгээ 3.53 дундаас дээш түвшинд үнэлэгдлээ.
- Эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд ирээдүйд бизнесээ өргөжүүлэхэд нэн түрүүнд шаардлагатай зүйлс нь санхүүгийн дэмжлэг буюу бага хүүтэй зээл байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ: ХҮН ХУДАЛДААЛАХААС ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ НЬ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



World Vision



The Asia Foundation



World Vision



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ: “ХҮН ХУДАЛДААЛАХААС ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



УЛААНБААТАР
2021

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн зөн Монгол ОУБ

Азийн Сан

Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Тус суурь судалгааны зорилго нь Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг тодорхойлж засгийн газар болон ИНБ-уудад зөвлөмж боловсруулах, олон нийтийн ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлохыг зорьсон. Энэ зорилгын хүрээнд хоёр үндсэн зорилтыг хангахаар ажиллав. Үүнд:

- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Суурь судалгааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлох




2021

4-р сар

2021

11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Улаанбаатар хотын Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг
Дорноговь аймгийн Замын-Үүд сум
Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум*

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл буюу “Хүн худалдаалах” гэмт хэргээр сүүлийн 3 жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоог авч үзвэл, нийт 38 хэрэгт 131 хохирогч тогтоогдсоны 35% нь насанд хүрээгүй 14-18 хүртэлх насны хохирогч байна. Хэргийн үйлдэгдсэн хэлбэрийг авч үзвэл бүгд бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн байх боловч хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, хөдөлмөр мөлжлөгийн хэлбэрүүдийг ХХГХ-т тооцохгүй байгааг ТББ-ууд онцолсон байна. Хүүхэд худалдаалах гэмт хэргийн үйлдэгдэж буй аргыг авч үзвэл гадаадад хэлний бэлтгэлд зуучлах, сургуульд тэтгэлгээр суралцуулах, өндөр цалинтай ажилд зуучлах, зар гаргах, түүнчлэн БНХАУ руу мал маллуулах, уралдааны морь унуулах, урлагийн үзүүлбэр үзүүлэх (уран нугараач) зорилгоор хуурч мэхлэн гадаад улсад хүчээр албадан хөдөлмөр хийлгэх, биеийг үнэлүүлэх, хилийн чанадад энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Мөн хүүхдээр гуйлга гуйх, хулгай хийх болон хурдан морь унах, мал маллах, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга зэрэг эдийн засгийн албан бус салбарт албадан байдлаар хөдөлмөр

эрхэлж байгааг АНУ-ын Төрийн департаментын 2020 оны тайланд дурджээ.

2020 оны 4 дүгээр сард АНУ-ын Засгийн Газар болон Монгол Улсын Засгийн Газар Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ (2020-2024)-г байгуулсан. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих энэхүү түншлэл нь МУЗГ, холбогдох яамд, төрийн, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх юм. Уг төслийг Дэлхийн зөн Монгол ОУБ болон Азийн сан хамтран хэрэгжүүлж байна. IRIM судалгааны хүрээлэн нь төслийн зорилго, зорилтуудын хүрээнд 2021 оны 4 дүгээр сараас 11 сарын хооронд Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар уг төслийн суурь судалгааг хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны ажлаар Монгол Улсад хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж төр болон иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудыг чадавхжуулахад чиглэсэн санал зөвлөмж боловсруулав. Суурь судалгаагаар дараах зорилгуудын хүрээнд суурь судалгааг гүйцэтгэсэн.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох


- Талуудын хамтын ажиллагааны өнөөгийн түвшнийг үнэлэх
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн түвшнийг үнэлэх
- Хохирогч хамгааллын үйлчилгээний зураглал гаргах
- Олон нийтийн ХХГХ-ийн талаарх ойлголт

Суурь судалгааны шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох

- Хилийн шалгалтаар илэрсэн, болон холбон зуучилсан ХХГХ-ийн байж болзошгүй хүүхдийн тоог тодорхойлох
- Урт болон богино хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоог тодорхойлох
- Бусдын дэмжлэггүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг авч чадна гэж хариулсан өрхийн хувийг тодорхойлох

Судалгааны арга зүй

Тус судалгааг тоон болон чанарын аргад үндэслэн гүйцэтгэсэн. Үүнд:



- 14-17 насны хүүхдүүд
- Нэг өрхийн эцэг эх, хүүхэд


- Төрийн албан хаагч (n=14)
- Үйлчилгээ үзүүлэгч ТББ (n=7)
- Түр хамгаалах байр, НЦҮТ (n=7)
- Олон улсын байгууллага (n=5)

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг тодорхойлохдоо ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр олон улсын конвенц,

баримт бичгүүдэд авч үздэг 4Р парадигмын дагуу судалгааны үр дүнг боловсруулж шинжилсэн.



Судалгааны хамрах хүрээ



КАР судалгааны загвар



Харин олон нийтийн ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг үнэлэхдээ КАР (мэдлэг, хандлага, дадал) загварыг ашигласан. Ингэхдээ арга зүйн хамрах хүрээний хувьд ХХГХ гэх ойлголтод төвлөрөхөөс гадна түүний төрөл хэлбэр болох (1) бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхдийг худалдаалах, (2) Хүүхдээр албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргүүдийг тусад нь судлагдахуун болгож авч үзсэн.

ҮР ДҮН

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй (ХХГХ)-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдал, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог үнэлж, холбогдох интервенцийг төлөвлөхөд ОУ-д ашиглагддаг 4P-ийн парадигм болох урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх болон хамтын ажиллагаа гэсэн үндсэн дөрвөн дэд бүлгийн хүрээнд судалгааг явуулсан.

Эдгээр дэд бүлгийн дагуу судалгааны үр дүнг дүгнэн үзвэл:

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Хөгжлийн бэрхшээл тэр дундаа сонсголын бэрхшээлтэй байх нь бүх төрлийн мэдээллээс хоцроход хүргэдэг. Гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг тэгш хүртэж чадахгүй байгаа нь тэднийг гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд оруулж болзошгүй байна.
- Хилийн хяналт шалгалтаар ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй тохиолдлыг илрүүлэх, хохирогч тогтоох албан ёсны стандарт байхгүй.
- Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо дутмаг. Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй, хоорондын хамтын ажиллагаа болон төслүүдийн залгамж халаа байхгүй.

Хохирогч хамгааллын чиглэлээр:

- Хууль тогтоомжид ХХГХ-т хохирогч хүүхдийг хэрхэн илрүүлэх, хамгаалах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг яаж үзүүлэх талаарх тусгайлан зохицуулалт байхгүй байна.
- Дэлхийн банкны төслийн хүрээнд Стандарт

хэмжилзүйн газраас 2013 онд ХХГХ –ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага стандарт MNS 6418:2013 батлагдан гарсан. Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх журамд хүүхдэд үзүүлэх үйлчилгээний зохицуулалт байхгүй байна. Гэрч хохирогч хамгаалах хуулийн хүрээнд хохирогч, гэрч нарт үзүүлэх хамгаалалтын арга хэмжээ тэр дундаа хууль зүйн, сэтгэл зүйн, эрүүл мэндийн, нийгмийн бусад туслалцааг үнэ төлбөргүй авах зохицуулалттай байдаг ч ХХГХ-ийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар тусгайлсан зохицуулалт дутмаг байна.

- Хохирогчдод үзүүлэх хууль зүйн туслалцаа, нэр төр аюулгүй байдал хамгаалах журам байхгүй.
- Хохирогчдод нийгмийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээний тухай зохицуулалт байдаггүй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:

- 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль баталсан. Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам өнөөг хүртэл батлагдаагүй.
- Шүүхийн статистикийн мэдээллийг цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдаж байгаа хэргийн тоон мэдээлэлтэй харьцуулан үзвэл шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй байна. Тодруулбал, 2017-2020 онд хүн худалдаалах 69, бэлгийн мөлжлөгийн 16, албадан хөдөлмөрлүүлэх 5, хүүхдээр гуйлга гуйлгах 1, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 55, хүүхэд худалдах 1, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах 1, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх 25 гэмт хэрэг бүртгэгдсэн ч шүүхээс хүн худалдаалах 13, бэлгийн мөлжлөг 2, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 7 хэргийг шийдвэрлэсэн байна.
- 2019 онд хүүхэд худалдах гэмт хэрэг 1, хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэрэг 1, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн ч одоогоор шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.

Хамтын ажиллагааны чиглэлээр:

- Төрийн байгууллагуудын хувьд хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, хохирогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд ТББ, ОУБ-уудтай хамтран ажиллах байдлаа харьцангуй сайн гэж үнэлсэн бол, ТББ-ууд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй сул гэж үзэж байна.
- Төлөвлөгөөний дагуу хамтран ажиллахад төр, төрийн бус, ОУБ хооронд ойлголт, хүлээлтийн зөрүү өнөөг хүртэл байгаа ба, нэг шатнаас хамтран ажиллахад хүндрэлтэй нөхцөл үүсдэг. Энэ нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшилгүй байдал, түүнээс үүдэн хариуцсан чиг үүрэгтэй мэргэших байдал хангалтгүй байгаатай холбоотой.

ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт:

- ХХГХ, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага нийтээрээ тааруу байна. Судалгааны үр дүнгээр хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх, бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах гэмт хэргийн талаар эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага хангалтгүй байгаа бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаар эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага дунд түвшинд байна. Уг хоёр ойлголтыг багтаасан ерөнхий ойлголт болох ХХГХ-ийг тусад нь тодруулахад эцэг эх, хүүхдийн мэдлэг дунд түвшинд үнэлэгдсэн ч уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага эцэг эх, хүүхдийн аль алинд нь хангалтгүй байна.

Судалгааны хураангуй үр дүн болон хэвлэлийн мэдээтэй дараах холбоосоор орж танилцах боломжтой.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн суурь судалгааны үр дүн гарлаа (<https://worldvision.mn/>)

‘ШИЙДЭЛД ЧИГЛЭСЭН СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ’ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Innovation for Change Central Asia

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Шийдэлд чиглэсэн судалгааны лаборатори төсөл нь бүс нутгийн иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ийн стратегийг цаашид системтэйгээр хөгжүүлэхэд тэр тундаа геополитик болон олон улсын хөрөнгө оруулалтын нөлөөлөлд анхаарал хандуулдаг Төв Ази болон Өмнөд Азийн ИНБ-уудын хамтран ажиллах чадавхыг бэхжүүлэх юм.

Тус төсөл нь үндсэн хоёр зорилттой:

1. Шийдэлд чиглэсэн судалгааны санал боловсруулахад оролцогчдын чадавхыг нэмэгдүүлэх;
2. Оролцогчдын судалгаа хийх, түүнийгээ хөгжүүлэх, кэйс судалгаа болон шийдэлд чиглэсэн судалгааны тайлан боловсруулах чадваруудыг бэхжүүлэх.



2021 5-р сар

2021 8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Афганистан, Бангладеш, Казахстан, Киргиз, Монгол, Пакистан, Шри-Ланка,
Тажикстан, Туркменистан, Узбекистан*

ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Шийдэлд чиглэсэн судалгааны лаборатори төсөл нь Төв болон Өмнөд Азийн ИНБ-уудыг чадавхжуулахад хувь нэмрээ оруулах зорилгоор санаачлан боловсруулсан бичил төслүүдийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүллээ.

1. Бэлтгэл шат

Хүний хөгжил, улс төр, нийгэм, эдийн засгийн асуудал, хүний эрх, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн нөхцөл байдалтай холбоотой зорилтот улс орнуудын онцлог асуудлуудыг судалж нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан боловсруулав. Түүнчлэн төслийн зорилтот орнуудад ашиглагдаж буй олон нийтийн сошиал сүлжээнүүдийг судалж, төсөл сонгон шалгаруулах тухай зар мэдээллийг түгээв. Мөн төсөл хэрэгжүүлж байх явцад гарч болох эрсдэлүүдийг тооцоолон, олон улсын багуудад зориулсан үйл ажиллагааны хяналтын төлөвлөгөөг боловсрууллаа.

2. “Шийдэлд чиглэсэн судалгааны лаборатори” чадавх бэхжүүлэх сургалт

Сонирхогч талуудаас төслийн саналыг хүлээн авахаас өмнө Монгол, Казахстан, Бангладеш, Тажикистан, Киргиз, Узбекистан, Афганистан болон Пакистан улсуудын нийт 27 оролцогчдыг хамруулсан таван өдрийн цахим сургалт зохион байгуулсан бөгөөд дараах сэдвээр илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэв:

- Сургалт 1: Шийдэлд чиглэсэн судалгааг тодорхойлох нь – Ж.Санчир (Оксфордын Их Сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан)
- Сургалт 2: Нэг зам нэг бүс хөтөлбөрийн хүрээнд дэх бизнес болон хүний эрх – Д.Сүхгэрэл (Оюу Толгойн Хяналт ТББ, Гүйцэтгэх захирал)
- Сургалт 3: Иргэний нийгэм болон Тинк танкийн үүрэг, хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграци – З.Батсайхан (Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институтын стратеги төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн)
- Сургалт 4: Хилийн чанад дахь (Хятад)

хөрөнгө оруулалт, зээл, төслийн боломжит ашиг, эрсдэлийг тооцоолох нь – П.Баярцэцэг (МУИС, багш) болон Ж.Санчир (Оксфордын Их Сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан)

- Сургалт 5: Дүгнэх хэлэлцүүлэг – Н.Минжирмаа (IRIM зөвлөх)

3. Төслийн санал сонгон шалгаруулах үйл явц

Зорилтот орнуудын төсөлд хамрагдах сонирхол бүхий багуудаас гаргасан ажлын даалгаврын хүрээнд үндэслэн судалгааны бичил саналуудыг хүлээн авах тухай мэдээллийг Фэйсбүүк, Телеграм, Одноклассники, бусад вебсайтууд зэрэг олон нийтийн сүлжээний түгээмэл платформуудаар дамжуулан тархаав. Нийт найман багаас төслийн саналыг хүлээн авч, үнэлгээний хороо байгуулан тусгайлан боловсруулсан үнэлгээний аргаар дүгнэн гурван багийг сонгон шалгаруулаа.

4. Төсөл хэрэгжүүлэлт

Сонгогдсон гурван баг зургаан долоо хоногийн турш санаачилсан судалгааны төслүүдээ өөрсдийн улсдаа хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд баг тус бүр ямар салбарт судалгаа гүйцэтгэж байгаагаас хамааран тухайн салбарын мэргэжлийн зөвлөхүүдээс зөвлөгөө, чиглүүлэг авч ажиллаж байв. Багууд долоо хоног бүр зөвлөхүүдтэй тогтмол уулзалт зохион байгуулж судалгааг гүйцэтгэхэд тулгарч буй бэрхшээл, гэнэтийн асуудлуудыг шийдвэрлэж байлаа.

5. “Иргэний форум”-д төслүүдийн үр дүнг танилцуулсан

2021 оны 7 сарын 7-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан Иргэний форумд бичил төслийн санхүүжилт авсан гурван баг өөрсдийн хэрэгжүүлж байгаа шийдэлд чиглэсэн судалгааны ажлын урьдчилсан үр дүнг танилцуулав. Баг тус бүр 15 минутын турш судалгаанаас гарсан үр дүн, хэрэгжүүлэхэд явцад хуримтлуулсан туршлага, судалгааны үр нөлөөг бусад оролцогчидтой хуваалцан хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан бие биеэсээ суралцаж байсан нь цаашид өөрсдийн судалгаагаа сайжруулахад нь үнэтэй хувь нэмэр оруулсан.

ШАЛГАРСАН ТӨСЛҮҮД

1. Бангладеш Улсын баг – RJKUF байгууллага

RJKUF баг нь “Хуурамч амлалт: Хятад улсаас хэрэгжүүлж буй томоохон хөрөнгө оруулалтын төслийн нөхөн төлбөр, хүний эрхийн асуудал болон цаашдын арга замууд” гэх төслийг хэрэгжүүлсэн. Төслийн гол зорилго нь цагдаа болон ажилчдын дундах мөргөлдөөний үр нөлөөг судлах, Хятадын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжих бүс нутгийн нийгмийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, Бангладеш дахь хүний эрхийн тухай хуулиуд болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын бизнес ба хүний эрхийн үндсэн зарчмуудаар баталгаажсан хүний эрхийг дэмжих, хамгаалах бодит институтийн механизмыг бий болгох үндсэн зорилготой.





2. Казахстан Улсын баг: “Martebe Plus” иргэний нийгмийн байгууллага

Martebe Plus баг нь “Тогтвортой нийгмийн хөгжлийн хүрээнд Өмнөд Казахстанд хоёр замтай авто замын хонгил барих үйл ажиллагааны хүний эрхэд үзүүлэх нөлөө” гэх нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн гол зорилго нь Өмнөд Казахстан дахь Шакпак Баба-ийн тогтвортой нийгмийн хөгжилд хонгилын барилгын үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг арилгах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад оршино.

3. Киргиз Улсын баг: “Хөгжлийн бодлогын хүрээлэн” иргэний нийгмийн байгууллага

Хөгжлийн бодлогын хүрээлэн баг нь “Бүгд Найрамдах Киргиз Улсын иргэний нийгэмд гадаадын хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөө” судалгааг гүйцэтгэлээ. Судалгааны зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлээр төрийн бодлогыг бүрдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, байр суурийг ойлгох хил

хязгаарыг өргөжүүлэх; төрийн байгууллагуудад хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлэх, түүний үр дүнг бүрэн, үр дүнтэй ашиглах, хүн амын бүх бүлэгт үр өгөөжийг тэгш хуваарилах талаар иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан санал зөвлөмж боловсруулахад оршино.



ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЦАХИМ МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ЧАНАРЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэргэдэх Хурдасгуур Лаборатори /Accelerator Lab/

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО


Судалгааны гол зорилго нь зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварын талаар сайн судлагдаагүй зүйлүүдийг олж мэдэх буюу сонгосон бүлгүүдэд ямар асуудал бэрхшээл тулгардаг, мөн дээрх бүлгүүдийн хандлага, үнэт зүйл, хэрэгцээ зэрэг урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлүүдийг олж нээх явдал юм.



2021 5-р сар

2021 8-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх Хан-Уул, Налайх дүүрэг

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Дэлхий нийтээр цахим шилжилтийг эрчимтэй хэрэгжүүлж байгаа энэ үед Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйлчилгээгээ цахим хэлбэрт шилжүүлэх, санал болгох нь нэмэгдсээр байна. Үүний тод жишээ нь 2020-2021 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн 50 орчим байгууллагын 527 үйлчилгээг цахимжуулж, и-Монголиа системд нэгтгээд байна. Гэвч энэхүү цаг үе, нийгмийн хөгжлийг дагасан цахим шилжилтэд иргэд, олон нийтийн бэлэн байдал, цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадварыг үнэлсэн судалгаа, шинжилгээний ажил хараахан гараагүй, арга зүйн хүрээнд хөгжүүлэлтийн шатандаа явсаар байна. Иймээс IRIM судалгааны хүрээлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хурдасгуур Лабораторийн захиалгаар “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”-г гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Судалгааны хүрээнд тодорхой үзэгдлийн талаар шинийг судалж илрүүлэх шаардлага үүсэж буй тул хамгийн тохиромжтой чанарын, индуктив арга зүй сонгосон ба энэ нь судалж буй асуудлын учир шалтгааныг илрүүлэхэд ач холбогдолтой байдаг. Судалгааны арга зүйг боловсруулахдаа Европын Холбооны Диж Комп 1.0 “Иргэдийн цахим чадавхыг үнэлэх хүрээ”-г сонгон, судалгааны дизайн, хэрэглэгдэхүүндээ ашигласан.

Судалгаанд нийслэлийн 4 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настай иргэн, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрхийн төлөөлөл, шилжигч өрхийн төлөөлөл, хөдөөгийн алслагдмал өрхийн төлөөллийг хамруулсан 78 хүнтэй хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийв. Түүнчлэн Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо, Түгээмэл хөгжилт ТББ-ын төлөөллүүдтэй гүнзгийрүүлсэн ярилцлага зохион байгуулсан. Судалгааны ярилцлагын удирдамж дараах ерөнхий болон дэд хэсгүүдээс бүрдсэн.


Судалгааны асуултын хүрээ

#	Оролцогчдын тоо	Сонголт хийсэн шалгуур
1	Мэдээлэл хайх, олж авах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Интернэтээс хайлтын тусламжтайгаар мэдээлэл олох Үнэн зөв эсэхийг үнэлэн дүгнэх Цуглуулсан мэдээлэл болон файлаа хадгалж, зохион байгуулах
2	Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Цахим платформ, технологийн тусламжтайгаар хүмүүстэй харилцах Хамтран ажиллах Мэдлэг, мэдээлэл хуваалцах Цахим орчинд ёс зүй баримтлах Өөрийн гэсэн цахим профайл мэдээлэл бүхий дүр төрхтэй болох
3	Цахим контент бүтээх ур чадвар	<ul style="list-style-type: none"> Дуу, дүрс, текст зэрэг олон төрлийн контент бүтээх Цахим контентод өөрчлөлт оруулах Цахим орчинд оюуны өмчийг дээдлэх
4	Аюулгүй байдлаа хангах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Ашиглаж байгаа төхөөрөмжөө хамгаалах Хувийн мэдээллээ хамгаалах Цахим технологи ашиглахтай холбоотойгоор эрүүл мэндээ хамгаалах Байгаль орчноо хамгаалах
5	Асуудлыг шийдвэрлэх ур чадвар	<ul style="list-style-type: none"> Өөрт тулгарсан техникийн асуудлыг шийдвэрлэх Хэрэгцээндээ тохирсон технологийн шийдлийг олох Цахим ур чадварын хэрэгцээ буюу цаашид энэ чиглэлээр сурах зүйлээ мэддэг байх

ҮР ДҮН

- Найдвартай, хурдны интернэтэд холбогдсон байдал, ухаалаг төхөөрөмж эзэмшиж буй байдал бага байгаагаас эдгээр таван бүлгийн иргэдэд цахим ур чадвараа сайжруулах урьдач нөхцөл хязгаарлагдмал байна. Судалгаанд оролцогчдын ердөө 20% нь гэртээ компьютертой байна. Товчлууртай гар утасны хэрэглээ өндөр ба 70% нь найдвартай, хурдны интернэтэд холбогдоогүй байна. Энэхүү хязгаарлагдмал нөхцөл нь ялангуяа КОВИД-19 цар тахлын үед иргэдийн ажил эрхлэлт, хичээл сурлагад нь сөргөөр нөлөөлж байна.
- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар хамгийн бага буюу орхигдсон байна. Үүнд цахимаар мэдээлэл олж авах ур чадвар, бусадтай харилцах, хамтран ажиллах чадвар, цахим контент бүтээх ур чадвар, аюулгүй байдлаа хамгаалах ур чадвар, асуудлыг шийдвэрлэх ур чадвар гэсэн 5-н ур чадвар багтана.
- Эсрэгээрээ насны хувьд залуу байх тусмаа цахим ур чадвар илүү өндөр байх хандлагатай байна. Залуучууд ахмад настай оролцогчидтой харьцуулбал өөрсдийн цахим ур чадвараа нэмэгдүүлэх сонирхол өндөр байна. Энэ нь ирээдүйд ажилд орох боломжийг нэмэгдүүлнэ гэж тэд бодож байна. Судалгааны үр дүнг хүйсээр нь харвал эмэгтэйчүүд нийгмийн сүлжээнд илүү идэвхтэй ч эрэгтэйчүүдтэй харьцуулбал цахим хөгжилд итгэх итгэл бага байна.

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

IRIM судалгааны хүрээлэн болон Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээ (ADRN) хамтран зохион байгуулсан Үндэсний түвшний семинар нь “Ардчиллын тэмцэл, сорилтын жилүүдэд: Монгол ба дэлхийн улс орнууд туршлагажиж эрхэлсэн нь” номын нээлтийг хийж, ардчилалд тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх илтгэлүүдийг ADRN -ийн гишүүд, их дээд сургуулиудын багш, эрдэмтдийн төлөөлөл, залуу, ахмад судлаачид, хэвлэл мэдээлэл, төрийн болон ТББ-уудын төлөөллүүдэд танилцуулан, сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх арга хэмжээг үндэсний түвшинд зохион байгуулахыг зорьсон.



2021

6-р сар

2021

7-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол, Швейцар, Солонгос, Канад, Австрали, Испани Улсын төлөөллүүд

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн баг нь номын нээлтийн арга хэмжээг цахим болон танхим хосолсон байдлаар зохион байгуулахаар төлөвлөж байсан ч COVID-19 цар тахлын эсрэг Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлж байсан хязгаарлалтуудын улмаас арга хэмжээг танхимаар зохион байгуулах боломжгүй болсон. Тиймээс 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр цахимаар зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт дараах гол илтгэлүүд тавигдав:

1. Социализмын дараах үеийн Монголын иргэний нийгмийн хувирал өөрчлөлт - Далайбуяны Бямбажав (Монголын Инновацийн бодлогын хүрээлэнгийн захирал бөгөөд Австралийн Квинсландын Их Сургуулийн Уул уурхайн салбар дахь Нийгмийн харууцлагын төвийн хүндэт эрдэм шинжилгээний ажилтан)
2. Өөрчлөлтийн мөч үү? Орлогын сөрөг цочрол ба дэлхийн улс орнуудын улс төрийн дэглэмийн өөрчлөлт - Увшийн Дэлгэржаргал (Нью Йоркийн Их Сургуулийн дэргэдэх Оросын талаарх Дэвшилтэт судалгааны Жордангийн төвийн докторын дараах эрдэм шинжилгээний ажилтан)
3. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх 2017 оны Зөвлөлдөх санал асуулга - Одонхүүгийн Мөнхсайхан (Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Профессор)
4. Монголын ардчилал: Үндсэн сорилт ба хэтийн бол Смж - Ойдовын Хатанболд (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч)
5. Зүүн өмнөд Азийн байгалийн нөөцийн менежмент: Авлигатай тэмцэх, хууль сахиулах болон үр ашигт тулгарч буй сорилтууд - Андреа Хэфнер (Австралийн Гриффетийн Азийн хүрээлэнгийн багш)
6. Каталаны 10 сарын 1-ний ард нийтийн саналасуулга ардчиллын төлөөх тэмцэл болсон нь- Нурия Суэро Комеллас (Улс

төр судлаач, Барселоны Автономит Их Сургуулийн Улс төр, бодлого, олон улсын харилцааны хөтөлбөрийн профессор)

Арга хэмжээ 2 цаг 30 минутын турш үргэлжилсэн ба арга хэмжээний төгсгөлд оролцогчид өөрсдийн асуулт болон сэтгэгдлээ номын зохиогчидтой хуваалцаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

ҮР ДҮН

Энэхүү номын нээлтийн арга хэмжээний бүтээгдэхүүнийг дараах байдлаар олон нийтэд түгээсэн. Үүнд:

1. Арга хэмжээний бүтэн видео бичлэгийг захиалагч (ADRN) байгууллагад хүлээлгэн өгсөн.
2. Техникийн тайлан болон нээлтийн арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан талаар богино хэмжээний бичлэгийг хийж, захиалагч (ADRN)-д хүлээлгэн өгсөн.
3. Мөн арга хэмжээний талаар мэдээллүүдийг IRIM өөрсдийн веб хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан, олон нийтэд түгээлээ.


Номыг олон нийтэд нээлттэй байршуулсан бөгөөд дараах холбоосоор хандан танилцана уу.

<https://www.worldsociety.ch/doku.php>

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨМТГИЙ БОЛОН ТЭСВЭРТЭЙ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага

Хууль зүй, дотоод хэргийн яам

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү суурь судалгаагаар Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн шалтгаан, нөхцөл, Монголчуудын ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөлж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон бөгөөд дараах зорилтуудын хүрээнд судалгааг гүйцэтгэсэн. Үүнд:

- Монгол Улсын иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг болон тэсвэртэй байдлыг үүсгэж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг судлах;
- Монгол Улс дотоодод болон Монгол Улсаас гадагшаа чиглэсэн ХХГХ-ийн чиглэл, чиг хандлага, хэв шинжийг тодорхойлох;
- ХХГХ-ийн хохирогч болсон иргэдэд шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлох;
- ХХГХ-тэй тэмцэхэд үр дүнтэй байж болох тэргүүлэх бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааг тодорхойлох.




2020

3-р сар

2021

12-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд
Дархан-Уул аймаг, Дархан хот
Өмнөговь аймаг, Ханбогд сум
Дорнод аймаг, Чойбалсан сум*

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс нь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор үндэстэн дамнасан хүн худалдаалах гэмт хэргийн илгээгч, хүлээн авагч, дамжуулагч орнуудын нэгд тооцогддог. Дотоод болон олон улс дахь Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн хэв шинж, чиг хандлага жил бүр олноор илэрч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн Газар болон олон улсын байгууллагууд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр онцгой анхаарал хандуулан хууль эрх зүйн орчинд холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улс дахь ХХГХ-тэй тэмцэхэд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн баримт, мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ямар иргэд, хаана илүү ХХГХ-т өртөх эрсдэлтэй байгааг тодорхойлж чадаагүйгээс хууль хяналтын байгууллагуудын хэрэгжүүлж буй ажлууд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бодитой үр дүн үзүүлж чадахгүй байна. Энэхүү суурь судалгааг Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын 2020-2022 оны хооронд хэрэгжүүлж буй "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг

бэхжүүлэх нь" төслийн хүрээнд уг гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын хүчин чармайлт, түүний үр дүнг сайжруулахад суурь нөхцөл байдлыг тодорхойлох хэрэгцээ шаардлагын үүднээс хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан өргөн хүрээнд мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн. Ингэхдээ чанарын аргаар ХХГХ-тэй тэмцэх Монгол Улсын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг судалж, эмзэг байршил, урсгал чиглэл, шалтгаантай холбоотой мэдээллийг тодруулсан бол тоон аргаар иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж болзошгүй мөн хамгаалах хүчин зүйлсийг тодруулахыг зорьсон.

ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны асуудлыг авч үзэхдээ 4Р-ийн парадигм буюу урьдчилан сэргийлэх (prevention), хохирогчийг хамгаалах (protection), хэрэг хянан шийдвэрлэх (prosecution) болон хамтын ажиллагаа (partnership) гэсэн дөрвөн үндсэн асуудлын хүрээнд судалсан.

Судалгааны ерөнхий арга зүйн хүрээ



БҮТЦИЙН
ТҮВШИНД:

Иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахдаа ОУШХБ-ын “Эмзэг байдлыг тодорхойлох загвар”-ыг ашигласан. Энэхүү загвар нь хувь хүн, гэр бүл, олон нийт, бүтцийн дөрвөн түвшинд хүнийг эрсдэлд оруулахад нөлөөлж буй болон хамгаалж буй хүчин зүйлүүдийг тодруулж, иргэдийн эмзэг байдлыг бууруулах интервенц боловсруулж, хэрэгжүүлэхэд ашиглагддаг арга зүйн хүрээ юм. Уг загвар нь хувь хүнийг аливаа төрлийн хүчирхийлэл, цаашлаад ХХГХ-ийн хохирогч болоход нөлөөлж буй хүчин зүйлсийг хувь хүн, гэр бүл, олон нийт, бүтцийн түвшинд цогцоор нь авч үздэгээрээ онцлог.

Иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй болон хамгаалж буй хүчин зүйлсийг тодорхойлохын тулд ХХГХ-ийн эрсдэл өндөр гэж үзсэн орон нутгуудад 467 иргэнийг хамруулсан хоёр үе шаттай тоон судалгааг зохион байгуулсан. Нэгдүгээр шатанд, зорилот бүлгийн 467 иргэний дунд ХХГХ-т өртөх эрсдэлийг илрүүлэх судалгааг гүйцэтгэсэн бол хоёрдугаар шатанд эрсдэлтэй болох нь тодорхойлогдсон 423 иргэний эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулж, ХХГХ-т өртөх эмзэг байдлын индекс тооцсон.

ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан 423 иргэнээс ХХГХ-т өртөмтгий байдлын индексийн шалгуур үзүүлэлтээс дор хаяж нэг үйлдэлд 28.4% нь буюу 120 иргэн өртсөн байв. Энэ нь эдгээр иргэд ХХГХ-т өртөмтгий шинжтэй байгааг илтгэж байсан.

Судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь ажил олгогчийн зүгээс анх тохирсноосоо өөр ажил хийхийг шаардах, шахах, ямар нэг байдлаар хуурч мэхлэх тохиолдлуудтай тулгарч байсан нь ХХГХ-ийн эрсдэл, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн байх магадлалтайг харуулж байв. Ялангуяа, эдгээр иргэдийн 5-8% нь ажил олгогчийн зүгээс дарамталж айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэх, хорьж цагдаж хянах зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэрч байсан, 6% нь ажил олгогчдоо өр төлбөртэй байсан гэж хариулсан.

ХХГХ-ийн хэлбэрүүдэд өртсөн байдлыг таних асуултуудын үр дүн (n=423)



Эдгээр иргэдийн мэдээлэлд үндэслэн иргэдийн эмзэг байдлын нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг

ОУШХБ-ын “Эмзэг байдлыг тодорхойлох загвар”-ын дагуу тодруулахад дараах үр дүнгүүд гарсан:

Иргэдийг ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс

ХУВЬ ХҮН

- Насны хувьд залуу (18-24)
- Ажилгүй эсвэл тогтмол орлогогүй, улирлын чанартай, цагийн ажил эрхэлдэг
- Оршин суугчийн бүртгэлгүй
- Ганц бие, эсвэл салсан
- Ажил эрхлэх, суралцах зорилгоор урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон
- Бие махбодын болон сэтгэл зүйн хүндрэл, бэрхшээлтэй

ГЭР БҮЛ

- Санхүүгийн баталгаагүй, орлого бага өрхийн гишүүн (Гэвч санхүүгийн хувьд баталгаатай байх нь хамгаалалт болох нөлөөгүй)
- Гэр бүлийн уур амьсгал таатай бус, зөрчил маргаантай
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг, дарамт хүчирхийлэлтэй
- Өрхийн аль нэг гишүүн сурах эсвэл ажил эрхлэх зорилгоор урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон

ОЛОН НИЙТ

- Бусдын зүгээс өөрсдийг нь хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл боловсролын түвшин доогуур, нийгмийн доод давхаргаас гаралтай гэж ханддаг орон нутаг, олон нийтийн дунд амьдардаг
- Амьдарч буй орон нутагт нь удаан хугацаанд хөдөлмөр эрхлээгүй эсвэл орлого багатай иргэдэд амьжиргаагаа дээшлүүлэх эдийн засгийн боломж хомс байдаг .
- Нийгмийн суурь үйлчилгээг авахад бэрхшээлтэй тулгардаг

Хоёр шаттай хийгдсэн тоон шинжилгээний үр дүн болон чанарын, баримт бичгийн өгөгдлүүдэд шинжилгээ хийхэд цаашдаа бодлого, үйл

ажиллагааны түвшинд нэн тэргүүнд анхаарах шаардлагатай дараах онцлох үр дүнгүүд гарсан.

ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд, судалгааны онцлох үр дүнгүүд



Эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн иргэд ХХГХ-т өртөж байна.




Санхүүгийн хязгаарлагдмал байдал нь ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.



Хөдөлмөрийн мөлжлөг нь Монгол Улсад улам нэмэгдэж буй чиг



COVID-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй шийдвэр, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.



Бүртгэлгүй шилжин ирэгсэд ХХГХ-т илүү өртөмтгий байна.



Улаанбаатар хот, орон нутгуудаас Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад ХХГХ-ийн эрсдэл өндөр байгаа

Хохирогч хамгааллын чиглэлээр хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо хангалтгүй, үйлчилгээний санхүүжилт дутмаг байна.

Дүгнэлт

ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг ОУШХБ-ын “Эмзэг байдлыг тодорхойлох загвар”-ын дагуу дөрвөн түвшинд судалсан судалгааны дүнгээр түвшин тус бүрд нөлөөтэй хүчин зүйлсийн хооронд нягт хамаарал байгаа нь харагдаж байв. Тухайлбал, бүтцийн түвшиндээ нийгмийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурал өндөр байгаа нь хувь хүн, өрхийн түвшинд орлогын тогтвортой эх үүсвэргүй байхад нөлөөлж байна. Олон нийт, бүтцийн түвшиндээ нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмж сул байх нь хувь хүн, өрх гэр бүлийг шилжилт хөдөлгөөн хийхэд хүргэж, өрхийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Энэ мэтчилэн олон нийт, бүтцийн түвшний суурь асуудлууд нь хувь хүн, өрхийн амьжиргаа, амьдралын чанарт нь шууд нөлөөлж байгаа нь хувь хүний сэтгэл зүйн төлөв байдал, гэр бүлийн уур амьсгалд таагүй нөлөөг үзүүлж дарамт, хүчирхийлэл мөлжлөг үйлдэгдэх, улмаар иргэдийг илүү боломж, амьдралын таатай нөхцөлийн төлөө гэмт хэрэгт холбогдох, эрсдэлтэй сонголт хийх суурь нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

Иймд ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавхыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийт, холбогдох төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх асуудалд шууд чиглэсэн ажлуудыг зохион байгуулахтай зэрэгцэн олон

нийт, бүтцийн түвшинд нөлөөтэй нийгмийн суурь хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн урт хугацааны бодлого, төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Цаашдын чиглэл

Монгол Улс ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бие даасан хуулийг 2012 онд баталж улмаар хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2021 оны хугацаанд хэрэгжүүлээд байна. Уг суурь судалгааг хийж гүйцэтгэх үетэй зэрэгцээд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусаж байсан тул хөтөлбөрийн дараагийн шатны чиглэл, үйл ажиллагааг төлөвлөхөд энэхүү судалгааны үр дүн холбогдох талуудыг баримт нотолгоогоор хангаж, ХХГХ-тэй тэмцэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэхэд хувь нэмэр болно гэж судалгааны багийн зүгээс найдаж байна.

УЛААНБААТАР ХОТЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ БОЛОН ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭМЗЭГ БАЙДЛЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


2017 онд гарсан хөдөө, орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай Нийслэлийн засаг даргын А/17 тоот захирамж гарсан. Энэхүү судалгааны гол зорилго нь дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдал, болон Улаанбаатар хотын амьдрах орчны ерөнхий нөхцөл байдлыг судлах замаар, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлалтын үр нөлөөг үнэлэхэд оршиж байв.



2020 1-р сар

2021 6-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Үндэсний статистикийн хорооны судалгаанаас харахад, сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 24,000 гаруй хүн Улаанбаатар хотод шилжин суурьшсан байна. Хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн урсгал нэмэгдсэнээр хотжилт хурдацтай явагдаж, хүн амын нягтаршлыг сааруулах сэдэл үүсэхэд түлхэц үзүүлсэн. Тиймээс Нийслэлийн засаг даргын тамгын газар (НЗДТГ)-аас “Нийслэлийн оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах” зорилгоор 2017-2020 оны хугацаанд хөдөө орон нутгаас Улаанбаатарт шилжин суурьших хөдөлгөөнийг хязгаарласан. НЗДТГ-аас гаргасан

2017 оны А/17 тоот уг захирамжийн хэрэгжилт, шилжин ирэгсдийн эмзэг байдалд үзүүлсэн нөлөө, Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөнд гарсан өөрчлөлт зэргийг үнэлэх хэрэгцээнээс үүдэн уг төсөл хэрэгжиж эхэлсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан Улаанбаатар хотод оршин суугаа шилжигч болон шилжигч бус өрхийн төлөөллөөс мэдээлэл цуглуулсан. Тоон судалгаанд УБ хотын төвийн 6 дүүргийн 40 хорооны нийт 2505 өрхийг хамруулсан.

Тоон судалгаа		Чанарын судалгаа	
Нийт 2505 өрх		Нийт 47 оролцогч	
Бүртгэлтэй шилжин ирэгсэд 2014-2016	n=486	4 бүлгийн ярилцлага	15 ганцаарчилсан ярилцлага
Бүртгэлгүй шилжин ирэгсэд	n=536	• 16 шилжигч иргэн • 16 шилжигч бус иргэн	• хорооны цагдаа, • Өрхийн эмнэлгийн эмч, • нийгмийн халамжийн нийгмийн ажилтан, • улсын бүртгэгч, • ЕБС-ийн сургалтын менежер
		Шилжигч бус	n=943

ҮР ДҮН

Өрхүүдээс цуглуулсан тоон мэдээллийг ашиглан Олон талт эмзэг байдлын индекс (ОТЭБИ)-ийг тооцоолсон. ОТЭБИ-ийн дээд утга 1 байх бөгөөд Алкир болон Фостерийн (2011) “хосолсон хязгаарлалтын (dual cutoff)” арга зүйн дагуу өрх 0.67-оос бага оноо авсан тохиолдолд тухайн өрхийг “эмзэг” гэж тодорхойлсон.

Шилжин суурьшигчдын эмзэг байдлыг гүнзгийрүүлэгч хүчин зүйлс




Шилжих хөдөлгөөний хязгаарлалт шилжин суурьшигч өрхүүдийн эмзэг байдлыг гүнзгийрүүлжээ. Шилжих хөдөлгөөний хязгаарлалт тавьсан үед (2017-2020) шилжин суурьшсан өрхүүдийн олон талт эмзэг байдлын индекс бусад онуудад шилжин суурьшсан өрхтэй харьцуулахад 1.3 хувиар бага байна.

Эдийн засгийн индекс дахь бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн дундаж оноо



Нэг хүнд ноогдох орлого багатай, цөөн тооны орлогын эх үүсвэртэй, газар/мал өмчлөлгүй (үзүүлэлт тус бүрт 1-ээс 0.03, 0.41, 0.39 оноо авсан) зэрэг шалтгаанууд шилжигч өрхүүдийг эмзэг болгож байв.

Нийгмийн индекс дахь бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн дундаж оноо



Шилжин суурьшигч өрхүүдийн дийлэнх нь олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо сул бөгөөд шаардлагатай үед албан бус дэмжлэг авах боломж хомс байдаг нь ажиглагдсан (0.23 and 0.59 scores out of 1).

Эрүүл мэнд болон боловсролын индекс дахь бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн дундаж оноо



Шилжин суурьшигч өрхүүд бүртгэлтэй эсэхээс үл хамааран эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжтой байдаг ба хоол тэжээлийн дутагдалд орох магадлал багатай байдаг. Гэсэн хэдий ч өрхийн тэргүүний боловсролын түвшин шилжигч бус өрхүүдтэй харьцуулахад харьцангуй доогуур байгаа (1-ээс 0.55 оноо авсан) нь эмзэг байдал гүнзгийрэхэд нөлөө үзүүлжээ.


Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь (57%) шилжих хөдөлгөөний хязгаарлалт Улаанбаатар хотод амьдрах нөхцөл байдлыг сайжруулаагүй гэж хариулсан байна. Зураг 4-т үзүүлсэн судалгааны үр дүнгүүд шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь замын хөдөлгөөн, орчны бохирдол, ажил эрхлэлт, аюулгүй байдал зэрэг Улаанбаатар хотын иргэдийн амьдрах нөхцөл байдлыг сайжруулах зорилгодоо хүрч чадаагүй болохыг нотолж байна.

Судалгаанд хамрагдсан нийт шилжилт хөдөлгөөн хязгаарласан үеэр шилжин суурьшсан хүмүүсийн 83% нь уг бодлогыг мэддэг эсэхээс үл хамааран шилжин ирэх байсан гэж хариулсан нь уг бодлого шилжин суурьшихаар завдаж буй хүмүүсийн хүсэл зоригийг бууруулна гэсэн анхны зорилтдоо хүрээгүй, тэдний зан үйлийг өөрчлөхөд төдийлөн нөлөөтэй байж чадаагүйг харуулж байна.

Нэмж дурдахад, шилжих хөдөлгөөнийг хязгаарласнаар зарим эрсдэлт бүлэг (тухайлбал өндөр настан, олон хүүхэдтэй өрхүүд)-ийн шилжин суурьшигчид нийгмийн суурь үйлчилгээг авах боломжгүй болсноос хууль бусаар тог цахилгаан хэрэглэх, хүүхдээ сургуульд оруулахын тулд хээл хахууль өгөх гэх мэт сөрөг арга зам сонгоход хүрч, улмаар аюулгүй байдал нь алдагдах, эмзэг байдал нь нэмэгдэх зэрэг хүсээгүй үр дагаварт хүргэсэн болохыг зорилтот бүлгийн ярилцлагад оролцсон орон нутгийн иргэд мэдээлсэн.

Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт амьдрах орчны нөхцөл байдалд нөлөөлсөн байдал

Таны бодлоор Улаанбаатар хотын амьдрах орчин нөхцөл одоогоос 5 жилийн өмнөхтэй харьцуулахад сайжирсан уу?




Судалгааны үр дүнд боловсруулсан бодлогын зөвлөмжүүд

Богино хугацаанд: Бууруулах арга хэмжээ	Бүртгэлгүй шилжин суурьшигчдыг олж тодорхойлж, бүртгэлжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Бүртгэлгүй шилжин суурьшигчдын тоог хянах, албан ёсны мэдээллийн санд оруулж нэгтгэх зорилгоор үндэсний статистикийн системийг илүү боловсронгуй болгох. 2. Бүртгэлийг сайжруулахын тулд бүртгэлтэй байхын давуу талуудыг олон нийтэд сурталчлах, бүртгэлтэй холбоотой гарч болох аливаа зардлыг бууруулах.
	Шилжин суурьшигчдын тодорхой дэд бүлгүүдийн эмзэг байдлыг бууруулах	<ol style="list-style-type: none"> 1. Өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн эдийн засгийн интервенцийг бий болгох. 2. Одоо хэрэгжиж буй нийгэм, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд шилжин суурьшигчдыг холбон зүүчлэх, хүнсний талон, тэтгэмж авах, сургуулийн тэтгэлэг болон түүнтэй адил тусламжид өргөдлөө өгөхөд нь дэмжлэг үзүүлэх.
Дунд хугацаанд: Нэгтгэл болон зөөлөн хязгаарлалт	Дотоодын шилжилт хөдөлгөөнд зориулсан хүний болон санхүүгийн нөөцийг тусгайлан хуваарилах	<ol style="list-style-type: none"> 1. Хотын амьдралын талаар танилцуулах хөтөлбөр, мэргэжлийн боловсрол олгох компани ажлуудыг зохион байгуулах байдлаар шилжин суурьшигчдын дасан зохицох байдлыг нэмэгдүүлэх. 2. Эргэн суурьшилтын тэтгэмжийг санал болгох замаар шилжин суурьшигчдын сайн дураараа буцах сэдлийг дэмжих.
	Хүний эрхийг зөрчсөн шилжилт хөдөлгөөний хэт хатуу хязгаарлалтаас зайлсхийх	<ol style="list-style-type: none"> 1. Дотоодын шилжин суурьшилтыг хязгаарлах аливаа бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эмзэг байдлын асуудлыг заавал харгалзаж үзэх. 2. Нийслэл хот дахь ажилгүй иргэдийг хөдөө орон нутаг дахь ажлын байранд ажиллуулахаар илгээх, эргэн суурьшуулах схемийг хэрэгжүүлэх.
	Дотоодын шилжилт хөдөлгөөний талаар сөрөг хэм хэмжээ, хандлагыг бууруулах	<ol style="list-style-type: none"> 1. Шилжин суурьшигчдын нийслэл хотод авчирч буй давуу талуудыг сурталчлах компани ажил, олон нийтийн хамарсан уулзалтуудыг зохион байгуулах. 2. Төрийн албан хаагчид, ялангуяа төрийн суурь үйлчилгээ үзүүлэгчдэд шилжин суурьшигчдын нөхцөл байдал, тэдний эрхэд нийцсэн төрийн үйлчилгээ үзүүлэх бодлого, туршлагын талаар сургалт зохион байгуулах.
Урт хугацаанд: Урьдчилан сэргийлэлт	Хөдөө орон нутгийн хөгжилд төвлөрөх замаар шилжин суурьшихад хүргэж буй хүчин зүйлсийг бууруулах	<ol style="list-style-type: none"> 1. Шилжилт хөдөлгөөний талаар зохих зорилтуудыг дэвшүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгох замаар орон нутгийн засаг захиргаанд илүү уян хатан санхүүжилт олгох. 2. Онцгой байдлын удирдлага болон эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зэрэг байгалийн гамшгийг даван туулах малчдын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх.
	Урт хугацааны төлөвлөгөө болон эрх зүйн баримт бичгүүдэд дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгаж өгөх	<ol style="list-style-type: none"> 1. Шилжилт хөдөлгөөний асуудлыг нэгтгэх, шилжилт хөдөлгөөний тодорхой зохицуулалт бүхий механизмыг тусгах зорилгоор дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдийг шинэчлэх. 2. Одоогийн болон ирээдүйд боловсруулахаар төлөвлөж буй бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнүүдэд шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгаж өгөх.
	Нэмэлт судалгаа хийх, гол оролцогч талуудтай зөвлөлдөх хэлэлцүүлэг, уулзалтууд зохион байгуулах	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн жилүүдэд гарсан хүн амын судалгааны тоо баримт дахь шилжин суурьшигчдын талаар мэдээлэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх, тухайн тоо баримтыг бусад бүртгэлийн болон захиргааны мэдээлэлтэй тулган харьцуулж, шилжих хөдөлгөөний бодит урсгалын илүү оновчтой тооцоолол гаргах. 2. УБ хотоос орон нутагтаа буцаж суурьшсан хүмүүсийн талаар судалгаа хийж, тэдний шилжин суурьшсан шалтгаан, хүчин зүйлсийг судалж, орон нутагт чиглэсэн шилжих хөдөлгөөнийг дэмжих үр дүнд суурилсан оновчтой бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах.

Судалгааны Монгол хэл дээрх бүтэн тайланг эндээс үзэх боломжтой: https://www.iom.int/sites/g/files/tmzbd1486/files/documents/Assessing%20the%20effectiveness%20of%20migration%20restriction_final.pdf?fbclid=IwAR1C3cvkSqe1f98GRwHuudlfqph4Wih1Nx2HU91Wkrmw0ULn9C1PHbE

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЦАХИМ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй цахим хүчирхийлэл хэрхэн илэрч, эмэгтэйчүүд цахим хүчирхийлэлд ямар хариу үйлдэл үзүүлдэг эсэх, цахим хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн иргэний нийгэм, улс төр дэх оролцоонд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилготой юм.




2021

11-р сар

2022

1-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Уулс

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Онлайн судалгаа авах болон гүнзгийрүүлсэн ярилцлага хийх зорилгын дор IRIM-ийн баг Монгол Улсад амьдардаг 18 ба түүнээс дээш насны 400 эмэгтэйгээс тоон мэдээлэл, цахим хүчирхийллийн чиглэлийн эксперт болон хүчирхийлэлд өртөж байсан 10 эмэгтэйгээс чанарын мэдээлэл цуглууллаа.

Тоон мэдээлэл цуглуулалт: Нийт мэдээлэл цуглуулалтыг онлайнгаар зохион байгуулсан.

Судалгааны багийн гишүүд судалгааны линкийг Фейсбүүкийн хаалттай бүлгэмүүдэд байршуулахаас гадна 10,000- аас дээш дагагчидтай Инстаграм хэрэглэгчдийн хаягаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Судалгааны зорилгод хүрэхийн тулд энэхүү судалгаанд магадлалт бус түүврийн аргыг ашигласан.

Мэдээлэл цуглуулалтад ашигласан арга, техникүүд:



Онлайн судалгаа нь дараах 2 үе шатын дагуу явагдсан.

Илрүүлэг судалгаа



Цахим хүчирхийллийн судалгаа

Судалгааны баг нь 18 ба түүнээс дээш настай, өмнө нь эсвэл одоо цахим хүчирхийлэлд өртөж байгаа, интернэт хэрэглэгчдээс онлайн судалгааны мэдээлэл цуглуулахын тулд урьдчилан бэлдсэн 2-3 минут үргэлжлэх илрүүлэг судалгааг авч, шалгуурт нийцсэн 400 оролцогчдыг үндсэн судалгаанд хамруулсан.

Чанарын мэдээлэл цуглуулалт: Судалгааны зорилгод оролцогчдыг нийцүүлэх үүднээс судалгааны баг бүх зорилтот бүлгийн (сонгуульд нэр дэвшиж байсан эмэгтэй улс төрчид, улс төрийн зүтгэлтнүүд, УИХ-ын эмэгтэй гишүүд, ИНБ-ын идэвхтнүүд, ЛГБТ төвийн төлөөлөл болон нийгмийн сүлжээний энгийн хэрэглэгчид) боломжит оролцогчидтой холбоо тогтоосон. Эдгээрээс судалгааны шалгуурт нийцсэн, оролцох боломжтой 10 эмэгтэйчүүдийн жагсаалтыг үүсгэж, захиалагч байгууллагаар батлуулсан ба уг жагсаалтын дагуу ярилцлага хийсэн.

ҮР ДҮН

Энэхүү судалгаанд манай байгууллага зөвхөн мэдээлэл цуглуулалтыг хариуцан ажилласан ба судалгааны үр дүн, дүгнэлт хараахан олон нийтэд ил болоогүй байна.

“НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭ (НҮБХТХ) 2017-2022”-ЫН ҮНЭЛГЭЭ



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний гол зорилгууд нь


- НҮБХТХ 2017-2022-ын хүрээнд хүлээгдэж буй үр дүнд хувь нэмрээ оруулахын тулд НҮБ-ын хөтөлбөрийн зарчмуудыг баримталж, үр дүнтэй, илүү их хариуцлагатайгаар ажиллахад нь НҮБ-н системд дэмжлэг үзүүлэх;
- Одоогийн НҮБХТХ 2017-2022-г хэрэгжүүлэх явцад тулгарсан ололт болон сургамжууд, тэдгээрийн учир шалтгааныг тодруулж, өнгөрсөн туршлагаасаа суралцах дадлыг дэмжих;
- Дараагийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хүрээ (НҮБТХХАХ)-нд ашиглаж болохуйц тодорхой, хэрэгжихүйц, стратегийн болон хөтөлбөрийн шинж чанартай санал зөвлөмжүүдийг эрэмбэлэн гаргах зэрэг юм.



2021 8-р сар

2022 3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улс, Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ДИЗАЙН

КОВИД-19 цар тахлын улмаас уг үнэлгээг алсын зайн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд мэдээлэл цуглуулалтын төлөвлөгөөг үүнтэй уялдуулан өөрчилсөн. Үнэлгээний олдворуудын найдвартай байдлыг нэмэгдүүлж, санал зөвлөмжүүдийн үндэслэлтэй, хэрэгжихүйц байдлыг хангахын тулд өөр ялгаатай түвшний мэдээллүүдийг трангулиаци (олон талаас нь дүн шинжилгээ хийх) хийсэн.

Олон Улсын 1 зөвлөх, Үндэсний 2 зөвлөхөөс бүрдсэн үнэлгээний баг нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Бэлтгэл шатанд баримт бичгийн шинжилгээ хийж, онол арга зүйг тодорхойлсон. Мөн оролцогч талуудыг тодорхойлж, тандах уулзалтууд хийв. Үүнээс гарсан шинжилгээний хүрээ, асуултуудад тулгуурлан дараах оролцогч талуудтай хэд хэдэн удаагийн уулзалт, ярилцлагуудыг зохион байгуулав.

Үнэлгээнд оролцогч талууд

1. НҮБ-ын агентлагууд
(11 ярилцлага болон бичгэн хариулт)

2. ЗГ-ын түншүүд
(18 ярилцлага болон бичгэн хариулт)

3. ИНБ ба академиуд
(7 ярилцлага болон бичгэн хариулт)

4. Хөгжлийн түншүүд/донорууд
(10 ярилцлага болон бичгэн хариулт)

5. Хувийн хэвшил
(6 ярилцлага болон бичгэн хариулт)

Ингээд цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дараах арга зүйн дагуу тайлан боловсруулж, урьдчилсан үр дүнгүүдийг оролцогч талуудад танилцуулсан.

Энэхүү үнэлгээг хамааралтай байдал, дасан зохицох байдал, үр дүнтэй байдал, тогтвортой байдал, үр нөлөө, нийцэл болон уялдаа холбоотой байх чиглэл болон үр ашигтай байдал гэх мэт шалгуурын дагуу гүйцэтгэж холбогдох санал зөвлөмжүүдийг гаргасан.

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Үр дүнг дээрх арга зүйн дагуу 5 шалгуур үзүүлэлтийн дагуу гаргахаас гадна хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хүний эрхэд суурилсан хандлага, жендерийн тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдал, үр дүнд суурилсан удирдлага гэх мэт зарчмуудыг авч хэлэлцсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Дор зарим үр дүнгүүдээс хуваалцлаа.

- **Хамааралтай байдал**

НҮБХТХ нь Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-2030-ыг сайн тусгасан “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030”-тай нийцсэн байна. НҮБ нь улс оронд шинээр тулгамдсан, урьдчилан тооцоолоогүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан. Сорилтын хувьд, КОВИД-19 цар тахал, сонгуулийн дараагаар төрийн албан хаагчдын халаа солигдож, холбогдох байгууллагын тогтвортой байдал алдагдсан нь НҮБХТХ-ний хэрэгжилтэд хязгаарлалт болж байжээ.

- **Үр дүнтэй байдал**

НҮБХТХ-ний зарим шалгуур үзүүлэлтүүд нь НҮБ-ын хувь нэмрийг үнэлэхэд хэтэрхий өндөр түвшинд буюу амбицтай боловсруулагдсан тул үр дүнтэй хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх боломжгүй байдлаар томъёологдсон байна. НҮБ дараагийн Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБТХХАХ)-гээ боловсруулахдаа НҮБ-ын хувь нэмрийг нарийн тодорхойлж, үр дүн, гарц нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь үр дүнг хэмжихэд тохиромжтой байдлаар томъёолох шаардлагатай.

Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



- **Тогтвортой байдал**

НҮБХТХ-ний хүрээнд эхлүүлсэн хамтын ажиллагааны төслүүдийг үндэсний түншүүд дэмжих буюу Засгийн газар үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өргөжүүлж байгаа олон тодорхой жишээ байна. Гэсэн хэдий ч хамтын ажиллагааны хүрээг Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, тогтвортой байдлыг хангахын тулд НҮБХТХ-г боловсруулж эхлэх цагаас л Засгийн газар оролцох нь маш чухал.

- **Үр нөлөө**

НҮБХТХ хүмүүст бодитой нөлөө үзүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хүний эрх, амьдрах орчныг хамгаалах тал дээр ахиц гаргасан. НҮБ-ын зарим агентлагуудын үнэлгээний тайланд үр нөлөөний талаар сонирхолтой дүгнэлтүүд бичигдсэн байсан нь НҮБХТХ нь НҮБ-н агентлагуудын хөтөлбөрөөр дамжин олон талаар бодит үр нөлөөтэй байсныг нотолж байна. Гэхдээ зарим тохиолдолд үр дүнгийн нөлөөг үнэлэхэд хэтэрхий эрт байна.

- **Үр ашигтай байдал**

Үйл ажиллагааны удирдлагын баг нь худалдан авах ажиллагаанд нийтлэг бизнесийн горимыг нэвтрүүлснээр бөөнөөр худалдан авбал зардал буурах зарчмын хүрээнд үйл ажиллагааны зардлыг бууруулан ажиллаж байна. Бэлэн мөнгө шилжүүлэх нэгдсэн хандлагыг хэрэглэн төрийн болон төрийн бус түншүүдэд бэлэн мөнгө шилжүүлэхдээ гүйлгээний зардлыг бууруулсан. НҮБ-ын шинэчлэлийн хүрээнд үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын дор арын албыг нэгтгэх нь цаашид гүйлгээний зардлыг бууруулах боломжийг олгож байна.

АНУ-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙН “LEADERS ADVANCING DEMOCRACY (LEAD) MONGOLIA” ХӨТӨЛБӨРИЙН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ



Эх сурвалж: LEAD MONGOLIA

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн агентлаг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний гол зорилго нь USAID-ийн санхүүжилтээр World Learning байгууллага удирдан хэрэгжүүлсэн LEAD Mongolia хөтөлбөрийн үр нөлөө, зорьж буй үр дүнг үнэлэх замаар буй хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийхэд оршиж байв.




2021

8-р сар

2022

2-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улс, Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

LEAD Mongolia хөтөлбөрийг USAID санхүүжүүлж, World Learning байгууллага удирдан 2016-2021 оны хооронд нийт 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийг World Learning байгууллагаас гадна Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн, Иргэний боловсролын төв хамтран хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь манлайлал, техникийн болон зөөлөн ур чадвар (soft skill), ардчилсан оролцооны талаар сургалтууд, олон улсын солилцоо, мэдлэг солилцох, харилцаа холбоо тогтоох арга хэмжээ, иргэний боловсролоор дамжуулан Монголын ирээдүйн ардчиллын удирдагчид болон гол оролцогчдыг хөгжүүлэх, чадавхжуулах үндсэн зорилгын дор хэрэгжсэн.


Уг хөтөлбөр нь дараах үндсэн гурван дэд бүрэлдэхүүнтэй:

1. LEAD АНУ-ын солилцооны болон Монгол дахь хөтөлбөр
2. LEAD Alliance хөтөлбөр
3. LEAD Ахлах ангийн иргэний боловсрол хөтөлбөр

IRIM нь эдгээр хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээг хийж, гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Хөндлөнгийн үнэлгээний хүрээ, үндсэн асуултуудыг боловсруулахдаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн тусламжийн хороо (OECD-DAC)-ноос боловсруулсан доорх үнэлгээний шалгууруудыг ашигласан.



Үнэлгээний хүрээнд тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргуудыг хослуулан ашигласан. Доорх хүснэгтэд тоон болон чанарын аргаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн харуулав.




ҮР ДҮН

LEAD АНУ-ын солилцооны болон Монгол дахь хөтөлбөрийн төгсөгчид, мөн LEAD Alliance хөтөлбөрийн оролцогчид энэ хөтөлбөрт хамрагдсанаар техникийн болон зөөлөн ур чадвараа нэмэгдүүлж чадсан гэж мэдээлсэн. Үүнээс гадна эдгээр хөтөлбөрүүдэд оролцогчдын 50-иас илүү хувь нь хөтөлбөрт хамрагдсанаар

хувийн болон мэргэжлийн хувьд хөгжиж чадсан, хөтөлбөрт зарцуулсан цаг хугацаа хангалттай байсан, хөтөлбөрөөс олж авсан мэдлэгээ ажилдаа ашиглаж эхэлсэн гэдгээ илэрхийлсэн. Доорх зурагт хөтөлбөрт оролцогчдын хөтөлбөрөөс олж авсан ур чадварыг нэгтгэн харуулав.

Хөтөлбөрт оролцогчдын олж авсан ур чадварууд




Үнэлгээнд мөн LEAD Mongolia хөтөлбөр нь Монголын ахлах ангийн сурагчдын ардчиллын оролцооны талаарх чадавх, ойлголтыг нэмэгдүүлж, бэхжүүлсэн эсэхийг судалсан. Үнэлгээгээр LEAD Mongolia хөтөлбөрийн Ахлах ангийн иргэний боловсролын бүрэлдэхүүн хэсэг нь ахлах ангийн сурагчдыг чадавхжуулах замаар ардчилсан оролцоонд залуучуудыг бэлтгэх зорьсон үр дүндээ хүрсэн гэж дүгнэв. Хөтөлбөр хэрэгжүүлэгчид ахлах

ангийн сурагчдын ардчиллын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдний дуу хоолойг хүргэх, төлөвлөх, сургууль болон орон нутгийн түвшинд тулгарч буй асуудлуудаа шийдвэрлэх, сурагчдын нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих замаар тус үр дүнд хүрчээ.

LEAD хөтөлбөрийн Иргэн төсөлд хамрагдсан ахлах ангийн сурагчдын мэдлэгийн өөрчлөлт



LEAD Mongolia хөтөлбөрийн гол гурван нөлөө



Хөтөлбөрийн бүх гурван бүрэлдэхүүн хэсгийн оролцогчид LEAD Mongolia хөтөлбөр нь залуучууд болон алслагдсан олон нийтийг эерэг өөрчлөлтийн төлөөлөгч болгоход нөлөөлж чадсан гэдэгтэй санал нэгдсэн. Хөтөлбөрт оролцогчид LEAD Mongolia хөтөлбөрт хамрагдсанаар ардчилал, манлайллын ач холбогдол, иргэний оролцооны талаарх мэдлэгээ нэмэгдүүлж чаджээ. Дараах зурагт LEAD Mongolia хөтөлбөрийн оролцогчдын дунд хамгийн их үзүүлсэн нөлөөг тоймлон харуулав.

Үнэлгээний үр дүнд үндэслэн дараах 3 гол санал зөвлөмжийг боловсруулав:

- 1. LEAD Mongolia хөтөлбөрийн хүрээнд бий болсон сүлжээг илүү системтэй, тогтвортой болгох.** LEAD төгсөгчдийн холбоо нь LEAD Mongolia хөтөлбөрийн үе үеийн төгсөгчдийг холбож зохион байгуулалтад оруулахад чухал ач холбогдолтой хэрэгсэл юм. Ингэхдээ олон төрлийн нийгмийн сүлжээг ашиглах хэрэгтэй. LEAD сүлжээг ирээдүйд яриа, хурал зохион байгуулах, бусад санхүүжүүлэгчид, Олон улсын санхүүгийн байгууллагууд болон засгийн газартай холбогдон хөрөнгө, төсөл хөтөлбөр боловсруулах, хамтран хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой.
- 2. LEAD Mongolia хөтөлбөрийн хүрээнд хэрэглээнд нэвтрүүлсэн сурах бичиг, сургалтын хөтөлбөрүүдийг одоогийн ЕБС-уудын хичээлийн хөтөлбөрт нэгтгэх.** “Ардчиллын үндэс” ба “Иргэн төсөл”-ийн хүрээнд ашигласан сургалтын хэрэглэгдэхүүн/ сургалтын хөтөлбөр нь багш, сурагчдын аль алиных нь хэрэгцээнд нийцсэн. Иймд, LEAD Mongolia хөтөлбөрийн нэвтрүүлсэн энэхүү сургалтын хөтөлбөрийг ахлах сургуулийн одоогийн Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрт нэмж оруулах замаар багш нар заах, хичээлийн жилийн төлөвлөгөөнд багтаан холбогдох үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх боломжтой.
- 3. Монголд хэрэгжиж буй бусад засаглалын хөтөлбөрүүдэд LEAD хөтөлбөрийн сайн туршлагыг нэвтрүүлэх.** Үүнд: Хөтөлбөрт хамрагдах шалгуурыг 40 нас хүртэл болгож өсгөх; Оролцогчдыг тусгай хэрэгцээ, жендерийн эрх тэгш байдлыг харгалзаж сонгох; Ардчиллын үнэт зүйлс, хүртээмжтэй байдал, эрх тэгш байдлыг сургах сургалтын үйл ажиллагаа; Төслийн санал боловсруулах, олон нийтийн төслүүдийг удирдан хэрэгжүүлэх талаар сургалтууд; Семинар, хурал, чуулган гэх мэт биечилсэн харилцааны арга хэмжээнүүд.

УХААЛАГ ГАР УТАСНЫ АУДИО МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ТӨСӨЛ



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

АППЕН

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү ажлын гол зорилго нь Монгол хэл авианы дуудлагыг судалж, танин мэдэхэд чиглэсэн юм. IRIM нь төсөлт ажлын хүрээнд, Монгол эх хэлтэй хүмүүсийг хамруулж дуу хоолойг бичих, бичлэгийн чанарыг хангах, энэ цуглуулсан бичлэгийн дата санг хүлээлгэн өгөх гол зорилтуудыг хангаж ажилласан.



2021

7-р сар

2022

1-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дата, өгөгдлийн сан бүрдүүлэх чиглэлээр мэргэшсэн APPEN ОУБ-ын захиалгаар дуу хоолой таних (voice recognition) гар утасны аппликейшн хөгжүүлэлтэд ашиглах аудио мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэлээ. Улмаар төсөлт ажлын хүрээнд Монгол хэл авианы дуудлагыг ухаалаг гар утасны аппликейшнд таниулах юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

IRIM нь төсөлт ажлын хүрээнд, зааварчилгааны дагуу 2415 Монгол эх хэлтэй хүмүүсийг хамруулсан. Оролцогч бүр нь ухаалаг гар утасны аппликейшн дээр 1 бүтэн бичлэгийг бүрэн уншиж дуусгана. Оролцогчид нь 16-60 насны хооронд бөгөөд ямар нэгэн аялгагүй байх шаардлагыг хангасан байх ёстой. Оролцогчдыг олохын тулд социал болон олон нийтийн зарын самбаруудад, байгууллагын дотоод сүлжээгээр зар тавих байдлаар хамруулсан бөгөөд дуу хоолой уншихаас өмнө шаардлага хангаж буй эсэхийг шалгаж байсан. Үнэлгээний хүрээнд тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргуудыг хослуулан ашигласан. Доорх хүснэгтэд тоон болон чанарын аргаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн харуулав.

ҮР ДҮН

Судалгаанд оролцох шалгуур хангасан оролцогчдод урьдчилан бэлтгэсэн сэдэвчилсэн текстүүдийг өгч уншуулан дуу хоолойн мэдээлэл цуглуулах нь энэ төслийн гол үйл ажиллагаа юм. Нийт 2450 гаруй хүнээс мэдээлэл цуглуулснаас 2415 шаардлага хангасан мэдээллийг хүлээлгэж өгсөн. Бичигдсэн мэдээлэл нь хүлээн зөвшөөрөгдөхийн тулд дараах шалгуурыг хангасан байх ёстой байв. Үүнд:

- Ярьж байх үед оролцогчийн дуу хоолойноос өөр чанга дуу чимээг бичлэгт оруулахгүй байх
- Хэт их цуурайтай орон зайгаас зайлсхийх
- Хэл яриаг хэтрүүлэхүйц дуу чимээ агуулахгүй
- Таслахгүй - Оролцогчид үг бүрийг уншихын өмнө болон уншсаны дараа дор хаяж 0.5 секунд чимээгүй байх
- Хэт их цуурай гаргахгүй
- Уншихын өмнө болон уншсаны дараа чанга ярих, уруулаа шахах, хүндээр амьсгалах гэх мэт өндөр дуу чимээ гаргахгүй байх
- Оролцогчдоос өөр хүний дуу хоолой агуулахгүй
- Нэгээс илүү буруу уншсан үг агуулахгүй
- Хувийн нууцыг зөрчсөн мэдээлэл агуулахгүй
- Жендерийн онцлогтой текстийн хувилбаруудыг тохирох хүйсийн хүн унших зэрэг шаардлагуудыг хангаж ажиллав.

Энэхүү төсөл нь зөвхөн дуу хоолойны мэдээлэл цуглуулах төсөл байсан бөгөөд судалгааны баг мэдээллийн санг захиалагч талд хүлээлгэн өгсөн. Бидний цуглуулсан мэдээллийг ашиглан Монгол хэл авианы дуудлагыг ухаалаг гар утасны аппликейшнд таниулах юм.

МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ БОЛОН СОЁЛЫН СУДАЛГАА - I-III



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Японы Кобе Их Сургууль

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Японы Кобе Их сургуулийн судалгааны багийн санаачлан хэрэгжүүлж буй “Монголчуудын амьдралын хэв маяг болон соёлын судалгаа”-ны тоон мэдээллийг цуглуулах зорилготой.



2021 7-р сар

2022 1-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, Өвөрхангай аймгийн Хужирт сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Японы Кобе их сургуулийн судалгааны баг “Монголчуудын амьдралын хэв маяг болон соёл” сэдэвт судалгааны ажлынхаа хүрээнд судалгааны тоон мэдээлэл цуглуулах үйл ажиллагаандаа мэргэжлийн дэмжлэг авах үүднээс IRIM судалгааны хүрээлэнд анх 2018 онд хандсанаар уг төсөл 3 дахь удаагаа хэрэгжиж байна.

Тоон мэдээлэл цуглуулалтын ажил 2018 онд судалгааны үндсэн аргагүй, хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулалтын арга зэргийг турших, 2019 онд төслийн суурь судалгааны мэдээллийг цуглуулах зорилготойгоор хэрэгжиж байв. Үүнээс гадна 2019 оны суурь судалгааны мэдээлэл цуглуулалт хийгдсэний дараа судалгаанд хамрагдсан өрх бүрийн хаягийг Нийслэлийн газрын зураг болон холбогдох бүртгэлүүдтэй тулгаж, бүртгэл санг үүсгэж байв.

Харин энэ удаад 2019 оны суурь судалгааны мэдээлэлд харьцуулалт хийж, судалгаанд оролцсон иргэдийн амьдралын хэв маяг, соёлд гарсан өөрчлөлтийг судлах зорилготой давтан судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсантай

холбоотойгоор бид 2022 оны 1 сард мэдээлэл цуглуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа тоон судалгааны асуулга болон оролцоонд суурилсан тоглоомын аргыг ашиглалаа. Захиалагчаас судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг урьдчилан илгээдэг бөгөөд төслийн багаас хэрэглэгдэхүүнүүдийг орчуулах, турших, сайжруулах ажлуудыг хариуцан гүйцэтгэдэг. 2018 болон 2019 оны судалгаанд 302 ба 668 өрхийн тэргүүнийг хамруулсан бол 2022 онд 767 өрхөөс мэдээлэл цуглуулсан. Судалгаагаар амьдралын орчин нөхцөл буюу дэд бүтэц, итгэлцэл, улс төрийн оролцоо, нийгмийн харилцааны талаар мэдээллийг цуглуулсан.

Түүврийн хэмжээ, жил, зорилтот талбараар

Жил	Хот/ аймаг	Дүүрэг/ сум	Хороо/ баг		Нийт
2018 оны туршилт судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	11-р хороо	Орон сууцны оршин суугчид	302
			12-р хороо	Гэр хорооллын оршин суугчид	
		Сонгинохайрхан дүүрэг	19-р хороо	Орон сууцны оршин суугчид	
			7-р хороо	Гэр хорооллын оршин суугчид	
	Өвөрхангай аймаг	Хужирт сум	5-р баг	Сумын төвийн оршин суугчид	
			2-р баг	Сумын төвөөс зайдуу оршин суудаг иргэд	
2019 оны суурь судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	18-р хороо	Гэр хорооллын дэд бүтцийн төвийн үйлчилгээ нэвтрэх бүсийн оршин суугчид	668
		Чингэлтэй дүүрэг	7-р хороо		
2022 оны харьцуулсан судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	18-р хороо	Гэр хорооллын Дэд бүтцийн төвийн үйлчилгээнд хамрагдсан/ хамрагдаагүй оршин суугчид	767
		Чингэлтэй дүүрэг	7-р хороо		

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэ ажлын хувьд IRIM судалгааны хүрээлэн иргэдээс тоон мэдээлэл цуглуулж, цугларсан мэдээлэлд чанарын хяналт хийх, нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, мэдээлэл цуглуулалтын техникийн тайлан боловсруулах үүрэгтэй бөгөөд судалгааны үр дүнг боловсруулж, олон нийтэд танилцуулах эрхгүй юм.

НЗДТГ-Н АЛБАН ХААГЧИД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН “СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУДАЛГААНЫ ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү зөвлөх үйлчилгээний гол зорилго нь 'Хотын засаглалыг сайжруулах нь төслийн Үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүн-1-ийн хүрээнд НЗДТГ-ын болон Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн ажилтан албан хаагчдын судалгаа шинжилгээний чадавхыг бэхжүүлэхэд оршино. Үүнтэй холбоотойгоор дараах зорилтуудад хүрч ажиллаа.

- Судалгааны арга зүйн гарын авлагыг сайжруулан боловсруулах;
- Жендерийн мэдрэмжтэй судалгаа болон судалгааны арга зүй, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих болон суурь болон нөлөөллийн үнэлгээний сургалтын материал боловсруулах;
- НЗДТГ-ын болон Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн ажилтан албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах.



2021

8-р сар

2022

1-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Хотын засаглалын сайжруулах төсөл нь нийслэлийн иргэдэд тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад илүү хүргэх, хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах болон иргэдтэй хамгийн ойр ажилдаг хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч болон дүүрэг, нийслэлийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар хотын оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Энэ зорилгын хүрээнд IRIM нь анх 2018 онд “Судалгааны арга зүйн гарын авлага”, “MS Excel программын гарын авлага”-ыг төрийн албан хаагчдад зориулан боловсруулж, сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж байсан. Энэхүү төслийн үргэлжлэл болгож 2021 онд өмнөх “Судалгааны арга зүйн гарын авлага”-ыг сайжруулан боловсруулах, шинэчилсэн агуулгаар сургагч багш бэлтгэх сургалтыг сонгогдсон төрийн албан хаагч нарын дунд зохион байгуулах ажлыг дахин гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээ нь бэлтгэл, гарын авлага сайжруулан боловсруулах, сургалт зохион байгуулах, тайлагнах үе шат гэсэн үндсэн дөрвөн үе шатанд хэрэгжсэн. Ингэхдээ судалгааны гарын авлага сайжруулан боловсруулахдаа хэрэгцээнд нийцүүлэн олон төрлийн судалгаа шинжилгээний аргачлал, арга зүйг ашигласан бөгөөд сургалт нь оролцооны, хэрэгцээнд суурилсан дадлага ажлуудад тулгуурлан явагдсан.

1. Судалгааны арга зүйн гарын авлага сайжруулах ажлын хүрээнд:
 - Төрийн албан хаагчдын болон сургагч багш нарын судалгааны арга зүйн мэдлэг, ойлголтыг тодорхойлох болон ажлын байран дээр ашиглагдах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулсан.
 - Хэлэлцүүлгийн үр дүн болон баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн одоогийн судалгааны арга зүйн гарын авлагыг сайжруулах хүрээ, төлөвлөгөө гарган танилцуулсан.
 - Судалгааны арга зүйн гарын авлагыг сайжруулж, оролцогч талуудад танилцуулан, баталгаажуулах хэлэлцүүлэг зохион

байгуулсан.

- Оролцогч талуудаас гарсан саналын дагуу судалгааны арга зүйн гарын авлагыг сайжруулж эцэслэсэн.
2. Сургагч багш нарт зориулсан сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

- Сургагч багш нар болон төрийн албан хаагчдын дунд судалгааны арга зүйн сургалт зохион байгуулахад тулгардаг бэрхшээл, эзэмших шаардлагатай байгаа үр чадварын хэрэгцээ тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн сургагч багш нарт зориулсан судалгааны арга зүйн хичээлийн гарын авлагыг боловсруулсан.
- Тус гарын авлагын хүрээнд сургагч багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр бэлтгэн, хөтөлбөрийн дагуу цуврал сургалтууд зохион байгуулсан. Сургалтыг цуврал байдлаар зохион байгуулсан нь дараах зорилготой байсан.

1. Гарын авлагад тусгах жишээ, кэйсийг оновчтой зөв тодорхойлох. Сургалтын явцад тухайн агуулгад хамгийн тохиромжтой жишээ, кэйсийг сургагч багш нартай хамтран тодорхойлж, түүнийгээ хичээл бүр дээр дасгал ажлаар хөгжүүлж, хэрэгжүүлж ажилласан.

2. Сургалтын үйл ажиллагааг чанартай, оролцогчдын саналд тулгуурласан байдлаар зохион байгуулах. Үүний хүрээнд сургалт бүрийн дараа сургагч багш нараас сургалттай холбоотой санал, сэтгэгдлийг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлж, дараагийн сургалтдаа тусгаж ажилласан.

3. Сургагч багш нарыг дадлага, практик ажлаар хөгжүүлэх. Хамгийн эхний сургалтын дараагаар сургалтад оролцогчдыг гурван багт хуваарилсан бөгөөд баг тус бүрээр хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд хийгдэх боломжтой судалгааны сэдэв сонгуулж, сургалтын хугацаанд бүтэн судалгааны ажил гүйцэтгэж зөвлөх үйлчилгээний баг судалгааны туршид ментор хийж ажилласан.

Мөн сургагч багш нар цаашид ашиглах сургалтын танилцуулга PPT болон видео хичээлийг тус тус боловсруулаад байна.


ҮР ДҮН

Зөвлөх үйлчилгээний хүрээнд IRIM судалгааны хүрээлэнгийн баг сургагч багш нарт зориулсан “Судалгааны арга зүйн” гарын авлага болон үр шим хүртэгчдэд зориулсан гарын авлага тус тус боловсруулсан. Сургагч багшийн гарын авлага нь хичээл зохион байгуулах төлөвлөгөө болон багш нарт зориулсан зөвлөмж, санамж зэрэг хэсгүүдийг оруулснаараа үр шим хүртэгчдийн гарын авлагаас ялгаатай. Одоогоор гарын авлага хянагдаж, хэвлэлтэд бэлтгэх шатанд явж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээний үе шат бүрд оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад үндэслэн гол бүтээгдэхүүнүүдийг боловсруулж сургагч багш бэлтгэх сургалтыг илүү оролцооны аргаар зохион байгуулсан тул цаашид төрийн албан хаагчдын судалгааны үр чадварыг сайжруулах, бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэж найдаж байна.



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН СОРИЛТУУДЫГ ХЭЛЭЛЦЭХ ҮНДЭСНИЙ ФОРУМ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Хөгжлийн Банк

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО


Боловсрол Шинжлэх Ухааны Яам төрийн өмчийн зургаан гол их сургууль, зөвлөх компани, АХБ-тай харилцан зөвшилцсөний үндсэн дээр IRIM-ийн баг бүрэлдэхүүн Үндэсний форумын Салбар хуралдаануудыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, тус нэмэр үзүүлэх, баримтжуулах, тайлагнах ажлыг хариуцан ажиллалаа.



2021 12-р сар

2022 2-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газраас Азийн хөгжлийн банк (АХБ)-нд хандан салбар дундын судалгаа, ахисан түвшний сургалт, технологи дамжуулах, тэдгээрийг эдийн засгийн эргэлтэд оруулах, чадварлаг ажилтныг бэлтгэх үндэс суурь нь болох судалгааны их сургуулиудыг хөгжүүлэх, (Судалгааны их сургуулийг хөгжүүлэх төсөл) зургаан томоохон төрийн өмчит их сургууль, төрийн өмчит судалгааны хүрээлэнгүүд болон аж үйлдвэрийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг авахаар хандсан.

Төсөл нь гурван бүрэлдэхүүн хэсэг үр дүнтэй байна: (1) ахисан түвшний сургалт, судалгааг сайжруулах бодлого, институтийг олон улсын стандартад ойртуулж бэхжүүлнэ; (2) судалгааг дэмжих болон судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог хөгжүүлнэ; (3) Монгол Улсын хөгжлийн сорилтуудыг амжилттай шийдвэрлэх судалгааны Жишиг төв байгуулж, ажиллуулна.¹

¹ADB Project brief

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үндэсний дэд форумын семинарын дизайн гаргах, бэлтгэл ажил

- Нэгдсэн хуралдаан, салбар худалдааны дизайны нарийвчилсан мэдээллийг боловсруулж, гурван хулалдааны арга хэрэгсэл, материал, баримтжуулалтын зохион байгуулалтыг бэлтгэх.
- Үндэсний таван дэд форумын семинар тус бүр дээр оролцогч талуудын урьдчилан таамаглал гаргах.
- Үндэсний дэд форумын семинар, хөгжлийн таван сорилттой холбоотой тойм илтгэл(үүд) болон материалыг бэлтгэх.
- Үндэсний форумын таван салбар худалдаанд оролцогчдод зориулан Үндэсний форумын өмнөх материалыг бэлтгэх.
- Хаалтын худалдааны тайлангийн загвар болон бусад зохицуулалтыг бэлтгэнэ.

Дэд үндэсний форумын семинарт дэмжлэг үзүүлэх, баримтжуулах

- Үндэсний таван дэд форумын семинар бүрийн салбар хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Үндэсний таван дэд форумын гурван хуралдааны хэлэлцүүлэг, үйл ажилгааг баримтжуулах
- Нэгдсэн хуралдааны хаалтын хуралдаанд илтгэл тавих
- Хэлэлцүүлэг бүрийн дараа үр дүнгийн талаар хэлэлцүүлэх, дараагийн хуралдааны дэгийг тодорхойлох, бэлтгэл хангах
- Үндэсний хуралдааны нэгдсэн хэлэлцүүлэг болон салбар хуралдаануудын илтгэл болон бусад материалыг илтгэх

Үндэсний дэд форумын семинарын талаар тайлан гаргах

- Нэгдсэн хуралдаан, салбар хуралдааны хэлэлцүүлэг, үйл ажиллагааны нарийвчилсан хураангуй тайланг тус бүрд нь бэлтгэх, үүнд хуралдаан бүрийн оролцогчдын жагсаалт, ашигласан багаж хэрэгсэл, материал, танилцуулга, илтгэлүүдийг багтаасан болно.

ҮР ДҮН

Баг нь таван чиглүүлэгч, арван дэд чиглүүлэгчдээс бүрдэнэ. Боловсрол Шинжлэн Ухааны Яам болон төрийн өмчийн зургаан гол их сургууль дараах дэд форум семинаруудыг бэлтгэж, зохион байгуулахад IRIM-ийн багтай хамтран ажиллахаар таван зохицуулагч, тэргүүлэгч их дээд сургуулиудыг нэр дэвшүүлсэн:

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан хэлэлцүүлэг нь дараах 5 сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан Үүнд:

Хэлэлцүүлэг 1: ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээ;

Хэлэлцүүлэг 2: байгалийн болон биологийн нөөцийн удирдлага ба боловсруулалт;

Хэлэлцүүлэг 3: цэвэр эрчим хүч ба эрчим хүчний хэмнэлт;

Хэлэлцүүлэг 4: насан туршийн болон дасан зохицох суралцахуй;

Хэлэлцүүлэг 5: эрүүл мэнд.

Үндэсний чуулганы хаалтын нэгдсэн хуралдаанд салбар хуралдаан, хамтарсан хаалтын тайлангийн хэсгээс бүрдэнэ.

Энэхүү төсөлд IRIM нь техникийн туслалцаа үзүүлэх байсан бөгөөд хэлэлцүүлгийн үр дүн, дүгнэлт гаргаагүй болно.


“ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ ТӨСӨЛ”-ИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эх сурвалж: GIZ

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа,
Хөгжлийн Яам

Австрали улсын Гадаад Хэрэг, Худалдааны Яам

Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Үнэлгээний зорилт нь Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТСТМБС) төслийн амжилт, үр нөлөөг судлах юм.

Үнэлгээний баг ТСТМБС төслийн үндсэн үр дүн, үр нөлөөтэй байдлын талаар төслийн оролцогч талуудын санал, бодлыг цуглуулна. Төлөвлөсөн болон төлөвлөөгүй өөрчлөлтүүдийг гол оролцогчид хэрхэн үнэлснийг судлах нь даалгаврын тэргүүлэх чиглэлүүдийн нэг байсан. Тэр дундаа, судалгаанаас дараах зүйлийг тодруулахыг эрэлхийлэв. Үүнд:

- Яагаад төлөвлөөгүй өөрчлөлт гарсан, тэдгээр нь төсөлтэй хэр зэрэг холбоотой байж болох,
- Түншүүдийн хүлээж байсан хэдий ч гараагүй өөрчлөлтүүдийг тодорхойлох,
- Гол оролцогчид төслийн эцэст ямар өөрчлөлтүүдийг харахыг хүсэж байсан, болон
- Үйл ажиллагааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох




2021

10-р сар

2021

12-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, Завхан аймаг, Өмнөговь аймаг, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг нь (ГОУХАН) 2019 оны 3-р сараас 2023 оны 12-р сарын хооронд Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТСТМБС) төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд Монгол Улс дахь техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын үйл явцад шинэчлэл хийх ажлыг дэмжин ажиллаж байгаа. Төслийг Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамтай (ХНХЯ) хамтран хэрэгжүүлж байгаа ба Герман, Австрали, Солонгос Улсын Засгийн Газрууд санхүүжүүлж байна. Тус төсөл нь мэргэжлийн багшийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, "чадамжийн төв"-ийг хөгжүүлэх замаар барилга, цахилгаан, механикийн мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулах зорилготой бөгөөд нийт 7 техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын сургуулиудын чадамжийн төв болгож тогтвортой хөгжүүлэхэд ХНХЯ-д дэмжлэг үзүүлэх, цаашлаад тэдгээр төвүүдийг баруун, зүүн, төв, өмнөд болон Улаанбаатарын бүсийн төв болгох бололцоог олгох зорилготой. IRIM судалгааны хүрээлэн нь уг төслийн чанарын судалгааг хийлээ.


ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээг ГОУХАН-ийн KOMPASS стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэсэн. Энэ аргачлал нь төрөл бүрийн харах өнцөг, үзэл бодлыг нээлттэй, системтэй, чанарт суурилсан байдлаар баримтжуулах (хамтран ажиллагчид болон зорилтот бүлгийн)-д төвлөрдөг.


Үнэлгээг урьдчилан батлагдсан шинжилгээний аргачлалын дагуу нийт 67 оролцогчид руу чанарын судалгаа авахаар хандсан.

Ганцаарчилсан ярилцлагыг 29 хүнтэй (мөн төслийн үндсэн гурван зорилтыг хариуцсан гурван ахлах мэргэжилтэнтэй, Монгол дахь KOICA-гийн төлөөлөгчид) хийсэн.

ГМЯ-ын түүврийн хэмжээ



ФБХ-ийн түүврийн хэмжээ



Фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ) - нийт 5 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт эрэгтэй 20, эмэгтэй 13, нийт 33 хүн оролцсон.

Жилийн тайлан, холбогдох статистик тоо баримт, хууль эрх зүйн болон бодлогын тогтолцоо, судалгаа, санал асуулгын (2019-2021 оныг хамарсан) баримт бичгийн судалгааг гүйцэтгэсэн.

ҮР ДҮН

Багш нарын мэргэжлийн чадварыг бэхжүүлэхэд оруулсан уг төслийн томоохон хувь нэмрийг сургуулиудын захирал, менежерүүд нотолж байна. Тэдний ажигласнаар төсөл хэрэгжсэн сургуулийн багш нарын арга зүй нь олон улсын зөвлөх, багш нарын тусламжтайгаар мэдэгдэхүйц өөрчлөгдсөн, хичээлүүд илүү практик болсон гэжээ. Мөн бүх сургуулиуд сургуулийнхаа сургалтын орчин сайжирч байгаад сэтгэл хангалуун байна. Сургуулийн сурах бичиг, хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь төслийн сургуулиуд болон хувийн хэвшлийнхний талархлыг хүлээсэн.

Төслийн хүрээнд боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг онцолсон нь боловсролын байгууллагуудтай хамтран

ажиллахын ач холбогдлын талаарх ойлголтыг хувийн хэвшлийн бусад оролцогчдын дунд нэмэгдүүлсэн. Олон улсын ур чадварын стандартын удиртгалыг нэвтрүүлснээр хувийн хэвшилд бүхэлд нь үр өгөөжөө өгсөн. Багш нарын зөөлөн ур чадварт хөрөнгө оруулалт хийсэн нь оюутан, төгсөгчдийн ажилдаа хандах хандлага, аюулгүй байдлын арга хэмжээ, харилцаа холбоог сайжруулсныг үнэлгээний ярилцлагад хамрагдсан хувийн хэвшлийнхэн өндрөөр үнэлж байлаа.

COVID-19 цар тахал төслийн хэрэгжилтэд илэрхий нөлөө үзүүлсэн. Багш нарт зориулсан сургалт цахимаар зохион байгуулагдсан нь хүлээгдэж буй үр дүнг сулруулсан. Гэсэн хэдий ч багш, оюутнуудын зайнаас суралцах буюу цахимаар суралцах ур чадвар сайжирсан. Төслийн зарим үйл ажиллагаа зогсонги байдалд орж, хойшлогдсон бөгөөд үйл ажиллагааны дараалал өөрчлөгдсөн. Хувийн хэвшлийнхэнтэй хийх хамтын ажиллагаа тасалдсан тул Мэргэжлийн зөвлөл болон тогтмол зохион байгуулагддаг бусад хурал, арга хэмжээ цуцлагдаж байсан. Оюутнуудад зориулсан практик сургалтууд тасалдсан ба энэ нь төгсөгчдийн чанар муудах шалтгаан болсон. Олон оюутнууд чанартай интернэт, тоног төхөөрөмжид холбогдох боломжгүй байсан нь дижитал цоорхой (gap) бүх түвшинд байгааг харуулж байна. Үүнээс гадна энэ

нь төслийн бүх оролцогч талуудын дунд дижитал мэдлэгийн сорилтыг бий болгосон.

Сургуулиудад Мэргэжлийн зөвлөл байгуулагдсан нь олон өөрчлөлтийг авчирсан. Гэсэн хэдий ч хувийн хэвшлийн өргөн хүрээний оролцогчдод боловсролын салбартай түншлэн ажиллахын ач холбогдлын талаар сургалт, сурталчилгаа хийх шаардлагатай байна. Төслийн үйл

ажиллагааг өргөжүүлэх (давтан хэрэгжүүлэх), эрэлт хэрэгцээг хангахын тулд олон амжилттай хамтын ажиллагааны түүх, тохиолдлуудыг дурдах шаардлагатай юм. COVID-19 цар тахлын үеэр зогсонги байдалд орсон Мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг дахин идэвхжүүлэх шаардлагатай байна.

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН “А” ХЭСГИЙН ОРЧНЫ БҮСИЙН МАЛЧДЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ СУДАЛГАА

ZSL
LET'S WORK
FOR WILDLIFE



Эх сурвалж: Arav.mn

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны ажлын зорилго нь Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцох замаар тодорхойлох болон орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгааллын асуудал, иргэдийн оршин суугаа нутгийнхаа байгаль, зэрлэг амьтдад хандах иргэдийн мэдлэг, хандлагыг тодорхойлоход чиглэсэн.




2022

2-р сар

2022

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын "А" хэсэгт хамаарах:
Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн баг, Шинэжинст сумын Уртын гол баг,
Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг, Цогт сумын Баянтоорой тосгон, Эрдэнэ сумын Өлзийт баг*

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

"Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг"-ийн 2021-2024 оны хооронд хэрэгжүүлж байгаа "Их говийн нүүдэлч малчдыг дэмжин, хавтгай тэмээг хамгаалах" төслийн хүрээнд энэхүү судалгааг зохион байгуулж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН


Судалгааг Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын "А" хэсэгт хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн баг, Шинэжинст сумын Уртын гол баг, Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг, Цогт сумын Баянтоорой тосгон болон Эрдэнэ сумын Өлзийт багийн 69 малчин өрхийг хамруулан зохион байгуулсан.

Судалгааны арга зүйн ерөнхий хүрээг доорх зурагт үзүүлээ. Судалгааны баг зорилгодоо хүрэхийн тулд үндсэн хоёр зорилтыг дэвшүүлээ.

Зорилт 1. Аргачлал: Говийн Их Дархан Цаазат Газрын "А" хэсгийн Орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцохдоо дараах хоёр төрлийн ядуурлын гүнзгийрлийг хэмжиж байна. Үүнд:

1. Ядууралд хамрагдах тохиолдол буюу (өгөгдсөн хүн амын) олон хэмжээст ядууралд өртсөн хүн амын харьцаа
2. Ядууралд хамрагдах тохиолдол буюу (өгөгдсөн хүн амын) гачигдал хомсдолын эрчимжилт буюу гачигдал хомсдолын жинлэгдсэн дундаж харьцаа

ОХЯИ-ийг тооцох аргачлалыг уг тайлангийн "Өрхийн аж ахуй болон эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт" хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн.



A1 - зорилтот бүлгийн суурь судалгааны үр дүн

A2 - зорилтот бүлгийн эцсийн шатны үнэлгээний үр дүн

X - энэхүү төслийн гол үр дүн.

Эцсийн төслийн үр дүн интервенц нь X-ээр хэмжигдэнэ. Энэхүү судалгааны загвар нь суурь судалгааг хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц, давтагдах боломжтой болгоно.

Зорилт 2. Аргачлал: Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн Орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгааллын асуудалд төслийн зорилтот бүс нутгийн иргэдийн мэдлэг ойлголт, хандах хандлагыг тодорхойлсон. Тус зорилгод хүрэхийн тулд судалгааны баг 69 өрхөөс авсан тоон өгөгдлийг ашиглан энгийн статистик шинжилгээ, судалгааны түлхүүр үзүүлэлт болон хүн, ам зүйн мэдээлэлтэй харьцуулсан шинжилгээ хийсэн.

Судалгааны загвар: Энэхүү судалгааг хийхдээ өмнө ба дараа судалгааны загварыг ашигласан. Загварын дэлгэрэнгүйг доорх зурагт үзүүлэв.

ҮР ДҮН

Төслийн тайланд өрхийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг судалгааны баг ОХЯИ тооцож, өрхөөс авсан асуулга мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар төслийн нийгэм, эдийн засгийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийг гаргасан.

Олон хэмжээст ядуурлын индекс

Суурь судалгаанд 5 багийн 69 өрхийн түүвэр өгөгдлийг ашиглан олон хэмжээс ядуурлын индексийг тооцлоо. Уг индекс тооцоололд аргачлалын дагуу:

1. Боловсрол (суралцсан жил, сургуульд хамрагдалт),
2. Эрүүл мэнд (нялхсын эндэгдэл, хоол хүнсний шим тэжээл),
3. Амьжиргааны түвшин (цахилгаан, ундны ус, ариун цэврийн нөхцөл, гэр, байр, орон сууцны шал, хоол унд хийх түлш, өмч хөрөнгийн эзэмшил) гэсэн 3 бүлэг, 10 дэд үзүүлэлтийг түүврийн асуулгын харгалзах асуултуудад үндэслэн 0, 1 гэсэн утга оноон, кодолж, тухайн өрхийн ядууралд өртсөн эсэхийг ядуурлын оноог (deprivation score) тооцох замаар тодорхойлов.

Нийт өрхийн 33.3% нь суралцах хугацааны дундаж жилийг илэрхийлдэг индикаторт гачигдалтай, 2.9% нь сургууль завсардсан гишүүнтэй, 14.5% нь хоол хүнсний шим тэжээлийн дутагдалтай гишүүнтэй байна. Амьжиргааны түвшний индикаторын хувьд 95.7% нь ариун цэврийн нөхцөл байдлын хувьд гачигдалтай, 95.7% нь хоол ундандаа ашигладаг түлшний хувьд гачигдалтай, 87.0% нь ундны усны эх сурвалж хол зайтай эсвэл баталгаатай биш, 81.2% нь гэр орон сууцны шалны материалын хувьд гачигдалтай байна. Үзүүлэлт болон тухайн үзүүлэлт дээр ядууралд өртсөн өрхийн тоог Хүснэгт 1-д дэлгэрэнгүй харууллаа.

Олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүд¹

	Үзүүлэлтүүд	Ядууралд өртсөн өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувь
A	Боловсрол		
1	Суралцсан жил	23	33.3%
2	Сургуульд хамрагдалт	2	2.9%
Б	Эрүүл мэнд		
3	Нялхсын эндэгдэл	0	0.0%
4	Хоол хүнсний шим тэжээл	10	14.5%
В	Амьжиргааны түвшин		
5	Цахилгаан	2	2.9%
6	Ундны ус	60	87.0%
7	Ариун цэврийн нөхцөл	66	95.7%
8	Гэр, байр, орон сууцны шал	56	81.2%
9	Хоол унд хийх түлш	66	95.7%
10	Өмч хөрөнгийн эзэмшил	0	0.0%

Гол үр дүнг нэгтгэвэл зорилтот багуудын хувьд амьжиргааны түвшнийг илтгэдэг олон хэмжээст ядуурлын индекс 0.114 гарсан. Тодруулбал нийт судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 28.2% ядууралд өртсөн байгаа нь Монгол Улсын ядуурлын хамрах хүрээнээс 0.4%-аар өндөр байна(2020 оны байдлаар МУ-ын ядуурлын хамрах хүрээ 27.8). Ядуурлын эрчимжилт 0.406 гарсан ба нийт ядууралд өртсөн өрхийн 40.6% нь бүх индикаторын хувьд гачигдалтай байгааг харуулж байна. Өрхийн эдийн засгийн сайн сайхан байдлын хэмжүүрийг харууллаа.

Дүгнэвэл түүвэрт хамрагдсан өрхүүдийн олон хэмжээст ядуурлын индекс тооцоход 10 дэд үзүүлэлтийн 2 буюу өрхүүдийн хөрөнгө эзэмшил болон нялхсын эндэгдлийн үзүүлэлтүүд боломжийн түвшинд байсан боловч амьжиргааны түвшний бусад 8 үзүүлэлт дээр маш хангалтгүй хэмжээнд байна. Ядуу өрхийн хувь өндөр гарахад ундны усны найдвартай эх үүсвэр, ариун цэврийн нөхцөл байдал, гэр, байр, орон сууцны шалны материал, хоол унд хийх түлш хамгийн их нөлөөлсөн байна. Өрхүүдийн 90-ээс дээш хувь нь ариун цэврийн нөхцөл байдал болон хоол унд хийх түлшний байдлыг илтгэдэг үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол 80-аас дээш хувь нь ундны усны найдвартай эх үүсвэр, гэр, байр, орон сууцны шалны материалын үзүүлэлтийн хувьд гачигдалтай байна.

Эдийн засгийн сайн сайхан байдлын боломжит хэмжүүрүүд

Олон хэмжээст ядуурлын индекс	Ядуу өрхийн эзлэх хувь (H)	Ядуурлын дундаж эрчимжилт	Амьдралын сэтгэл ханамжийн дундаж утга
0.114	28.2%	40.6%	4.18

¹Олон хэмжээст ядуурлын индексийг тооцох аргачлалыг НҮБХХ-өөс гаргасан нийтлэг арга зүйд үндэслэн, Монгол Улсын онцлог нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулсан. Монгол улсын хувьд олон хэмжээст ядуурлын индексийг тооцоходоо эрүүл мэнд, боловсрол, амьдралын нөхцөл, аж байдлын баталгаат байдал гэсэн 4 хэмжээс, тэдгээрийг тодорхойлох 10 үзүүлэлтээр тооцсон. Мэдээллийн эх үүсвэрийн хувьд Үндэсний Статистикийн Хорооноос зохион байгуулан явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг ашигласан. Дэлгэрэнгүйг: 24-2.pdf (num.edu.mn), Микро мэдээллийн сан (nso.mn)



**ХЭРЭГЖИЖ БУЙ
ТӨСЛҮҮД**

“ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Японы Хүүхдийг Ивээх Сан

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Итгэлцлийн Сан

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Суурь судалгааны зорилго нь “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх юм. Ингэхдээ (1) төслийн ахиц, үр нөлөөг үнэлж болохуйц төслийн зорилгын шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг тодорхойлох; болон (2) төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөгдсөн үйл ажиллагааны цар хүрээ болон боломжит үр нөлөө, төслийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Зорилтот дүүрэг тус бүрийн холбогдох тоон болон чанарын судалгааны мэдээллээр төслийн зорилгын зорилтот хоёр шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих,
- Зорилтот 5 дүүргийн төр, иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) ажилтнууд хохирогч төвтэй, гэмтлийн дараах сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх аргачлалыг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай эсэхийг судлах,
- Сургуулийн удирдлага, багш, сурагчид жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тухай, охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг багасгахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендерийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие бие хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, хохирогч-төвтэй арга зүйн талаар, үйлчилгээ үзүүлэгчдээс цаг тухайд нь тусламж, үйлчилгээ авах, сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой эсэхийг судлах,
- 12-18 насны охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, чиглэлд дараах үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн эсэх, хаанаас тусламж авахаа мэддэг болсон (цахимаар болон биеэр) талаар чанарын болон тоон судалгаа хийх зэрэг зорилтууд багтаж байна.



2021 11-р сар

2022 3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Японы Хүүхдийг Ивээх Сан нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Итгэлцлийн Сангийн санхүүжилтэйгээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг 2021-2024 оны хооронд “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн түвшин доогуур 5 дүүргийн 12-18 насны охидыг COVID-19 цар тахлын хүчин зүйлийн улмаас хүндэрсэн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах гэсэн

жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх замаар охидын эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх үндсэн зорилготой юм. Энэхүү төслийн хүрээнд IRIM Судалгааны хүрээлэн нь “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгааг хэрэгжүүлж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгаа нь үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн ба үүнд доорх дүрсэд үзүүлсний дагуу тоон болон чанарын судалгаа багтсан болно.

Бүрэлдэхүүн 1: Тоон судалгаа

CAPI аргыг ашигласан 15 зорилтот сургуулийн 664 сурагч охидоос судалгаа авсан.

Бүрэлдэхүүн 2: Чанарын судалгаа

Зорилтот байгууллагуудын мэргэжилтнүүдтэй 63 ярилцлага хийсэн.

Бүрэлдэхүүн 1. Тоон судалгаа

Тоон судалгааны түүврийг бүрдүүлэхдээ судалгааны баг захиалагч талын дэмжлэгтэйгээр зорилтот дүүргүүдийн сонгогдсон 15 сургуулийн захиргаатай хамтран ажилласан. Сургуулийн захиргаа болон холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдсоноор зорилтот сурагчдыг тодорхойлж урьдчилан тооцсон түүврийн тооцооллын дагуу уулзаж судалгаа авах хуваарийг гарган ажиллав.

Суурь судалгааны тоон судалгаанд нийт 664 сурагч охид хамрагдсан. Тоон судалгаанд Computer Assisted Personal Interviewing (CAPI) буюу компьютерт суурилсан биечлэн мэдээлэл цуглуулах аргыг ашигласан.

Бүрэлдэхүүн 2. Чанарын судалгаа

Чанарын судалгааны түүврийг бүрдүүлэхдээ жендерт суурилсан хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг

голлохоролцогчталууд болох төрийн байгууллагын албан хаагчид, хамтрагч болон үйлчилгээ үзүүлэгч иргэний нийгмийн, олон нийтэд түшиглэсэн, төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдийг сонгон авч судалсан. Мөн зорилтот 15 сургуулийн 14-17 насны сурагч охид болон хохирогч болсон охидыг холбогдох байгууллагууд, сургуулиудын нийгмийн ажилтнуудтай хамтран сонгон авч чанарын судалгаанд хамруулсан.

Чанарын судалгааны хүрээнд кейс судалгаа, фокус бүлгийн ярилцлага, голлох мэргэжилтний ярилцлага, хагас бүтэцлэгдсэн ярилцлага, баримт бичгийн шинжилгээний аргуудыг ашиглан нийт 63 ярилцлагыг оролцогч талуудтай хийсэн.

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бэлтгэх явцад хэрэгжиж байгаа ба 2022 оны 3 сард эцсийн үр дүнг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээнд худал, ташаа мэдээлэлтэй та хэр их таардаг вэ?

Нас	Вөдөр бүр, асвал бараг өдөр бүр	7 хоногт хэд хэдэн удаа	7 хоног бүр	Тийм их биш	Тааралдаж байгаагүй
Нийт	24%	18%	12%	9%	22%
18-35	31%	24%	13%	8%	18%
36-55	21%	14%	11%	10%	25%
56+	11%	8%	9%	10%	24%
Хүйс					
Эрэгтэй	27%	19%	13%	9%	19%
Эмэгтэй	21%	16%	11%	9%	24%
Байршил					
Хот	27%	20%	12%	9%	20%
Хадгас	18%	14%	11%	9%	24%

Эх сурвалж: Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Уг судалгааны зорилго нь (1) засгийн газрын талаарх иргэдийн сэтгэл ханамж, (2) сонгогдсон албан тушаалтнуудын хариуцлагатай байдал, (3) эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо, (4) засгийн газрын ерөнхий гүйцэтгэлийн талаарх олон нийтийн санаа бодлыг судлах юм. Үүний хүрээнд төслийн баг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Захиалагч талаас санал болгосон арга зүй, асуумж хэрэглэгдэхүүнийг туршиж, сайжруулах үйл явцыг хариуцан зохион байгуулах
- Зорилтот орон нутгуудад мэдээлэл цуглуулах төлөвлөгөө гарган, утсан судалгааны дата санг дотоод мэдээллийн сангаас бүрдүүлж бэлтгэх
- Дуудлагын төвийг ашиглан Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс 2500 өрхийг түүвэрлэн утсаар мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгуулах
- Цугларсан мэдээллийг зориулалтын программд оруулж, чанарын шаардлага хангасан дата сан үүсгэн захиалагчид хүлээлгэн өгөх
- Мэдээлэлд шинжилгээ хийж, түүний үр дүнд суурилан Аналитик тайлан бэлтгэх
- Судалгааны үр дүнг бүрэн тусгасан танилцуулга (PPT)-ыг бэлтгэн захиалагчид хүлээлгэн өгөх




2021

01-р сар

2022

6-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)-ийн Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (БНОУХ)-ийн захиалгаар гүйцэтгэж буй “Олон нийтийн санаа бодлын судалгаа-2022” нь ардчилал, хүний эрх, улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлын талаар ард иргэдийн санал бодлыг тандах зорилготой хийгдэж буй цуврал судалгаануудын нэг юм. Захиалагч байгууллага болох БНОУХ нь ардчилал, эрх чөлөө, олон нийтэд тулгуурласан хөгжил болон эрх зүйт ёсыг дэлхий дахинаа хөгжүүлэхийн төлөө ажилладаг байгууллага бөгөөд дэлхийн олон оронд энэ сэдвээр судалгаа, нөлөөллийн ажлуудыг гүйцэтгэдэг. Тус байгууллагаас өмнөх 2020, 2021 онуудад зохион байгуулсан олон нийтийн санаа бодлын судалгаанд мөн IRIM судалгааны хүрээлэн хамтран ажилласан. Судалгааны үр дүн, мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байршсан бөгөөд БНОУХ-ийн веб хуудаст хандан танилцах боломжтой.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг судалгаа нь нэг цаг хугацаанд өргөн хүрээг хамрах буюу “хөндлөн үргэлжлэх” (cross-section) дизайнтай байна. Үндэсний түвшний судалгаагаар засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг олон нийтийн санаа бодлоор тодорхойлох (descriptive) зорилготой судалгаа юм.

Судалгаанд оролцогчдын харьцааг төслийн саналд тусгасан (хот 69%, хөдөө 31%) хэвээр хадгалж мэдээлэл цуглуулалтын ажлыг 2022 оны 3 сараас 4 сарыг дуустал үндэсний түвшинд зохион байгуулж байна.

ҮР ДҮН

IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн мэдээлэл цуглуулах шатанд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд үр дүн, тайлан бэлтгэх шатад оролцохгүй болно.

2021 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгийн танилцуулгатай дараах холбоосоор нэвтэрч танилцах боломжтой.

https://www.iri.org/wp-content/uploads/legacy/iri.org/mongolian_public_opinion_poll_final.pdf

“COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН БҮСИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ НЬ” ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨСӨЛ



SUB CENTER
ULANBAATAR URBAN SERVICES
AND RURAL AREAS DEVELOPMENT
INVESTMENT PROGRAM

ADB

ASIAN DEVELOPMENT BANK



Эх сурвалж: IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Хөгжлийн Банк

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгдүгээр үе шатны Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн зорилтот хороодын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тэднийг дэмжихэд төслийн гол зорилго оршино. Үүний тулд дараах 3 зорилтыг хангана. Үүнд:

- Зорилтот хороодын бичил, жижиг, дунд бизнесүүдийн хэрэгцээг тодорхойлох
- Зорилтот хороодын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесүүдийн хэрэгцээнд нийцсэн чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- Зорилтот хороодын бичил, жижиг, дунд бизнесүүдэд бодит дэмжлэг үзүүлэх



2021

5-р сар

2022

4-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот:

СХД-ийн 7, 8, 9, 10, 28, 40-р хороо

ЧД-ийн 14, 18-р хороо

СБД-ийн 13, 14-р хорооны бизнес эрхлэгчид

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” (УБХГХХОДХ) төслийг 9 жилийн хугацаанд 3 үе шаттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд гэр хороололд инженерийн суурь дэд бүтэц болон нийгмийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг ажлыг гүйцэтгэж, 6 дэд төвийг байгуулах юм.

Ингэснээр Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон зохисгүй төвлөрлийг сааруулж, нийгмийн болон хотын үйлчилгээг жигд хүртээмжтэй болгоход туслах юм. Мөн хөтөлбөрийн нөлөөллөөр Улаанбаатар хотод амьдрах нөхцөл сайжирч, амьдрах таатай орчин, өрсөлдөх чадвар бүхий тэгш оролцоог хангасан дэд төвүүдийн сүлжээ Улаанбаатар хотын гэр хорооллуудад бий болно. Хөтөлбөрөөс үндсэн 4 үр дүн гарна: (1) тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын

холболт сайжирна; (2) зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ; (3) дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна; (4) хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавх бэхэжнэ. Төслийн 1-р үе шат буюу Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажил дуусаж байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудаас гадна дэд төвүүдийн иргэдийн оролцоог хангах, чадваржуулах үйл ажиллагаанууд хэрэгжиж байна. Энэ хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүсийн орчмын бичил, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид (БЖДБЭ)-ийг чадавхжуулснаар тэдний амьжиргаа, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхэд үр нөлөө үзүүлэх техник туслалцааны төслийг IRIM судалгааны хүрээлэн, Би Эф Эй Эс ХХК (BFAS), Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн ментор клуб (WEMC) байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна.


ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн ерөнхий зорилгын хүрээнд 3 үр дүнд хүрэхийг зорьсон. Үүнд:

1. БЖДБЭ-н бизнесийн үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ
2. Зорилтот хороодын БЖДБЭ-н мэдлэг, чадавх нэмэгдэх
3. Зорилтот хороодын БЖДБЭ тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэх

Хүрэх үр дүн 1 - БЖДБЭ-н бизнесийн үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ:

Дэд төв орчмын бүсийн БЖДБЭ-ийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийснээр үр дүнд үндэслэн дараагийн арга хэмжээнүүдийг тодорхойлох байв. Тиймээс энэ ажлын хүрээнд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан Баянхошуу, Сэлбэ дэд төв орчмын 276 БЖДБЭ-ээс мэдээлэл цуглуулсан. Мөн бизнес эрхлэгчтэй хамтран ажилладаг төр, олон улсын төсөл хөтөлбөр, банк санхүүгийн байгууллага зэрэг 16 төлөөлөгчтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Судалгаанд хосолмол дизайны арга ашиглан дараах хүрээнд мэдээлэл цуглуулав.



Хүрэх үр дүн 2 - Зорилтот хороодын БЖДБЭ-н мэдлэг, чадавх нэмэгдэх: Судалгааны үр дүнд тулгуурлан сургалтын сэдвийг тодорхойлон, сургалтын агуулгыг бэлтгэн нийт 84 удаагийн сургалт, 4 удаагийн санхүүгийн байгууллагатай танилцах аялал, 3 удаагийн сургагч багш бэлтгэх сургалтууд төлөвлөж, үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнээс гадна сургалтын хугацаанд өдөр тутам 2 дэд төвд менторууд ажиллаж БЖДБЭ-ийг шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.


Хүрэх үр дүн 3 - Зорилтот хороодын БЖДБЭ тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэх: Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тулгуурлан БЖДБЭ-дэд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн хэрэгцээг судалсан. Үүний үр дүнд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах юм. БЖДБЭ-ийн бизнесийн

нөхцөл байдлыг судалснаар тэдэнд тохирсон сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, үнэлгээний хороо байгуулан тоног төхөөрөмжийн дэмжлэг хүссэн БЖДБЭ-ийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдэж байна.

ҮР ДҮН

Төслийн эхний 2 зорилт болох БЖДБЭ-ийн хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээнд суурилсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагаа хэрэгжиж дууссан. Харин 3 дахь зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй тоног, төхөөрөмжөөр дэмжих үйл ажиллагаа үргэлжлэн хэрэгжиж байна. Тиймээс төслийн эцсийн үр дүнгүүд харахан гараагүй, түүнийг үнэлэх ажлууд хийгдэхээр төлөвлөж байна.

“ХАМТДАА УНШИЦГААЯ” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



Эх сурвалж: Unsplash

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Уг судалгаа нь Азийн Сангийн “Хамтдаа уншицгаая” санаачилгын хүрээнд хэрэгжих төсөл, кампанит ажлуудын үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжихэд шаардлагатай суурь мэдээллийг цуглуулах үндсэн зорилготой. Энэхүү судалгаагаар 0-5 насны монгол хүүхдийн номд дуртай байдал, гэр бүл дэх хүүхдэд зориулсан номын хүртээмж, ном уншихын ач холбогдол, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгөх дадлыг тодруулахад чиглэсэн.



2021

11-р сар

2022

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын 9 дүүрэг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2021 оны есдүгээр сард Азийн Сангаас хүүхдүүддээ ном уншихыг сурталчлах, боловсролын үр дүнг сайжруулах зорилгоор “Хамтдаа уншицгаая” санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү санаачилга нь монгол хэл дээрх чанартай хүүхдийн номын хүртээмжийг нэмэгдүүлэх, насанд хүрэгчдэд бага насны хүүхдүүдтэй ном унших хэвшлийг бий болгоход чиглэсэн цогц хөтөлбөр юм. Энэхүү санаачилга нь эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн номыг бага насны хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал “хэрэгсэл” болгон ашиглахад туслах зорилготой юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан зохион байгуулсан. Тоон судалгаанд Улаанбаатар хотын сонгогдсон сургууль, цэцэрлэгийн 0-5 хүүхдүүдийн 834 эцэг, эхчүүдийг хамруулав. Харин чанарын судалгаанд Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Боловсролын газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, дүүргүүдийн боловсролын хэлтэс, цэцэрлэг, сургуулийн удирдлагуудын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Суурь судалгааны мэдээллийг төслийн эцсийн үнэлгээний үр дүнтэй харьцуулагдахуйц байхад тохиромжтой, цаг хугацааны давтамжтай загварыг сонгосон.

Цаг хугацааны давтамжтай загвар



ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байгаа ба 2022 оны 4 сард эцсийн үр дүн гарахаар төлөвлөгдөөд байна.

Уг төслийн хүрээнд дараах үр дүнг гаргахаар ажиллаж байна. Үүнд:

- Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгдөг дадал, номд дуртай байдал
- Эцэг эх, асран хамгаалагчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын менежер, багш нарын хүүхдэд ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт мэдлэг
- Номын хүртээмжтэй байдал, бодлогын орчин, түүний хэрэгжилт
- Өрхүүд болон боловсролын байгууллагуудын сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, нийтлэг бэрхшээлүүд зэргийг тодорхойлохыг зорьж байна.

ҮР ДҮНД СУУРИЛСАН УДИРДЛАГА БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ СОЁЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

IRIM судалгааны хүрээлэн нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Үр дүнд суурилсан удирдлагын гарын авлага болон Үнэлгээний удирдамж (нийт 8 төрлийн баримт бичиг)-ийг Монгол хэл рүү орчуулж, нэр томъёоны тайлбар толь боловсруулна. Мөн НҮБ-ын харьяа байгууллагууд, хөгжлийн түншүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдэд уг баримт бичгүүдийг танилцуулах арга хэмжээ зохион байгуулах юм.




2022

1-р сар

2022

4-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улс

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Хүний эрх болон үр дүнд суурилсан удирдлага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС)-гийн бодлого хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, шийдвэр гаргалт болон хариуцлагын суурь стратеги нь болдог. Үнэлгээ, ялангуяа үнэлгээний соёл нь хариуцлагатай, үр дүнд хүрдэг, сайн засаглалыг бий болгох гол цөм нь юм. Тиймээс НҮБХС-ийн Үр дүнд суурилсан удирдлагын гарын авлага болон Үнэлгээний удирдамжийг Монгол хэл дээр орчуулж, нэр томъёоны тайлбар толь боловсруулах ажлыг эхлүүлсэн ба IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэж

байна. Энэхүү баримт бичгүүдийн орчуулгыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын мэргэжилтнүүдэд танилцуулна. Ингэснээр оролцогч талууд уг баримт бичгүүдийг эх хэл дээрээ ашиглах, хяналт-шинжилгээ үнэлгээний ажилдаа баримтлан ажиллах боломжтой болох юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн ажлын ерөнхий үе шатууд болон үйл ажиллагааг дараах зурагт харуулав.

Бэлтгэл

- Ажлын төлөвлөгөө гаргах
- Төсөлтэй холбоотой материалууд хүлээн авах
- Баримт бичгийн шинжилгээ хийх

Хэрэгжилт

- Баримт бичгүүдийг орчуулах
- Нэр томъёоны тайлбар толь боловсруулах








Төгсгөл

- Бүтээгдэхүүнүүдэд захиалагчаас санал авах, сайжруулах
- Оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах

ҮР ДҮН

Баримт бичгийн орчуулга болон нэр томъёоны тайлбар нь орчуулагдаж, боловсруулах шатандаа

явж байгаа бөгөөд төслийн баг дараах 8 баримт бичгийг орчуулж байна.



Уг баримт бичгүүд нь орчуулагдан гарснаар хяналт, шинжилгээ үнэлгээний талаарх ойлголтыг нэгтгэж, энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудын

өргөнөөр хэрэглэдэг гарын авлага болно гэдэгт бид итгэлтэй байна.

МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АВСАН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТӨСӨЛ

+ IFRC



Эх сурвалж: MRCS

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо
Монголын Улаан Загалмай Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Уг төсөл нь 2020 оны 2 сараас 2022 оны 1 сарын хооронд МУЗН-ээс цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээний явц, үр дүн, ололт амжилтыг үнэлж, цаашид хэрэгжүүлэх цар тахлын дараах нөхөн сэргээх хөтөлбөрийн үйл ажиллагааны санал, зөвлөмж боловсруулах зорилготой.



2022 1-р сар

2022 5-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Ховд аймгууд болон Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монголын Улаан Загалмай Нийгэмлэг (МУЗН) нь эрүүл мэндийн салбарыг дэмжих, эмзэг бүлгийн иргэдэд туслах зорилгоор үндэсний хэмжээнд COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлж байгаа билээ. Уг арга хэмжээний хүрээнд төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, Улсын Онцгой Комисс болон бусад

сүлжээ байгууллагуудын гишүүний хувиар Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.

МУЗН-ийн хариу арга хэмжээ нь дараах үндсэн 3 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд зохион байгуулагдсан байна.

МУЗН-ийн Ковид-19-ийн эсрэг хариу арга хэмжээний үндсэн 3 үйл ажиллагааны чиглэл

Чиглэл 1:
Эрүүл мэнд, ус
ба эрүүл ахуй

Чиглэл 2:
КОВИД-19-ийн
нийгэм-эдийн засгийн
үр нөлөөг бууруулах

Чиглэл 3:
Үндэсний
нийгэмлэгийг
чадавхжуулах

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээний төслийн ерөнхий хүрээг гаргахдаа ажлын даалгаврын дагуу доорх 5 шалгуур үзүүлэлтийг ашигласан.

Үнэлгээний хүрээ



Арга зүйн хувьд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулж баримт бичгийн судалгаа, асуулга, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, кейс судалгаа зохион байгуулж байна. Тоон судалгаанд COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд МУЗН-ээс тусламж хүртсэн үр шим хүртэгчид болон МУЗН-ын сайн дурын ажилтнууд хамрагдах бол чанарын судалгаа төрийн байгууллагын төлөөлөл, МУЗН-ын ажилтнууд зэрэг бусад оролцогч талуудыг хамарна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

МУЗН-ийн COVID-19 цар тахлын эсрэг үндсэн 3 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд зохион байгуулагдсан хариу арга хэмжээний үр дүнг судалгаагаар тогтоох юм.

Энэхүү төсөл нь жилийн тайлан гарах явцад хэрэгжиж байсан ба 2022 оны 5 сард үр дүн, дүгнэлт эцэслэгдэнэ.